**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 03 өдөр Дугаар 45 Есөнбулаг сум

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 92.2 хувьтай үнэлж, “*Үр дүн гарсан*” гэж дүгнэсүгэй.

2.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт дутуу арга хэмжээний хэрэгжилтийг ханган, холбогдох хөгжлийн бодлогын баримт бичигт тусган ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Чинбат)-д даалгасугай.

ДАРГА Л.НАСАНБУЯН

2025010192

**АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН**
**2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ /өссөн дүнгээр/**

2025.11.25 Есөнбулаг

| № | Арга хэмжээ-ний дугаар | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв сая.төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | Түвшин | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| **НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ** | | | | | | | | | |
| **Зорилго 1. Алтайчуудын бахархал, үнэт зүйлийг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэн, Нийгмийг соён гэгээрүүлнэ.** | | | | | | | | | |
| **Алтайчуудын бахархал, эв нэгдэл** | | | | | | | | | |
| **Зорилт 1.1. Алтайчуудын бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ.** | | | | | | | | | |
| 1 | 1.1.1. | Алтай нутгаас төрөн гарсан төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэдийг алдаршуулж, бахархлыг сэргээж, эх оронч үзлийг төлөвшүүлнэ. | ОНТ-50.0 | Аймгаас төрөн гарсан төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэдийг алдаршуулсан тоо | 2020 | 0 | 20 | Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ой, сумдын 100 жилийн ойн хүрээнд аймгаас төрөн гарсан төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэдийг алдаршууллаа. Төрийн 14 байгууллага, 1 гудамжийг алтай нутгаас төрөн гарсан төр нийгмийн зүтгэлтний нэрэмжит болголоо. Алдартны танхимыг 11 сум, 1 тосгоны Соёлын төвд байгууллаа. Аймгаас төрөн гарсан төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэдийг алдаршуулах уулзалт хэлэлцүүлэг 12, үзэсгэлэнг 16 удаа зохион байгууллаа. Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Ц.Лоохуузын мэндэлсний 100 жилийн ойн хүрээнд орон нутгийн төсвөөс 50.0 сая төгрөгийн баримтат киноны зураг авалтыг 2025 оны 10 сард хийлээ. Нэрт соён гэгээрүүлэгч, орчуулагч, зохиолч, яруу найрагч М.Цэдэндоржийн нэрэмжит “Хуурын эгшиг-2025” яруу найргийн наадмыг “Алтайн бахархал” сэдвийн хүрээнд 3 үе шаттай зохион байгуулж, 41 яруу найрагч оролцлоо. Нэрт соён гэгээрүүлэгч, МЦ-ын Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн Л.Түдэвийн мэндэлсний 90 жилийн ойг тохиолдуулан баримтат нэвтрүүлгийн зураг авалт хийж, Жангар номын санд “Хүндэтгэлийн танхим” байгуулан, “Дурсамж” уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж 200 гаруй хүн хамрагдлаа. Мөн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд Л.Түдэвийн зохиол бүтээлээс уран унших “Уран жиргээ” уралдаанд 40 сурагч оролцож, эхний 5 байрыг шагнаж урамшууллаа. | |
| 2 | 1.1.2 | Түүх, байгалийн түүхэн дурсгалт газар, ан амьтдыг түшиглэн зорилтот аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно. | | Шинээр бий болсон бүтээгдэхүүн | 2020 | 0 | 2 | Түүх, соёл, байгалийн түүхэн дурсгалт газрыг түшиглэн "Жангар фестиваль"-ийг 4 удаа зохион байгуулж нийт 5000 гаруй залуучуудыг хамруулла. Ээж хайрхан уул-Эхийн элбэрэл аялал, Энергийн төв - Ээж хайрхан ууланд хүслээ даатгах, сакура (буйлс) цэцэглэхийг үзэх зорилтот аяллыг 2022 оноос хойш 4 дэх жилдээ зохион байгуулж 9800 жуулчин хамрагдлаа. Олон улсын “Тахь” групптэй хамтран Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн ховор, нэн ховор амьтад болон өвөрмөц байгалийг түшиглэсэн 5 удаагийн аялал зохион байгуулж 35 жуулчин хамрагдлаа. | 100 |
| **Өв соёл, ёс заншил** | | | | | | | | | |
| **Зорилт 1.2**. **Монгол ахуй, өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлж, соёлын биет болон биет бус өвийг хойч үе хүүхэд, залуучуудад өвлөн уламжлуулна.** | | | | | | | | | |
| 3 | 1.2.1 | Өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ. | УТ 30,0 | Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн хангамж, мэргэжлийн түвшний хангалт | 2020 | 61.5 | 90 | Соёлын салбарт нийт 210 албан хаагч ажиллаж байгаагаас 181 буюу 86,2 хувь нь мэргэжлийн албан хаагч байна. | 90 |
| 4 | 1.2.2 | Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон хүмүүжил, төлөвшилд чиглэсэн | - | Хандлага, хүмүүжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаанд хамрагдсан хүүхэд | 2019 | 78.3 | 95.0 | Хүүхдийн хандлага, хүмүүжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаанд 51 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 14100 хүүхэд, "Эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр", "Би монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд жил бүр 8 зорилтот арга хэмжээг төлөвлөн 28 сургууль, 31 цэцэрлэг, МБС, АШУҮИС-ийн хэмжээнд хэрэгжүүлж, 1000 гаруй багш, ажилтан албан хаагчид болон 12000 гаруй суралцагч хамрагдлаа. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйл ажиллагааг цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 5 | 1.2.3 | Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, төрлийг өргөжүүлж, соёлын өвийн бүртгэл, мэдээлэл, хадгалалт хамгаалалт, сурталчилгааг нэмэгдүүлж, нутгийн онцлогийг илэрхийлсэн соёл урлагийн нэрийн /брэнд/ ажил үйлчилгээг бий болгоно. | УТ 30,0 | Соёл, урлагийн брэнд үйлчилгээ | 2020 | 0 | 2 | Монголын эртний уран зохиолын ноён оргил гэгдэх "Жангар" баатарлаг тууль хайлах “Туульсын хаан Жангар” эвент арга хэмжээг 3 удаа зохион байгуулж Монгол Улсын оюуны өмчид “Алтайн Жангарчид” албан ёсны бүртгэлтэй боллоо.<br>Алтай нутгийн өв соёл, уламжлал, бахархлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулагдаж буй бүх албан ёсны арга хэмжээ, уулзалт, сургалт, хэлэлцүүлэг болон олон нийтийн арга хэмжээний нээлтийг “Алтайн магтаал”-аар эхлүүлдэг боллоо. | 100 |
| 6 | 1.2.4 | Гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэн удам угсаагаа мэдэх угийн бичиг хөтлөх иргэний үүргээ биелүүлэх ажлыг зохион байгуулна. | ОНТ 5,0 | Угийн бичиг хөтлөлтийн хувь | 2020 | 21 | 60 | Угийн бичиг хөтлөлтийн ач холбогдлыг таниулах 235 удаагийн сургалт зохион байгуулж 12748 насанд хүрэгч, 1028 хүүхэд нийт 13776 хүн хамрагдлаа. Аймгийн хэмжээнд 16413 өрхийн 9924 өрх буюу 60,5 хувь угийн бичгээ хөтөлж байна. | 100 |
| **Монгол хэл, бичиг** | | | | | | | | | |
| **Зорилт 1.3.Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.** | | | | | | | | | |
| 7 | 1.3.1 | Монгол бичгийн дунд болон урт хугацааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагад Монгол | УТ 30,0<br>ОНХС 25,6 | Монгол хэл, бичиг арга хэмжээний хэрэгжилт | 2020 | 0 | 60 | Монгол улсад анхны хос бичигтэн аймаг боллоо. “Үндэсний хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх тухай аймгийн Засаг даргын А/68 тоот захирамж, 2021 оны 01 тоот албан даалгавар гарган жил бүр арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүллээ. Үүний дүнд 18 сумд хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөл байгуулж, үндэсний бичгийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, эх хэлний боловсролыг дээшлүүлнэ. | | | | | | хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр 2021-2025 онд нийт 200 гаруй төрлийн ажлыг орон нутагтаа зохион байгуулсан бөгөөд аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт 24 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж 15 арга хэмжээг зохион байгуулж төлөвлөгөөний биелэлт 80 хувьтай байна. | |
| 8 | 1.3.2 | Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. | | Монгол бичгийг төрийн албан хэрэгцээнд нэвтрүүлсэн байгууллага | 2020 | 0 | 40 | Аймгийн төрийн 172 албан байгууллага албан хэргийг хос бичгээр хөтөлж хэвшлээ. | 100 |
| **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | | | |
| **Зорилго 2.Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж, хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн, эрүүл дадал хэвшилтэй, нийгмийн идэвхтэй, эрүүл хүнийг хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| **Эрүүл мэнд** | | | | | | | | | |
| **Зорилт 2.1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тасралтгүй хүртээмжтэй, чанартай хүргэх үр дүнтэй тогтолцоог нэвтрүүлнэ.** | | | | | | | | | |
| 9 | 2.1.1 | Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай авах чадавхыг бүрдүүлнэ. | | Хүн амын дундаж наслалт | 2019 | 70.37 | 71.2 | Аймгийн хүн амын дундаж наслалт 2024 онд 73.14 болж, 1,3 жилээр нэмэгдлээ. | 90 |
| | | | | Төрөлтийн нийлбэр коэффициент (нэг эмэгтэйд ногдох) | 2019 | 3.1 | 3.3 | Нөхөн үржихүйн насны буюу 15-49 насны 1 эмэгтэйд ногдох төрөлтийн нийлбэр коэффициент 2021 онд 3.0, 2022 онд 2.5, 2023 онд 2.5, 2024 онд 2.2 байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин | 2019 | 14.6 | 10.3 | Нялхсын эндэгдэл 2021 онд 23 тохиолдол бүртгэгдэн 17.7, 2022 онд 14 тохиолдол бүртгэгдэн 13.4, 2023 онд 11 тохиолдол бүртгэгдэн 11.2, 2024 онд 12 тохиолдол бүртгэгдэн 13.9, энэ оны 10 сарын байдлаар 8 тохиолдол бүртгэгдэн 11.7 промиль болж, суурь түвшин 2019 оноос 2.9 промилиор буурсан үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдэл бодит тоогоор 2019 онд 20 байсан нь 2024 онд 12 болж бууруулсан, амьд төрсөн хүүхэд 2019 онд бодит тоогоор 1368 байсан бол 2024 онд 862 болж 506-аар буурсан нь 1000 амьд төрөлтөд тооцох түвшин өндөр үзүүлэлттэй гарахад нөлөөлж байна. Энэ нь төрөлт буурсантай холбоотой.<br>Нялхсын эндэгдлийн тохиолдолд нярайн эндэгдэл 2021 онд 69.5%, 2022 онд 85.7%, 2023 онд 63.6%, 2024 онд 25%, 2025 оны 10 сарын байдлаар 50%-ийг эзэлж байна. Үүнд:<br>-Нэгдсэн эмнэлэгт төрсөн ≤30-39 долоо хоногтой дутуу бага жинтэй төрсөн нярайд сурфактант эмчилгээ хийснээр 2021 онд 75%, 2022 онд 50%, 2023 онд 83.3%, 2024 онд 90%, 2025 оны 10 сарын байдлаар 83.3% нь үр дүнтэй боллоо.<br>-Нялхас буюу 0-1 хүртэлх насны гэрийн эргэлтийн хамралтыг 2021 онд 70.1%, 2022 онд 72%, 2023 онд 82.1%, 2024 онд 74.7%, 2025 оны 10 сарын байдлаар 73.2%-д хүргэлээ. | |
| | | | | 1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа | 2019 | 0.0 | 0.0 | 2021, 2022, 2024, 2025 онуудад эхийн эндэгдэлгүй, 2023 онд эхийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдлээ. Жирэмсний эхний 3 сартайн хяналт 2021 онд 92.5, 2022 онд 89.3, 2023 онд 94.0, 2024 онд 94.1, 2025 оны эхний 10 сарын байдлаар 94.7%-тай байна.<br>"Говь-Алтай аймгийн 80+" Эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд эх барихын тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эх баригч нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ажил мэргэжлийн уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж, 28 эх баригч оролцож, 71,0 сая төгрөгийн урамшуулал олголоо. | |
| | | | | Товлолт дархлаа-жуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь | 2019 | 99.3 | 99.5 | Заавал хийх товлолт дархлаажуулалтад 2021 онд 21800 хүүхдийн 94.4%, 2022 онд 18581 хүүхдийн 98%, 2023 онд 17861 хүүхдийн 97.3%, 2024 онд 16254 хүүхдийн 96.3%, 2025 оны эхний 10 сарын байдлаар 15270 хүүхдийн 96.7%-тай хамрагдсан байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь | 2019 | 77.4 | 79.4 | Тус эрт илрүүлгийн үзлэгт 2021 онд 36251 хүнээс 47.6%-ийг хамруулж шинээр 251, 2022 онд 34503 хүнээс 54.7%-ийг хамруулж шинээр 155, 2023 онд 35376 хүнээс 61.2%-ийг хамруулж шинээр 256, 2024 онд 33823 хүнээс 72%-ийг хамруулж шинээр 405, 2025 оны 10 сарын байдлаар 34286 хүнээс 52.4%-ийг хамруулж шинээр 172 өвчлөл оношилж хяналтад авч эмчилгээнд хамруулсан. Артерийн даралт ихсэх өвчний хамрагдалтын зорилтот түвшнээс бага байгаа нь эрт илрүүлгийн зорилтот нас 2021 оноос 18 болж өөрчлөгдөж хамрагдвал зохих хүн амын тоо нэмэгдсэн, эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой байна. | |
| | | | | 10,000 хүн амд вирусТ гепатитын өвчлөл | 2019 | 1.7 | Суурь үзүүлэлтээс дээшгүй | 2021 онд 4 тохиолдол бүртгэгдэж 0.7, 2022 онд 3 тохиолдол бүртгэгдэж 0.5, 2023 онд тохиолдол бүртгэгдээгүй, 2024 онд 1 тохиолдол бүртгэгдэж 0.2, 2025 оны 10 сарын байдлаар 1 тохиолдол бүртгэгдэж 0.2 байна.<br>Вируст гепатитын өвчлөлөөс урьдчилан сэргийлж 2021-2025 оны 10 сарын байдлаар дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.Үүнд:<br>-Сайн дурын В вирусийн эсрэг вакцины 1 болон 2 дугаар тунд 506 хүнийг хамруулсан.<br>-“А” вируст хепатитын эсрэг товлолын дархлаажуулалтад хамрагдах 1 нас 2 сартай, 2 насны 8793 хүүхдийн 8608 буюу 97.9%-ийг хамруулсан.<br>-Шинээр ажилд орсон эмнэлгийн ажилтан бүрийг “В” вирүсийн эсрэг дархлаажуулалтын I тунд 95.8%, II тунд 100% бүрэн хамруулж, В вирусийн дархлал тогтцын шинжилгээг 495 эмнэлгийн ажилтанд хийснээс дархлал тогтоогүй 121 ажилтан элэгний вирус илрүүлэх шинжилгээнд хамрагдаж В вирусын эсрэг 1,2-р тунд хамрагдлаа.<br>-Шинээр жирэмсний хяналтад орсон 4072 эхээс 3871 буюу 95%-ийг элэгний “В”, “С” вирус илрүүлэх шинжилгээнд хамруулахад 121 буюу 3.1% нь В, 20 буюу 0.5% нь С вирустай оношлогдож дараагийн шатны эмчилгээ шинжилгээнд хамруулан хяналтад авч ажиллалаа.<br>-Жил бүрийн 7 сарын 28-ны өдөр Дэлхийн Гепатиттай тэмцэх сэргийлэх өдрийн хүрээнд “Халдварт гепатитаас урьдчилан сэргийлэх” талаар сургалт хийж 11070 хүнд, сурталчилгаанд 14209 хүнийг хамруулсан.<br>-Сар бүр ХӨСҮТ-д вирус гепатитын цочмог болон архаг халдвар, үр дагавар, эхээс хүүхдэд дамжих халдварын мэдээг 23 нэгжүүдээс авч нэгтгэн өгч хэвшлээ. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тавт вакцины 3 дахь тунгийн хамрал -тын хувь | 2019 | 98.6 | Суурь үзүүлэлтэ эс доошгүй | 2021 онд 1001 хүүхдийн 99.8%, 2022 онд 959 хүүхдийн 97.7%, 2023 онд 969 хүүхдийн 95.7%, 2024 онд 811 хүүхдийн 98%, 2025 оны 10 сарын байдлаар 613 хүүхдийн 97.3% нь хамрагдлаа. Тавт вакцины 3 дахь тунгийн хамрагдалт зорилтот түвшинд хүрэхгүй байгаа нь хүүхдийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байна. | |
| 10 | 2.1.2 | Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг дадал болгон сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна. | | 2-12 насны хүүхдийн шүдний өвчлөлийн тархалтын хувь | 2019 | 80 | 40 | Шүдний эмчийн үзлэг, эмчилгээнд 2021-2024 онуудад 2-12 насны хүүхдийн 25.3%, 2025 оны 10 сарын байдлаар 64.3%-ийг хамруулсан байна.<br>11 сумын эрүүл мэндийн төвд 2-12 насны, аймгийн төвийн 3 сургуулийн 6-12 насны хүүхдийн дундах шүдний өвчлөлийн судалгаа хийхэд шүдний цоорлын хувь 78.4 байна.<br>Амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.Үүнд:<br>-Бугат, Бигэр, Дэлгэр, Дарив, Чандмань, Хөхморьт эрүүл мэндийн төвүүдэд шүдний сувилагчийн орон тоог шинээр батлууллаа.<br>-“Хүүхдийг ивээх сан”-гаас Чандмань сумын эрүүл мэндийн төвд шүдний тоног төхөөрөмж нийлүүллээ.<br>-ДЭМБ-ийн 34,0 сая төгрөгийн санхүүжилтээр ЭМЯ, Нийслэлийн эрүү, нүүр, шүдний төвтэй хамтран 2024 онд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 4-7 дугаар ангийн 200 хүүхдийн дунд “Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн”-ийг анх удаа зохион байгууллаа.<br>-Боловсролын газартай хамтран 2024 онд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмч нар 12 цэцэрлэгийн 423, 9 сургуулийн 478 хүүхдийг үзлэгт хамруулан өвчилсөн шүдийг эрүүлжүүлэх зуны даалгаврыг хүүхэд, асран хамгаалагч, ангийн багш нарт өглөө.<br>-Сургуульд суурилсан 1-р ангийн хүүхдийн шүдний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэг 2025 оны хагас жилд зохион байгуулагдаж аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 26 сургуулийн 1145 хүүхдээс 1112 буюу 97.1%-ийг хамруулснаас 636 буюу 57.2%-д нь шүдний өвчлөл бүртгэгдэж, 656 хүүхдийн 5-6 шүдийг эрүүлжүүллээ.<br>-Нэгдсэн эмнэлгийн шүдний кабинет, анхан шатны 4 эрүүл мэндийн төв, аймгийн явуулын эмнэлэг, Улаанбаатар хотын хувийн 3 эмнэлэг 6 сумд ажиллаж амны хөндийн эрүүл мэндийн тусламж үзүүлж, эмчилгээ хийлээ. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь | 2019 | 73.1 | 75 | 2021 онд 17448 хүний 70.8%-ийг хамруулж шинээр 12, 2022 онд 22345 хүний 61.3%-ийг хамруулж шинээр 4, 2023 онд 22588 хүний 69.7%-ийг хамруулж шинээр 27, 2024 онд 22688 хүний 81%-ийг хамруулж шинээр 92, 2025 оны 10 сарын байдлаар 22846 хүний 62.9%-ийг хамруулж шинээр оношлогдсон 46 хүнийг тус тус хяналтад авч эмчилгээнд хамрууллаа. Чихрийн шижингийн эрт илрүүлгийн хамрагдалт зорилтот түвшнээс бага байгаа нь 2022 оноос зорилтот нас 35 болж өөрчлөгдөж хамрагдвал зохих хүн амын тоо нэмэгдсэн, эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой байна. | |
| | | | | Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь | 2019 | - | 70.0 | 2021 онд 33.7%, 2022 онд 27.1%, 2023 онд 42.8%, 2024 онд 53.1%, 2025 оны 10 сарын байдлаар 52.5%-ийг хамруулсан. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын үзлэг 2022 оны 5 сараас улс орон даяар эхлэн явагдсан бөгөөд улсын хэмжээнд хамрагдалт 50.9% буюу хамрагдалтын хувь бага байгаа нь хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтад нөлөөлж байна. Хавдрын эрт илрүүлгийн хамрагдалтыг дотор нь задалбал:<br>-Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт 2021 онд 30-аас дээш насны 4090 хүний 41%, 2022 онд 4010 хүний 32.3%, 2023 онд 3867 хүний 28.3%, 2024 онд 3853 хүний 51.1%, 2025 оны 10 сарын байдлаар 3906 хүний 42.8%-ийг<br>-Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 2021 онд 30-60 насны 14407 хүний 5244 ба 46.0%, 2022 онд 11438 хүний 60.8%, 2023 онд 11325 хүний 81.4%, 2024 онд 11646 хүний 88.6%, 2025 оны 10 сарын байдлаар 11004 хүний 71%-ийг<br>-Элэгний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 2021 онд 40-65 насны 14879 хүний 50.0%, 2022 онд 16446 хүний 42.4%, 2023 онд 16274 хүний 59,6%, 2024 онд 18646 хүний 70.2%, 2025 оны 10 сарын байдлаар 16363 хүний 52.5%-ийг<br>-Ходоод, улаан хоолойн хавдрын эрт илрүүлэгт 2022 онд 35-аас дээш насны 25847 хүний 16%, 2023 онд 30.3%, 2024 онд 21203 хүний 41.5%, 2025 оны 10 сарын байдлаар 21203 хүний 56.1%-ийг<br>-Уушгины хавдрын эрт илрүүлэгт 2022 онд 18-аас дээш насны 37720 хүний 13.2%, 2023 онд 37493 хүний 36.8%, 2024 онд 37245 хүний 43.9%, 2025 оны 10 сарын байдлаар 37245 хүний 46.6%-ийг<br>-Түрүү булчирхайн хавдрын эрт илрүүлэгт 2022 онд 18-аас дээш насны 18459 хүний 9.1%, 2023 онд 18459 хүний 33.1%, | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 2024 онд 18287 хүний 35.5%, 2025 оны 10 сарын байдлаар 17896 хүний 42.9%-ийг тус тус хамруулсан. Сүүлийн 5 жилийн хугацаанд ходоодны 93, улаан хоолойн 37, элэгний 199, уушгины 40, түрүү булчирхайн 3, умайн хүзүүний 19, хөхний хорт хавдар 20 нийт 411 хорт хавдар оношлогдсоны 276 буюу 67.2% эрт үедээ, 135 буюу 32.8% хожуу үедээ оношлогдсон байна. | |
| | | | | Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь | 2019 | 99.7 | Суурь үзүүлэлтэ эс доошгүй | 2021 онд 838 хүүхдийн 99.6%, 2022 онд 969 хүүхдийн 97.9%, 2023 онд 888 хүүхдийн 96.2%, 2024 онд 768 хүүхдийн 97.9%, 2025 оны эхний 10 сарын байдлаар 1395 хүүхдийн 98.8% байна. УГУ вакцины хоёр дахь тунгийн хамрагдалт зорилтот түвшинд хүрэхгүй байгаа нь "Ковид-19" цар тахал гарсан жилүүдээс хойш товлолын дархлаажуулалтын хамрагдалт буурах хандлагатай байгаад иргэдийн вакцинд эргэлзэх байдалтай холбоотой байна. | |
| 11 | 2.1.3 | Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна. | УТ 280,0 | 1.Нэмэгдүүлсэн тусламж, үйлчилгээний нэр төрөл<br>2. Нэгдсэн эмнэлгийн тогтолцоонд шилжсэн байгууллага | - | 1,15 | 2 | Уламжлалт анагаах ухааны төв нь 2021 онд MNS 5700:2020 стандартын дагуу Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн тогтолцоонд шилжин үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд 2021 онд 2, 2022 онд 2, 2023 онд 2, 2024 онд 1, 2025 оны 10 сарын байдлаар 3 буюу нийт 10 эмчилгээг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүллээ.<br>Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд 3, 2022 онд 5, 2023 онд 10, 2024 онд 6, 2025 оны 10 сарын байдлаар 8 буюу 32 төрлийн шинэ технологийг амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна. | 100 |
| 12 | 2.1.4 | Яаралтай тусламжийн чанар хүртээмж, чадавхийг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ. | УТ 70,0<br>ОНХС 403,8<br>ХХО 750,0 | - | - | - | - | Аймгийн нэгдсэн эмнэлгийн "Хүлээн авах-Яаралтай тусламж-103" тасгийн бүтцийг 2022 онд шинэчлэн тогтоож, мэргэшсэн эмч 4, мэргэшсэн сувилагч 6 ажиллаж байна.<br>Харьяа 23 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн бэлэн байдал 88%, тоног төхөөрөмжийн хангалт 85%, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 90%-тай байгаа бөгөөд яаралтай тусламжийн сургалтад давхардсан тоогоор 180 эмч, 134 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.<br>2021-2025 онд 22 эрүүл мэндийн байгууллагад 31 автомашин нийлүүлэгдэж, нийт 26 эрүүл мэндийн байгууллагын 85 хувьд парк шинэчлэлт хийгдлээ.<br>2021 онд 11 сумын 39 багийн эмчийн унааг улсын төсвийн 70,0 сая төгрөгийн санхүүжилтээр, 2023 онд "Энх-Алтай" өрхийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | эрүүл мэндийн төвийн Наран багийн эмчийн мотоциклийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 3,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинэчиллээ.<br>2025 онд 11 сумын 16 багийн эмчийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 400,3 сая төгрөгийн санхүүжилтээр, 17 сумын 30 багийн эмчийг "Хан-Алтай" ресурс ХХК, "Цэн газар" ХХК, "Хос Кварц" ХХК, "Цэрдийн тал" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд 750,0 сая төгрөгийн санхүүжилтээр, нийт 18 сумын 46 багийн эмч буюу 58,9 хувийг PROBOX автомашинаар хангалаа. 2025 оны 12 сард 14 багийн эмчийг унаажуулна. | |
| 13 | 2.1.5 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлнэ. | - | - | - | - | - | Аймгийн нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, 17 сум, 2 тосгон, 3 өрхийн эрүүл мэндийн төв гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг 100% нэвтрүүлэн Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй гүйцэтгэлээр санхүүжих гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| 14 | 2.1.6 | Цахим үйлчилгээг өргөжүүлж, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ. | - | - | - | - | - | Зайн оношлогоогоор 2023 онд 11 удаа зөвлөгөө авч эмчилгээ хийсэн байна. Үүнд:<br>-Хүүхэд, нярайн тусламж үйлчилгээтэй холбоотой ЭХЭМҮТ-өөс 5, Монгол Японы эмнэлгээс 1, Сонгдо эмнэлгээс 1 нийт 7 удаа зөвлөгөө авч, дараагийн шатлалд илгээсэн 5, эдгэрсэн 2 үйлчлүүлэгч байна.<br>-Телемидцин буюу зайн оношлогоор зөвлөгөө аван эмчилгээ хийсэн 4 тохиолдол буюу Гэмтэл Согог судалын Үндэсний төвийн эмч нартай 2 удаа 1 үйлчүүлэгчийг тээвэрлэсэн ба Гэмтэл Согог судалын Үндэсний төвийн эмч нартай хамтран олон ясны хугаралын мэс заслыг хийсэн.<br>-Улсын клиникийн нэгдүгээр төв эмнэлгийн эмч нараас Шалтгаан тодорхойгүй хүнд хэлбэрийн цус багадалтай 2 үйлчлүүлэгчийн биеийн байдал, шинжилгээ, эмчилгээг танилцуулж зөвлөгөө аван ажиллаж эмчлэгдсэн.<br>Телемидицинээр 2024 онд гэмтэл согог судлалын эмнэлгээс 4, ХӨСҮТ-ээс 1, Улсын 3-р эмнэлгээс 1 нийт 6 удаа зөвлөгөө авч, эмчилгээг үргэлжүүлсэн 3, хагалгааны баг ирж тусламж үзүүлсэн 2, тээвэрлэн шилжүүлсэн 1 үйлчлүүлэгч байна. ЭХЭМТ-ийн зөвлөх эмчээс нийт 10 жирэмсэн эхэд зөвлөгөө авч лавалгаа 3 дугаар шатлалын эмнэлэгт 8 тохиолдлыг илгээсэн байна.<br>Аймгийн нэгдсэн эмнэлэгт 2025 онд PACS системийг нэвтрүүлж, тус системээр дүрс, бичлэгийн 3000 мэдээлэл | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | 2.1.7 | | | | | | | дамжуулагдаж хадгалагдсан бөгөөд телемедицинээр Улсын гуравдугаар төв эмнэлгээс 1 удаа зөвлөгөө авч, ХӨСҮТ-ээс 2, ГССҮТ-ээс 3 удаа нийт 5 удаа зөвлөгөө авч, 8 удаагийн хурал зохион байгуулж, 26 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 5 удаагийн зайн сургалтад 21 хүн хамрагдлаа. | |
| 15 | 2.1.7 | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын цахим тогтолцоог нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | - | - | - | - | - | 2021 онд 32 нэрийн 66,9 сая төгрөгийн, 2022 онд 87 нэрийн 88,4 сая төгрөгийн, 2023 онд 91 нэр төрлийн 141,2 сая төгрөгийн, 2024 онд 102 нэрийн 249,3 сая төгрөгийн, 2025 оны 10 сарын байдлаар 108 нэрийн 347,0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн цахим худалдан авалтыг хийлээ. Цахим тогтолцоонд шилжсэнээр эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ сүүлийн 3 жилийн хугацаанд тогтвортой байна. 2021 оноос нэр төрлийг 76-аар нэмэгдүүллээ. | 100 |
| 16 | 2.1.8 | Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | УТ 60,8<br>ОНТ 1.175,5<br>ОХНС 10,0<br>Хандив 23,5 | - | - | - | - | 2021-2025 онд төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад 181, гадаад улс болон дотоодод туршлага судалсан 40, ажлын байрны дадлагажуулах сургалтад 36, нийт 215 эмнэлгийн мэргэжилтэнг чадавхжуулахад улсын төсвөөр 60,8, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр 13,1, орон нутгийн төсвөөр 1,5, хандиваар 23,5, нийт 98,9 сая төгрөг зарцууллаа.<br>Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд дараах томоохон арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.Үүнд:<br>-2021 онд эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн төсвөөс 38.2 сая төгрөг,<br>-2022 онд коронавируст халдварын үед улаан бүсэд ажилласан 420 эрүүл мэндийн ажилтанд аймгийн гамшгийн сангаас 84,0 сая төгрөгийн урамшуулал, 22 эрүүл мэндийн ажилтанд орон нутгийн төсвөөс 1,7 сая төгрөг,<br>-2023 онд 81 эрүүл мэндийн ажилтанд 810,0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг,<br>-2024 онд 88 баг, өрхийн эмчид нийт 132,0 сая төгрөг, ажил мэргэжлийн уралдаанд тэргүүлсэн 91 сувилагч, эх, баригч, тусгай мэргэжилтэнд 158,0 сая төгрөгийн урамшуулал тус тус олголоо. | 100 |
| 17 | 2.1.9 | Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан үйлчлүүлэгчдэд | УТ 18.427,3<br>ТХ 400,0<br>ОНХС 476,8 | - | - | - | - | 2021 онд Нэгдсэн эмнэлгийн ариутгалын шинэ барилгыг “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” төслийн 400,0 сая төгрөгийн санхүүжилтээр барьж 50 ортой төрөх эмнэлэгтэй холболоо.<br>Улсын төсвийн 585,0 сая төгрөгийн санхүүжилтээр үйлдвэрийн тоног төхөөрөмжөөр тоноглосон 40 тонн чингэлэг байрлуулан | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ээлтэй, аюулгүй, стандарт хангасан орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | хүчилтөрөгчийн бичил үйлдвэрийг байгуулж хүүхэд, гэмтэл, сэхээн, дотор, мэдрэл, мэс засал, яаралтай тусламж, сэтгэцийн тасгийг ханын хүчилтөрөгчийн системтэй холбон тусламж үйлчилгээ үзүүлж байна.<br>2023 онд Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг улсын төсвийн 2610,9 сая төгрөгийн санхүүжилтээр ашиглалтад оруулаа.<br>2024 онд Зооноз өвчин судлалын төвийн шинэ барилгыг улсын төсвийн 4377,8 сая, Баянтоорой тосгоны эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг улсын төсвийн 2446,5 сая төгрөгийн санхүүжилтээр ашиглалтад оруулаа.<br>2021 онд Уламжлалт Анагаах Ухааны Нэгдсэн эмнэлгийн их засварын ажлыг улсын төсвийн 207,9 сая, 2024 онд Чандмань сумын эрүүл мэндийн төвийн их засварыг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 476,8 сая, 2022 онд Алтай сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийг улсын төсвийн 250,0 сая, 2024 онд Нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийг улсын төсвийн 7949,2 сая төгрөгийн санхүүжилтээр тус тус хийж гүйцэтгэлээ.<br>2021-2025 онд нийт 2 их засвар, 2 өргөтгөл, 4 шинэ барилга баригдлаа. | |
| **Боловсрол** | | | | | | | | | |
| **Зорилт 2.2. Монгол хүний хүмүүжил, хэл, соёл, өв уламжлалаа эрхэмлэн, дээдэлсэн эрдэм мэдлэгтэй иргэн төлөвшүүлнэ:** | | | | | | | | | |
| 18 | 2.2.1 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 91 хувьд, ерөнхий боловсролын хамран сургалтыг 98.6 хувьд хүргэнэ. | - | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын үнэлгээ | 2019 | 81.9 | 91 | Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 2022 онд 81.9%, 2023 онд 82%, 2024 онд 86.2%, 2025 оны хагас жилийн байдлаар 87.8 хувьд хүрч сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, хамран сургалт тогтвортой нэмэгдэж байна.<br>Хувилбарт сургалт 18 цэцэрлэгт хэрэгжиж, үүнээс 17 цэцэрлэг мэргэжлийн багшийн орон тоогоор хангагдсанаар хувилбарт сургалтын багшийн хангалт 95 хувьтай байна.<br>Ерөнхий боловсролын хамран сургалт 2022 онд 84.7%, 2023 онд 85.8%, 2024 онд 86.2%, 2025 онд 88.1%-тай тогтмол өссөн үзүүлэлттэй байна.<br>Ерөнхий боловсролын хамран сургалт 2022 оноос 3.7 хувиар, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2022 оноос 5.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 90 |
| | | | - | Ерөнхий боловсролын хамран сургалтын үнэлгээ | 2019 | 95.8 | 98.6 | | |
| 19 | 2.2.2 | Ерөнхий боловсролыг тэгш хүртээмжтэй эзэмших боломж | ОНТ 19,9 | Сургалтын чанарын үнэлгээ | 2019 | 52.9 | 62.0 | Аймгийн Засаг даргын нэрэмжит анги нийтийн сорилгод 2024 онд 751 багшийг хамруулан 55.6%-тай, 2025 онд 59 төрлийн хичээлээр 755 багшийн давхардсан тоогоор 28000 сурагч | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ. | | | | | | оролцуулан зохион байгуулж 60.7%-ийн дундаж гүйцэтгэлтэй шалгагдсан байна.<br>Өмнөх оноос сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 91.1 болж 7.7 хувиар ахисан, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 90.3% болж 6.9 хувиар ахисан байна. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 79.4 болж 2.4 хувиар ахисан, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 83.9% болж 6.8 хувиар ахисан байна. Гүйцэтгэлийн үнэлгээний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгээр 2023 онд 50.4%, 2024 онд 60.1%, 2025 онд 64.4%-тай тогтмол ахицтай үнэлэгдсэн.<br>Элсэлтийн шалгалтын дундаж 2025 онд 510.1 оноонд хүрч улсад 9-р байранд эрэмбэлэгдэн, 2020 оноос 11 байраар урагшилсан амжилттай байна. Сургалтын чанарыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэн 2021-2025 онуудад нийт 7.2 тэрбум төгрөгийг боловсролын салбарт зарцуулсан байна.<br>Үр дүн: Нийт багш сурагчдаа хамруулан жил бүр зохион байгуулдаг анги нийтийн сорилго шалгалт болон гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээтэй харьцуулсан дүнгээр сургалтын чанарын үнэлгээ 62.55%-д хүрсэн байна. | |
| 20 | 2.2.3 | Боловсролын салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулна. | - | Багш нарын мэргэжлийн мэдлэгийн шалгалтын гүйцэтгэлийн хувь | 2019 | 63 | 72 | 2025 онд Ерөнхий боловсролын сургуулийн дунд ахлах ангийн 407 багшаас элсэлтийн шалгалтын агуулгаар шалгалт авч мэргэжлийн мэдлэгийн үнэлгээ тогтоосон. Тус үнэлгээгээр нийт багш нарын мэргэжлийн мэдлэгийн түвшин 62.05%-тай үнэлэгдсэн байна. Боловсролын салбарын хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор ажиллах хүсэлт гаргасан багш нараас мэргэжлийн мэдлэгийн шалгалт авч сургуулиудад дүн үнэлгээг хүргүүлж ажилласан. Үүнд 2024 онд 62 багш хамрагдаж 60.3%, 2025 онд 20 багш хамрагдаж 57.7%-ийн дундаж үнэлгээтэй шалгагдсан байна.<br>Багшийн нийгмийн баталгаа хангах чиглэлээр 2021 онд 103 багш, 2022 онд 149 багш удирдлага, 2023 онд 454 багш удирдлага, 2024 онд 1121 багш, удирдлага, 2025 онд 79 багш урамшуулалд хамрагдан боловсролын салбарт нийт 7.223,2 төгрөгийн хөрөнгө оруулалт, урамшууллыг зарцуулаад байна.<br>Сургуулийн өмнөх боловсролын багш нарын мэргэжлийн мэдлэг, арга зүй ур чадварын түвшин тогтоох 2 төрлийн үйл ажиллагаанд нийт 29 цэцэрлэгийн 146 багш хамрагдаж даалгаврын гүйцэтгэл 80%-тай үнэлэгдсэн байна. 2022 онд 10 судлагдахууны 425 багшаас мэргэжлийн мэдлэгийн шалгалт | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | авахад 74%-ийн дундаж үнэлгээтэй байсан.<br>Багш нарын мэргэжлийн мэдлэгийн шалгалт, арга зүй ур чадварын үнэлгээний гүйцэтгэлийн хувь 72.2% | |
| 21 | 2.2.4 | Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон хүмүүжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | Хандлага, хүмүүжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаанд хамрагдсан хүүхэд | 2019 | 78.3 | 95 | "Эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг аймгийн 28 сургууль, 31 цэцэрлэгт сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлж ажиллалаа. "Эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр", "Би монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд жил бүр 8 зорилтот арга хэмжээг төлөвлөн 28 сургууль, 31 цэцэрлэг, МБС, АШУҮИС-ийн хэмжээнд хэрэгжүүлж, 1000 гаруй багш, ажилтан албан хаагчид болон 12000 гаруй суралцагч (давхардсан тоогоор 30000-40000) хамрагдлаа. | 100 |
| 22 | 2.2.5 | Боловсролын салбарын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан, хүүхдэд ээлтэй сургалтын орчинг бүрдүүлнэ. | УТ-2042.9 | Стандарт, чанарын шаардлага хангасан хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 2019 | 71 | 95 | 2021-2025 онд аймгийн хэмжээнд Боловсролын салбарт 17 шинэ барилга баригдаж хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдсэн. Мөн шинээр улсын төсвийн хөрөнгөөр 15 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Эрдэнэт үйлдвэрийн санхүүжилтээр хийгдэж буй нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих төсөлд 4 ээлжийн 44 барилга хамрагдсанаас одоогоор 2,3,4 дүгээр ээлжийн 33 объектын ажил дуусаж ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Улсын төсвөөр 2021-2025 онд 307.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хатуу зөөлөн эдлэл нийлүүлсэн. Орон нутгийн төсвийн 2,861.4 сая төгрөгөөр ЕБС, СӨБ-ын 1032 багшийг 100% компьютержүүлж 630 таблет хүлээлгэн өгч сургалтын орчин сайжруулсан байна. 2025 оны Гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр аймгийн хэмжээнд сургалтын орчин бүрдүүлэлт СӨБ- 89.9%, ЕБС- 89.7%-тай үнэлэгдсэн.<br>Үр дүн: 31.5 тэрбум төгрөгөөр 17 шинэ барилга баригдаж, орон нутгийн төсвөөс 2.86 тэрбум төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 33 объектын ариун цэврийн байгууламжийг шинээр бий болгож нийт 61 сургалтын байгууллага 100% хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх бодлого үйл ажиллагаанд хамрагдсан байна. | 90 |
| 23 | 2.2.6 | Цахим сургалтыг хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөр, агуулга, хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан | - | Цахим сургалтад хамрагдалтын хувь | 2019 | 30 | 85 | ЭШ-2025 аяны хүрээнд цахим сорилгод 11138, цаасан суурьтай 1604 сурагч хамруулж, цахим болон танхимын 1558 цагийн давтлагад давхардсан тоогоор 20692 сурагч хамрагдлаа.<br>Гадаадад амьдарч байгаа 2, цэргийн албан хааж буй 1 суралцагч боловсрол нөхөн олгох цахим хөтөлбөрт хамрагдан | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | туршдаа суралцахуйг дэмжиж, орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | бүрэн дунд боловсрол эзэмшлээ. "Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг баталгаажуулах шалгалтад танхимаар 7, цахим хэлбэрээр 18 хүн нийт 25 иргэн хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэдтэй холбоотой олон улсын цахим сургалтад 18, мэдээлэл технологи, мэдээллийн аюулгүй байдал цахим ур чадвар сургалтад 300, сургууль, цэцэрлэгийн удирдлага, ёс зүйн дэд хороодын цахим сургалтад 450 гаруй багш, ажилтан шинээр батлагдсан хууль тогтоомжийг салбарын хэмжээнд сурталчлан таниулахад 700 гаруй албан хаагч, Моза боловсролын системийн танилцуулга цахим сургалтыг 480 багшид, дижитал платформ хичээл сургалтанд ашиглах сургалтыг 785 багшид, нийт давхардсан тоогоор 4748 хүнд цахим сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж хамрагдалтын хувь 100% байна. | |
| 24 | 2.2.7 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг хүүхэд, багшийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангана. | УТ 38,7 ОНХС 10,0 ХХО 15,0 | Тоног төхөөрөмж сургалтын хэрэглэгдэхүүний хангалт /Сургуулийн өмнөх боловсрол/ | 2019 | 60 | 85 | Улсын төсвөөр Боловсролын яам, Боловсролын ерөнхий газраас нөхөн хангалтаар 2021-2025 оны хоорон 128.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хатуу зөөлөн эдлэл нийлүүлсэн. Орон нутгийн төсвөөр СӨБ-ын 150 багшийг зөөврийн компьютержүүлж нийт сургалтын орчин сайжруулах зардалд 2,861.4 сая төгрөг зарцуулсан байна. 2025 оны Гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр аймгийн хэмжээнд сургалтын орчин бүрдүүлэлт СӨБ- 89.9%-тай үнэлэгдсэн. | 100 |
| | | | УТ 178,5 ОНТ 2.861,4 ОНХС 1.556,3 | Тоног төхөөрөмж сургалтын хэрэглэгдэхүүний хангалт /Ерөнхий боловсрол/ | 2019 | 62 | 85 | Улсын төсвөөр Боловсролын яам, Боловсролын ерөнхий газраас нөхөн хангалтаар 2021-2025 оны хоорон 178.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хатуу зөөлөн эдлэл нийлүүлсэн. Орон нутгийн төсвөөр 982 багшийг зөөврийн компьютержүүлж, 12 дугаар ангийн 630 хүүхдийг таблетаар ханган нийт сургалтын орчин сайжруулах зардалд 2,861.4 сая төгрөг зарцуулсан байна. 2025 оны Гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр аймгийн хэмжээнд сургалтын орчин бүрдүүлэлт ЕБС- 89.7%-тай үнэлэгдсэн. | |
| **Гэр бүл** | | | | | | | | | |
| **Зорилт 2.3.Нийгмийн бүх орчинд гэр бүл, хүүхэд, залуучуудын аливаа эрх зөрчигдөх, хүчирхийлэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, хариу үйлчилгээ үзүүлэн, хариуцлага ёс зүйтэй өсвөр үе, залуучуудыг төлөвшүүлэх орчин нөхцөлийг сайжруулна:** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | 2.3.1 | Хүүхэд, гэр бүл, залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зөвлөл, хороодын гишүүд, хүүхдийн төлөө ажиллагсдыг чадавхжуулан, арга зүйн дэмжлэг үзүүлж салбар дундын уялдаа холбоог хანган ажиллаа. | УТ-21,3 ОНТ-4,3 Төсөл хөт-17,0 | Салбар дундын ажилтнуудыг чадавхжуулсан сургалт | 2019 | 13 | 60 | Хүүхэд гэр бүлийн чиглэлээр төрөөс баримталж буй бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хангах, гэр бүлийн амьдралын чанарыг сайжруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, салбар дундын уялдаа холбоог сайжруулж хүүхэд, гэр бүлийн сайн сайхан байдлыг дэмжих зорилгоор “Хамтын шийдэл– хамгаалагдсан ирээдүй” арга хэмжээг 4 зорилтын хүрээнд 22 үйл ажиллагаа, 29 шалгуур үзүүлэлтийг тусган боловсруулж, Аймгийн ИТХ-ын 2025 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 37 дугаар тогтоолоор батлууллаа.<br>2021-2025 онд хамтарсан баг, хүүхдийн төлөө зөвлөл, эцэг эхийн зөвлөл болон мэргэжлийн удирдлагын байгууллагуудын албан хаагчдыг чадавхжуулах 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 2027 албан хаагч хамрагдлаа.<br>Хууль тогтоомжийг сурталчлах 96 удаагийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 80961 хүн хамрагдлаа. | 100 |
| | | | | Сургалтад хамрагдсан иргэн | 2019 | 2120 | 5000 | | |
| 26 | 2.3.2 | Эрх нь зөрчигдсөн хүүхэд, гэр бүл, залуучуудыг хариу үйлчилгээнд хамруулж, нөхөн сэргээх, хамгаалах олон талт цогц үйлчилгээг сум, багийн түвшинд үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | ОНТ-3.4 Төсөл хөтөлбөр-101.0 | Эрсдэлт нөхцөл дэх хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн хувь | 2019 | 58 | 90 | Хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх олон талт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2021 онд 18 төрлийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 11230 хүүхдийг хамруулсан бөгөөд эрсдэлт нөхцөл дэх 5686 хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүллээ.<br>2022 онд 23 төрлийн арга хэмжээнд 13416 хүүхдийг хамруулсан ба 5321 хүүхдэд, 2023 онд 28 төрлийн арга хэмжээнд 14548 хүүхдийг хамруулж, эрсдэлт нөхцөл дэх 235 хүүхдийг мэдээллийн санд шинээр бүртгэж, 4613 хүүхдэд, 2024 онд 33 төрлийн арга хэмжээнд 15289 хүүхдийг хамруулж, эрсдэлт нөхцөл дэх 225 хүүхдийг шинээр мэдээллийн санд бүртгэж, 4356 хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүллээ.<br>2025 онд 36 төрлийн арга хэмжээнд 18123 хүүхдийг хамруулж, эрсдэлт нөхцөл дэх 183 хүүхдийг мэдээллийн санд шинээр бүртгэсэн бөгөөд мэдээллийн санд энэ онд 921 хүүхэд бүртгэлтэй байна. Эрсдэлт нөхцөл дэх 3853 хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүллээ.<br>2021-2025 онд нийт эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн 91,3 хувьд хамгааллын үйлчилгээ үзүүллээ. | 100 |
| 27 | 2.3.3 | Өсвөр үе, залуучууд, гэр бүлийн сайн туршлагыг түгээн | Хандив тусламж-2.0 | Өсвөр үе хүүхэд залуучууд гэр бүлийн хөгжил | 2019 | 49 | 87.5 | 2021 онд аймгийн 30 хамтарсан баг гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 84 удаагийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэлгэрүүлэх, санал санаачлагыг дэмжих, хөгжил оролцоог хангасан орчинг бүрдүүлнэ. | | оролцооны арга хэмжээнд хамрагдсан хувь | | | | сургалтад 3712 хүн, 489 удаагийн нөлөөллийн арга хэмжээнд 20688 хүн хамрагдлаа.<br>2022 онд хүүхдийн хөгжлийн чиглэлээр 26 төрлийн уралдаан тэмцээн, арга хэмжээнд 3289, сургалт нөлөөллийн 48 арга хэмжээнд 14230, хамгааллын чиглэлээр 36 арга хэмжээнд 11160 хүүхэд, насанд хүрэгч хамрагдаж 39 төрлийн гарын авлага зөвлөмж материалыг тараалаа.<br>2023 онд 42 удаагийн сургалт мэдээллийн ажилд 20900 хүн 2952 хүүхдийг хамруулсан нь нийт хүүхэд залуучуудын 86,6 хувь нь хамрагдсан байна.<br>2024 онд хүүхдийн хөгжил оролцоог дэмжих, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан 14 төрлийн сургалт сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 3500, 34 нэр төрлийн тэмцээн, уралдаанд давхардсан тоогоор 1651 хүүхэд, дугуйлан, сургалтад 325 хүүхэд, тоглолт, драмын жүжигт давхардсан тоогоор 180 хүүхэд нийт 5656 хүүхэд хамрагдлаа.<br>2025 онд гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 85 удаагийн 17 төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулж, нийт 13260, хүүхдийн 12 төрлийн сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 9562 хүүхэд хамрагдаж 28 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулж нийт 1403 хүүхэд оролцлоо.<br>Дээрх 5 жилийн хугацаанд 898 удаагийн хөгжил оролцоо, сургалт нөлөөллийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 106812 хүүхэд, насанд хүрэгч хамруулсан ба хүүхэд өсвөр үеийнхний дунджаар 88 хувьд хүрч ажиллалаа. | |
| 28 | 2.3.4 | Хөгжилтэй андууд зусланг их засварт оруулан үйл ажиллагааг тогтмолжуулж, “Засагт ханы хот айл гэр зуслан”-г сум бүрт байгуулан хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлнэ. | - | Зусланд амрагчдын тоо | 2019 | 300 | 1500 | “Хөгжилтэй Андууд” зусланд 2022 онд “Хайрлагдсан Алтай” ТББ-аас 110 хүүхдийг 5 хоног, 2023 онд “Хантайшир бөхийн дэвжээ”-ний 113 хүүхэд 20 хоног бэлтгэл сургуулилтад хамрагдсан.<br>Хүүхэд багачуудыг монгол ёс зан заншил, нүүдэлчин ахуй, өв уламжлалаа өвлөн авах, сурч мэдэх, амьдрах ухаанд суралцуулах тэднийг хөгжил, оролцоогоор дамжуулан хамгаалах, хөгжүүлэх зорилгоор “Засагт ханы хот айл” гэр зусланг жил бүр ажиллуулж, 2021 онд 571, 2022 онд 636, 2023 онд 275, 2024 онд 245, 2025 онд 390, нийт 2117 хүүхдэд хөгжил оролцоог дэмжсэн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрийн дагуу 2024 онд Баянхонгор аймгийн “Өвгөн жаргалант” зусланд 192, 2025 онд “Өвгөн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | жаргалант" болон Завхан аймгийн "Даян" хүүхдийн зусланд 150 хүүхдийг амраалаа. | |
| **Биеийн тамир, спорт** | | | | | | | | | |
| **Зорилт 2.4. Нийтийн биеийн тамирыг хүн амын хэрэглээ болгон эрүүл аж төрөх дадалд хэвшүүлж, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулан олон улс, тив дэлхийд өрсөлдөх чадвартай тамирчдыг бэлтгэнэ:** | | | | | | | | | |
| 29 | 2.4.1 | Нийтийн биеийн тамираар хичээллэгч-дийн тоог нэмэгдүүлж, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдагсдын тоог ахиулна. | УТ-118.7 | Нийтийн биеийн тамираар хичээллэгчид | 2019 | 5272 | 6000 | Улсын хэмжээнд зохион байгуулагдсан "Эрүүл мэндийн цахим гүйлт-2021" арга хэмжээнд 3825 албан хаагч, иргэдийг хамруулж 89645 км зам туулан тэргүүн байранд шалгарлаа. "Дасгал хөдөлгөөн хийцгээе" сарын аянд 18 сумын 879 иргэн хамрагдаж 7298 км зам тууллаа.<br>"Цахим гимнастрада" биеийн тамирын арга хэмжээг амжилттай зохион байгуулж 7 төрөлд 83 багийн 1496 иргэн хамрагдлаа.<br>"Илүүдэл жингүй-Эртэч Монгол" арга хэмжээнд 9 дүүрэг, 21 аймгийн хэмжээнд 74 өдөр цахимаар зохион байгуулж, 18 сум, 27 байгууллагын 29393 хүн хамрагдлаа. Аяны хаалтын ажиллагаанд буухиа уралдаан болон дугуйн уралдааныг 2 насны ангилалаар зохион байгуулж нийт 354 иргэн хамрагдлаа "Хүн амын бие бялдар чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд" хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор 2021-2025 онд 84 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж 13645 иргэн хамрагдлаа.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53-р тоот зарлиг "Хүн амын бие бялдар чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил"-ын сарын аяныг жилд 2 удаа 2021-2025 онд нийт 9 удаа зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд сорилд хамрагдах 3-64 насны 49351 иргэн хамрагдахаас 17947 иргэн буюу сорилд хамрагдах нийт иргэдийн 36.4 хувийг хамруулснаас 52.56 хувь нь АВС үнэлэгдлээ. Дээрх арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор нийт 67539 иргэн хамрагдлаа. | 100 |
| 30 | 2.4.2 | Спортын төрлүүдийг шинээр хөгжүүлж, тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ. | - | Спортоор тогтмол хичээллэгчид | 2019 | 785 | 800 | Шинэ тутам хөгжиж буй хөлбөмбөг, модон барилдаан, усанд сэлэлт, киркит, дартс, сагсан бөмбөг 3х3, пауэрлифтинг, аэробик, гимнастикийн анхан шатны сургалт, тэмцээн уралдааныг дэмжин холбоодуудтай хамтран ажиллаж байна.<br>Спортын төрлүүдийг шинээр хөгжүүлэх тогтмол хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэн ажиллаж байна. Хөлбөмбөг-243, модон барилдаан -16, спорт авиралт-46, усанд сэлэлт-61, дартс-216, аэробик, гимнастик-120, сагсан бөмбөг 3х3-65, пауэрлифтинг-38, нийт-805 тамирчин хичээллэж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | 2.4.3 | Биеийн тамир спортын заал, гадна талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | УТ 3.749,5 | Шинээр баригдсан спорт заал | 2020 | 20 | 35 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хантайшир сургалтын төв, 1,2,3 дугаар сургууль, Бугат, Дэлгэр, Хөхморьт, Тонхил, Жаргалан, Шарга, Эрдэнэ, Цээл сумын нийт 12 спорт заал, Хандив тусламжаар Хантайшир сургалтын төв. Нийт 13 заал ашиглалтад орсон. | 90 |
| | | | | Шинээр баригдсан биеийн тамирын гадна талбай | 2020 | 28 | 38 | Түмэн, Жаргалант, Оргил баг, Төв цэнгэлдэх хүрээлэн, Хаанбанкны 3х3, Ахуй үйлчилгээний ордон, 4-р сургууль, Ид шидийн орон, Дэлгэр сумын төв цэнгэлдэх, Шарга сумдад гадна биеийн тамирын талбай байгуулагдаж, хүртээмж нэмэгдлээ. | |
| 32 | 2.4.4 | Тамирчдыг бүс, улс, олон улсын уралдаан, тэмцээнд оролцуулж ур чадварыг нэмэгдүүлнэ. | - | Бүс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн тамирчид | 2020 | 65 | 260 | “Аваргыг аймагтаа” арга хэмжээг хэрэгжүүлэн өсвөр үеийн шигшээ баг спортын 10 төрлөөр (хөл бөмбөг, сагсан бөмбөг, жүдо, чөлөөт бөх, самбо, волейбол, хөнгөн атлетик, шатар, ширээний теннис, үндэсний бөх) 292 тамирчин бэлтгэж байна. Тамирчдыг бүс, улс, олон улсын тэмцээнд оролцуулах ур чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг жил бүр тогтмол спортын 15 төрлөөр (волейбол, сагсан бөмбөг, ширээний теннис, шатар, даам, таеквондо, жүдо, самбо, чөлөөт бөх, үндэсний бөх, хөнгөн атлетик, сагсан бөмбөг 3х3, хөл бөмбөг) зохион байгуулж 2021-2025 онд 12750 хүүхэд хамрагдлаа.<br>Баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнд спортын 5 төрлөөр 380 тамирчин оролцож алт-32, мөнгө-41, хүрэл-52, Улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 5 төрлөөр 642 тамирчин оролцож алт-14, мөнгө-16, хүрэл-37, Монголын улсын Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагддаг 5 удаагийн наадмуудад 561 тамирчин оролцож 6 алт, 14 мөнгө, 22 хүрэл медаль хүртлээ. Нийт медалийн тоо-278 | 100 |
| 33 | 2.4.5 | Усан спорт, чийрэгжүүлэлтийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, спортын хэрэглэл материал, тоног төхөөрөмжөөр хангаж, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | - | Усан спортоор хичээллэгчид | Суурь түвшин 0-с эхлэнэ. | - | 2000 | 2021 онд - 124, 2022 онд 667, 2023 онд 703, 2024 онд 912, 2025 оны 11 сарын байдлаар 842, нийт давхардсан тоогоор 3248 хүн усан бассейнаар үйлчлүүлсэн байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | 2.4.6 | Бүс, улсын аварга шалгаруулах тэмцээнийг аймаг орон нутагтаа 2-оос доошгүй удаа зохион байгуулна. | УТ 34,8 | Монголын бүх ард түмний их наадамд оролцогчид | 2016 | 825 | 1100 | Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны тэмцээнийг 2022 онд спортын 9 төрлөөр зохион байгуулж 716 тамирчин 248 багц медалийн төлөө өрсөлдлөө. Баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 48 тамирчин оролцсоноос волейболын эмэгтэй баг тамирчид тэргүүн байранд шалгарч шигшээ тэмцээнд оролцох эрхээ авч, наадмын шигшээ тэмцээнд спортын 13 төрөлд 116 тамирчин оролцсоноос 2 мөнгө, 4 хүрэл медаль хүртлээ.<br>Монголын бүх ард түмний спортын XVI их наадмын анхан шат аймгийн аварга шалгаруулах насанд хүрэгчдийн тэмцээнд спортын 10 төрлөөр 910 тамирчин, шигшээ тэмцээнд спортын 12 төрлөөр 75 тамирчин оролцож, 3 мөнгө, 5 хүрэл медаль хүртэж өмнөх наадмуудын амжилтыг ахиуллаа.<br>Монголын бүх ард түмний 2 удаагийн спортын их наадмын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг давхардсан тоогоор спортын 19 төрлөөр зохион байгуулж 1626 тамирчин, шигшээ тэмцээнд спортын 25 төрлөөр 191 тамирчин оролцож, нийт мөнгө-5, хүрэл-9 медаль хүртсэн амжилттай оролцлоо. Дээрх уралдаан тэмцээнүүдэд давхардсан тоогоор нийт 1865 тамирчин оролцлоо. | 100 |
| | | | УТ 38,9 | Хүүхдийн спортын их наадамд оролцогчид | 2019 | 2430 | 2600 | Монголын хүүхдийн спортын VII наадмын өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн спортын 12 төрлөөр зохион байгуулж 1734 тамирчин 809 багц медалын төлөө өрсөлдлөө. Наадмын шигшээ тэмцээн “НӨХӨРЛӨЕ, ХӨГЖЬЕ, ХАМГААЛЬЯ” уриан дор Баянхонгор аймагт зохион байгуулагдаж, спортын 12 төрлөөр 134 тамирчин оролцож алт-2, мөнгө-1, хүрэл-6 хүртлээ.<br>Монголын хүүхдийн спортын VIII их наадмын өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн спортын 15 зохион байгуулж, 2750 тамирчин оролцлоо. Наадмын шигшээ тэмцээн “МӨРӨӨДЛИЙНХӨӨ ТӨЛӨӨ ШУДАРГААР ӨРСӨЛДЬЕ” уриатай Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, спортын 12 төрлөөр 145 тамирчин оролцож, алт - 2, мөнгө-4, хүрэл-6 нийт 12 медаль хүртэж YII их наадмын амжилтаа ахиуллаа. Багийн дүнгээр 30 байгууллагаас 18, аймгуудын хэмжээнд 12-р байрт шалгарлаа.<br>Монголын хүүхдийн спортын 2 удаагийн их наадмын өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг давхардсан тоогоор спортын 27 төрлөөр зохион байгуулж 4484 хүүхэд хамрагдаж шигшээ тэмцээнд спортын 27 төрлөөр 279 тхмирчин оролцож алт-4, мөнгө-5, хүрэл-12 медаль хүртлээ. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | УТ 11,7 | Үндэсний спортын их наадамд оролцогчид | 2018 | 297 | 350 | Үндэсний спортын VII их наадмын анхан шатны тэмцээнийг аймгийн Засаг даргын 2022 оны А/128 дугаар захирамжийн дагуу өвлийн спортын 2, зуны спортын 7 төрлөөр зохион байгуулж 18 сумын 406 тамирчин оролцлоо. Шигшээ тэмцээнд 9 төрлөөр 91 тамирчин оролцож, 2 алт, 1 хүрэл медаль хүртэн, нийлбэр дүнгээр улсын хэмжээнд VI байранд шалгарч өмнөх наадмуудад гаргасан амжилтаа ахиуллаа. | |
| | | | - | Оюутны спортын их наадамд оролцогчид | 2017 | 500 | 600 | Монголын оюутны спортын их наадмын шигшээ тэмцээн 2024 оны 04 сард зохион байгуулагдаж 34 их дээд сургуулийн 2240 тамирчин спортын 10 төрлөөр өрсөлдлөө. Говь-Алтай аймгаас спортын 3 төрөлд 18 тамирчин оролцлоо. | |
| **Хүнд ээлтэй амьдрах орчин** | | | | | | | | | |
| **Зорилт 2.5. Эрүүл баталгаат орчныг бий болгоно:** | | | | | | | | | |
| 35 | 2.5.1 | Алтай хотын соёл амралтын хүрээлэнг өргөжүүлж, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг сайжруулна. | ОНТ-614.4 | Тохижуулсан цэцэрлэгт хүрээлэн | 2020 | 1 | 1 | Орон нутгийн хөгжлийн сангийн 264.4 сая төгрөгийн санхүүжилтээр Соёл, амралтын хүрээлэнд алсыг харагч, морин тойруулгын тоглоом суурилуулах ажлыг “Өнө гурван баян” ХХК, ёслол хүндэтгэлийн өргөө барих ажлыг 80.0 сая төгрөгөөр “Содон ресурс” ХХК-иуд хийж гүйцэтгэхээр тус тус гэрээ байгуулсан.<br>Алтай хотод улсын төсвийн 7068.9 сая төгрөгийн хөрөнгөөр 3500 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэнгийн барилгыг “Арвин бэлт” ХХК-иар 2020 оноос гүйцэтгүүлэн 2023.07.25-нд ашиглалтад оруулаа. | 100 |
| 36 | 2.5.2 | Есөнбулаг сумд “Хөгжлийн гудамж” төслийг хэрэгжүүлж, Алтай хотыг орчин үеийн хот болгох суурийг эхлүүлнэ. | | Алтай хотын явган замын урт, км | 2020 | 15.79 | 20 | Алтай хот анх удаа 3 болон 4 эгнээ хатуу хучилттай авто замтай боллоо. 2023-2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн 4,474.0 сая төгрөгөөр аймгийн төв талбайг тохижуулж, түүний дагуух Жанчивын гудамжийг 3 болон 4 эгнээ хатуу хучилттай автозам болгон өргөтгөж, явган зам, ногоон байгууламж, ус зайлуулах далд байгууламжийг цогцоор нь хийхээр зураг төслийг “Нью товер” ХХК, “Кадсүрвэй” ХХК-аар тус тус гүйцэтгүүлэн бүтээн байгуулалтын ажлыг Зэвсэгт хүчний 341 дүгээр цэргийн ангитай гэрээ байгуулж ашиглалтад оруулаа. Энтүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх авто зам, хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг Хөгжил хорооллын доод талаас 3,4 дүгээр гудамжинд хатуу хучилттай авто зам 1км, явган хүний зам 2км, Батсуурийн гудамжинд 800м авто зам болон 2,2 км явган зам, 6 автомашины зогсоол, Алтай сумд | 100 |
| | | | | Сумдын явган болон дугуй замын урт, км | 2020 | 4.56 | 9.12 | | |
| | | | | Алтай хотын гудамжны гэрэлтүүлэг, тоо | 2020 | 869 | 1738 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 800м авто зам 400м явган зам, Бигэр сумд 330м авто замын ажлууд тус тус хийгдсэн. Замын нийт урт 7,53км<br>Есөнбулаг сумын хэмжээнд шинээр цамхагт гэрэлтүүлэг 48, гудамжны гэрэлтүүлэг 172 ширхэг хийгдсэн байна. | |
| 37 | 2.5.3 | Стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлнэ. | | Алтай хотын хүүхдийн тоглоомын талбай | 2020 | 6 | 15 | Есөнбулаг сумын 8 багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг улсын төсвийн 194.7 сая төгрөгөөр “Эс Пи Эм интернэйшнл” ХХК, Хаан банкны 44.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Гоц-Азаа” ХХК Солонго хороололд 3х3 сагсан бөмбөгийн талбайн ажлыг, 1 дүгээр сургуулийн 1994 оны төгсөгчдөөс 35.0 сая төгрөгөөр 3х3 сагсан бөмбөгийн талбайг хийж хүлээлгэн өглөө.<br>Аймгийн ОНТ, сумын ОНХС-ийн нийт 339.3 сая төгрөгөөр Есөнбулаг сумын Жаргалант багийн 0.5 га талбайд хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх боломжтой цэцэрлэгт хүрээлэн бүхий тоглоомын талбай байгууллаа. Мөн 17 сум 2 тосгонд хүүхдийн тоглоомын талбайн ажил хийгдсэн. | 100 |
| | | | | Сум, суурин газрын хүүхдийн тоглоомын талбай | 2020 | 3 | 20 | | |
| 38 | 2.5.4 | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ. | - | - | - | - | - | Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа “Хүнсний хувьсгал хөдөлгөөн”, Засгийн газрын 36 дугаар тогтоолын хүрээнд 2023-2025 онд “Хүнсний аюулгүй байдал” аяныг зохион байгуулан төлөвлөгөөний дагуу 18 сумын 3400 гаруй иргэд, хүнсний үйлдвэр, хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгч нарыг хамруулан давхардсан тоогоор 14 удаагийн сургалтыг үе шаттайгаар чиглэл бүрээр зохион байгуулж, 43 төрлийн 6000 гаруй гарын авлага, зөвлөмж тарааж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, иргэд болон сургуулийн хүүхдүүдэд хэрэглээний баталгаат хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй хүнсний бүтээгдэхүүнээр үзүүлэн гарган шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхээс сэргийлэх талаар зөвлөгөө, мэдээлэл түгээлээ.<br>Төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг сумдын хүнсний худалдаа, хүнсний үйлдвэр, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр хийж, давхардсан тоогоор 180 иргэн, 252 аж ахуй нэгжийг хамруулан 944 зөрчил илрүүлэн 516 буюу 55 хувийг арилгуулан ажиллалаа.<br>Хүнсний аюулгүй байдлын талаар ойлголт, зөв дадлыг төлөвшүүлэх зорилгоор 10 төрлийн постерыг хийж цахим хаягуудаар түгээн, сумдын хүнс хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан хүнсний аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулан мэргэжил аргазүйгээр ханган ажиллалаа. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Есөнбулаг сумын хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 110 иргэн, аж ахуйн нэгжид "Хүнсний аюулгүй байдлыг хангах нь" сэдэвт салбарын сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. "Дэлхийн чанарын өдөр", "Тогооч нарын өдөр"-ийг тэмдэглэх ажлын хүрээнд "Хоолны илчлэг тооцох аргачлал", "Технологийн карт, бүтээгдэхүүний шошгыг хэрхэн зөв унших", "Сахарын хэрэглээ, зөв зохистой хооллолт" сэдэвт сургалт зохион байгуулж, сумдын сургууль, цэцэрлэгийн 70 гаруй тогооч хамрагдлаа. Мөн "Аяга таваг угаах 3 дамжлага", "Аюулгүй хоол хүнс үйлдвэрлэх 5 түлхүүрийн зарчим" гарын авлагаар хангалаа. | |
| 39 | 2.5.5 | Сум, суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж усалгаа, арчилгаа, хамгаалалтыг олон нийтийн оролцоотойгоор шийдвэрлэнэ. | - | Сум, суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ, га | 2020 | 86 | 100 | 2020 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 305,977 ширхэг мод тарьсан байсан. Сум, суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 2021 онд 30702 ширхэг, 2022 онд 52769 ширхэг, 2023 онд 80999 ширхэг, 2024 онд 45903 ширхэг, 2025 онд 93928 ширхэг мод тарьж 39 га талбайгаар нэмэгдүүлж, нийт талбай 125 га-д хүрсэн. Төв суурин газарт 18 төрлийн 261123 ширхэг, хамгаалалтын зурваст 84377 ширхэг мод, бут, сөөг тарих ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн жимс, жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд 2021 онд 47950 ширхэг жимсний мод, хамгаалалтын зурваст 11710 ширхэг мод, 2022 онд 12535 ширхэг мод, 2023 онд 9800 ширхэг мод хамгаалалтын зурваст 3000 ширхэг мод, 2024 онд 1874 ширхэг мод хамгаалалтын зурваст 4520 ширхэг мод тарьж нийт 91389 ширхэг жимсний мод, бут тарих ажлыг зохион байгуулж аймгийн хэмжээнд хамгаалалтын зурвас, ногоон байгууламж, жимсний мод нийт 556389 ширхэг байна. 2021-2025 онд нийт 1,394,389 ширхэг мод, бут, сөөг, заг тарих ажлыг хийж гүйцэтгэлээ. | 100 |
| 40 | 2.5.6 | Алтай хотын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | | Алтай хотын үерийн далан сувгийн урт, км | 2020 | 5.367 | 10 | Алтай хотын 10,8 км үерийн хамгаалалтын барилга байгууламжийн зураг төслийг "Эм Ти Эс гидро инженеринг" ХХК боловсруулсан. 2026 оны улсын төсөвт хөрөнгийг тусгалаа. Гамшгийн сангийн зардлаар 10,3 км үерийн түр даланг байгуулж, үерийн эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авлаа. | 100 |
| 41 | 2.5.7 | Сумдын шинэчлэл арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | УТ 5,464.5 ОНХС 526.6 | "Сумдын шинэчлэл-хөдөөгийн хөгжил" төсөл хэрэгжсэн сум | 2020 | 1 | 5 | Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн 5,464.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 сум ариутгах татуургын төв шугам сүлжээнд холбогдож, 8 сумд цэвэрлэх байгууламжийн барилгыг барьж, АОНХС-ийн 1676.0 сая төгрөгийн хөрөнгөөр Шарга, Баян-Уул сумдын цэвэрлэх | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгууламжийн ажлыг “Жи гоулд” ХХК гүйцэтгэж байна. Бугат сумын цэвэрлэх байгууламжийн ажил дуусч, ашиглалтад орсон. Баян-Уул, Шарга сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг 2025 оны 12 сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.<br>Хувийн хөрөнгө оруулалтаар Бигэр сумд 45 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулж, 120 айлын орон сууцны хорооллын дулаан дамжуулах төв, хорооллын доторх ус, дулаан хангамжийн барилга угсралтын ажлыг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 526.6 сая төгрөгийн хөрөнгөөр “Шатат” ХХК гүйцэтгэж, орон сууцны хорооллын гадна цахилгаан хангамжийн ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 147.7 сая төгрөгийн хөрөнгөөр “Хуруу цахир” ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан.<br>Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд сумдыг халаалтын зуух, төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, Баян-Уул, Тонхил сумыг ”Аураг даян” ХХК, Цогт, Чандмань сумыг “Хүрд хүч чадал” ХХК, Хөхморьт сумын ажлыг “Буман хаус” ХХК, Бугат сумын ажлыг “Гүн урлал” ХХК, Төгрөг сумын ажлыг “Энх өвгөдий” ХХК, Шарга сумын ажлыг “Агар галдай” ХХК, Халиун сумын ажлыг “Тэргүүлэн” ХХК ашиглалтад оруулж, сумдын төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүд, айл өрхүүдийг ус, дулаан хангамжид холбогдож, 17 сум нэгдсэн халаалтын системд холбогдлоо.<br>Улсын төсвийн 2,493.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бигэр сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилга угсралтын ажлыг “Сити агро эх” ХХК, Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамжийн төсөл /Говь-Алтай аймаг, Алтай сум/-ийн ажлыг улсын төсвийн 10,192.7 сая төгрөгийн хөрөнгөөр "Тунгалаг говь транс" ХХК, "Билгүүн од констракшн" ХХК-ийн түншлэл гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>Дээрх дэд бүтцийн ажлууд хэрэгжсэнээр хөдөөгийн 16 сум, 2 тосгон төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системд холбогдож байна.<br>Жаргалан сумын ариутгах татуургын шугам сүлжээний ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 459.5 сая төгрөгийн хөрөнгөөр “Дулаан проект” ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 30%-тай. | |
| **Шинжлэх ухаан, технологи, инноваци** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2.6 Шинжлэх ухаан, технологи инновацийг нутагшуулна.** | | | | | | | | | |
| 42 | 2.6.1 | Шинжлэх ухаан, технологи, инновацийн зөвлөл байгуулж, шинэ техник, технологийг нэвтрүүлнэ. | | Нэвтрүүлсэн инновацийн тоо | 2020 | 0 | 3 | Аймгийн засаг даргын 2022 оны 06 сарын 09-ний өдрийн А/348 захирамжаар шинжлэх ухаан технологийн салбар зөвлөлийг байгуулсан. Аймаг орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх төлөвлөгөөг гарган дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүллээ. “Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ 2022-2024 онд “Ээгий Ээмзи 2” нэртэй 2D анимэйшн төсөл арга хэмжээг байгалийн үзэсгэлэнт газар, ховор болон нэн ховор ургамал, ан амьтныг хүүхэд багачууд болон олон нийтэд таниулах, тэднийг хайрлан хамгаалахад анхаарал хандуулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, үндэсний уламжлал, соёл, ёс заншлыг хүүхэд багачуудад танин мэдүүлэх, төлөвшүүлэх, аймгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарын бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчиллаа. “Шинжлэх ухаан, технологи, инновацийг орон нутагт нутагшуулъя” аянг зохион байгуулж, 500 гаруй албан хаагчдыг хамруулан орон нутгийн үйлдвэрлэл, инновацийг дэмжих санал шийдлүүд гарсан. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Мобиком компанийн “smart education-4” төслийн санхүүжилтээр ерөнхий боловсролын IV сургуульд ухаалаг анги, БНСУ-ын хөрөнгө оруулалтаар нэгдүгээр сургуульд мэдээлэлзүйн ухаалаг танхимуудыг байгуулав. “Хүргэлт” арга хэмжээний хүрээнд нутгийн махны “Шимт богц брэнд”-ийг гарал үүсэл, танилцуулга мэдээлэл бүхий сав баглаа боодолтойгоор 18 сумын малчдын хотноос 270 гаруй тн махыг захиалга өгсөн 400 орчим иргэнд хүргэлээ.<br>Дрон кодчиллын сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зохион байгуулж, сургууль бүрийг сургалтын дроноор хангалаа. | 100 |
| **ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА** | | | | | | | | | |
| **Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг сайжруулна.** | | | | | | | | | |
| **Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес** | | | | | | | | | |
| **Зорилт 3.1.Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн “Иргэн бүрт орлого-Өрх бүрт өсөлт” арга хэмжээг зохион байгуулж, 1000-аас доошгүй байнгын ажлын байрыг шинээр бий болгож, ажилгүйдлийн түвшинг жилд дунджаар 0,5 хувиар бууруулна:** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | 3.1 | Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн “Иргэн бүрт орлого-Өрх бүрт өсөлт” арга хэмжээг зохион байгуулж, 1000-аас доошгүй байнгын ажлын байрыг шинээр бий болгож, ажилгүйдлийн түвшинг жилд дунджаар 0,5 хувиар бууруулна | - | Ажилгүйдлийн түвшин | 2020 | 15 | 12.5 | Ажилгүйдлийн түвшин 2021 онд 10.3, 2022 онд 10.7, 2023 онд 7.6, 2024 онд 6.6, 2025 оны 3-р улирлын байдлаар 3.5%-тай байна. | 70 |
| | | | | Шинээр бий болсон ажлын байр | 2020 | 622 | 1000 | Аймгийн хэмжээнд 2021-2025 онд шинээр нийт 3362 байнгын шинэ ажлын байр бий болсон байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд уулзалт, өдөрлөг, хэлэлцүүлгийг зорилтот бүлэг бүрээр зохион байгуулж, ажил олгогчдын талаарх мэдээллийг өгч ажилласнаар 2021 онд 530, 2022 онд 610, 2023 онд 599, 2024 онд 1010 байнгын ажлын байр шинээр бий боллоо. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 613 байнгын ажлын байр бий болсон байна. | |
| | 3.1.1 | Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ. | | Start up арга хэмжээнд хамрагдаж дэмжлэг авсан залуучууд | 2019 | 15 | 200 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2021-2025 онд 18-34 хүртэлх насны 76 залуучуудад ХЭДСангаас 580,0 сая төгрөгийн дэмжлэгийн олгож 18 ажлын байр бий болголоо. Үүнд:<br>-Start up арга хэмжээний хүрээнд 18-34 хүртэлх насны 18 залуучуудад 90,0 сая төгрөгийн дэмжлэгийг олголоо. Үүнд: 2021 онд 3 багийн 9 гишүүнд 30,0 сая төгрөг, 2022 онд 1 багийн 2 гишүүнд 10.0 сая төгрөг, 2023 онд 1 багийн 2 гишүүнд 10,0 сая төгрөг, 2024 онд 1 багийн 2 гишүүнд 10,0 сая төгрөг, 2025 онд 2 багийн 3 гишүүнд 30,0 сая төгрөгийг тус тус олгосон байна.<br>-Хувиараа хөдөлмөр эрхлэгч 25-34 хүртэлх насны 44 залуучуудад 36 сарын хугацаатай 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 410,0 сая төгрөгийг олголоо. Үүнд: 2022 онд 14 иргэнийг хамруулж 85,0 сая төгрөг, 2023 онд 11 иргэнийг хамруулж 110,0 сая төгрөг, 2024 онд 14 иргэнийг хамруулж 140,0 сая төгрөгийг, 2025 онд 5 иргэнийг хамруулж 75,0 сая төгрөгийг олголоо.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй 25-34 хүртэлх насны 14 залуучуудад 24 сарын хугацаатай 50 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 80,0 сая төгрөгийг олголоо. Үүнд: 2022 онд 8 иргэнд 32,0 сая төгрөг, 2023 онд 3 иргэнийг хамруулж 24,0 сая төгрөгийг, 2024 онд 3 иргэнийг хамруулж ХЭДСангаас 24,0 сая төгрөгийг тус тус олгосон байна. | |
| 44 | 3.1.2 | Өрхийн болон бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, үйл ажиллагааны | ОНТ-3,8 | “Алтайд үйлдвэрлэв” борлуулалтын төв | 2020 | 2 | 5 | Орон нутгийн баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрийн үнээр нэг дороос борлуулах зорилгоор “Алтайд үйлдвэрлэв” борлуулалтын төвийг 2018 оноос эхлэн тасралтгүй ажиллуулж байна. 2025 оны байдлаар | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтвортой байдлыг хангаж бизнес инкубатор төвийг бий болгоно. | | худалдааны сүлжээ | | | | “Алтайд үйлдвэрлэв” борлуулалтын 9 төвөөр 22 үйлдвэрлэл эрхлэгчдийн 50 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрийн үнээр худалдан борлуулж байна. Үүнээс 2 борлуулалтын төвийн түрээсийн төлбөрийг ХЭДСангаас хариуцан ажиллаж байна. Дээрх арга хэмжээнд ХЭДСАнгаас 28,6 сая төгрөг зарцууллаа. | |
| | | | ХЭДС-183,4 | Урамшуулалд хамрагдсан аж ахуй нэгж, байгууллага | 2019 | 10 | 40 | Зорилтот бүлгийн иргэдийг байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийг ухамшуулах замаар тэдний ажлын байрны тогтвортой байдлыг хадгалж байна. Дээрх арга хэмжээнд 2021-2025 онд зорилтот бүлгийн 36 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 25 байгууллагад ХЭДСангаас 215 сая төгрөг урамшууллыг олголоо. Үүнд: 2021 онд зорилтот бүлгийн 10 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 7 ААН байгуулагад 55,4 сая төгрөг, 2022 онд зорилтот бүлгийн 3 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 3 ААН байгуулагад 15,1 сая төгрөг, 2023 онд зорилтот бүлгийн 9 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 7 ААН байгуулагад 46,9 сая төгрөг, 2024 онд зорилтот бүлгийн 5 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 3 ААН байгуулагад 26,4 сая төгрөг, 2025 онд зорилтот бүлгийн 9 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 5 ААН байгуулагад 71,2 сая төгрөг байна. | |
| | | | ХЭДС-164.8 | Дэмжлэгт хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгчид | 2019 | 56 | 160 | Аймгийн хэмжээнд 2021-2025 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч 268 иргэнд ХЭДСангаас 2307,0 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатай 100 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй олголоо. Үүнд: 2021 онд 32 иргэнд 117,0 сая төгрөг, 2022 онд 44 иргэнд 280,0 сая төгрөг,<br>2023 онд 85 иргэнд 790,0 сая төгрөг, 2024 онд 57 иргэнд 570,0 сая төгрөг,<br>2025 онд 50 иргэнд 550,0 сая төгрөгийг олгосон байна. | |
| 45 | 3.1.3 | Малчдын ажлын байрны тогтвортой байдлыг хадгалж, орлогын эх үүсвэртэй болгоно. | ХЭДС-88.0 | Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрх | 2019 | 43 | 150 | Аймгийн хэмжээнд 2021-2025 онд 200 хүртэл толгой малтай 204 малчин өрх малжуулах арга хэмжээнд хамруулж ХЭДСангаас 1343,0 сая төгрөг зарцуулж, 21093 толгой малаар малжууллаа. Малыг төрлөөр нь авч үзвэл 4164 хонь, 16929 ямаа байна. Үүнд 2021 онд 20 малчин өрхийг хамруулж 92,0 сая төгрөг, /хонь 495, ямаа 904, нийт 1399/, 2022 онд 28 малчин өрхийг хамруулж 140,0 сая төгрөг, /хонь 440, ямаа 1587, нийт 2027/, 2023 онд 35 малчин өрхийг хамруулж 175,0 сая төгрөг, /хонь 352, ямаа 3020, нийт 3372/, 2024 онд 85 малчин өрхийг хамруулж 680,0 сая төгрөг, /хонь 2411, ямаа 7842, нийт 10253/, 2025 онд 36 малчин | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | өрхийг хамруулж, 256,0 сая төгрөг, /хонь 466, ямаа 3576, нийт 4042/ тоо толгой малаар малжуулсан. | |
| 46 | 3.1.4 | Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, амьжиргааг нь дээшлүүлнэ. | ХЭДС-696,0 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн | 2019 | 40 | 120 | Аймгийн хэмжээнд 2021-2025 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд нийт 123 иргэнийг хамруулж, ХЭДСангаас 696,0 сая төгрөгийг зарцуулсан. Үүнд: 2021 онд 18 иргэнд 56,0 сая төгрөг, 2022 онд 29 иргэнд 144,0 сая төгрөг, 2023 онд 27 иргэнд 176,0 сая төгрөг, 2024 онд 27 иргэнд 160,0 сая төгрөг, 2025 онд 22 иргэнд 160,0 сая төгрөгийг тус тус олголоо. | 100 |
| 47 | 3.1.5 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тоон судалгааг хийж, хөдөлмөрийн хөлс, урамшууллыг ажлын бүтээмжинд нийцүүлнэ. | ХЭДС-909,0 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэжээнд хамрагдсан ахмад настан | 2019 | 21 | 50 | Аймгийн хэмжээнд 2021-2025 онд Ахмад настанд олгох санхүүгийн дэмжлэгийн хүрээнд 162 иргэнд ХЭДСангаас 909,0 сая төгрөгийг олгосон. Үүнд: 2021 онд 13 ахмадад 25,0 сая төгрөг, 2022 онд 31 ахмадад 125,0 сая төгрөг, 2023 онд 25 ахмадад 125,0 сая төгрөг, 2024 онд 48 ахмадад 384,0 сая төгрөг, 2025 онд 45 ахмадад 250,0 сая төгрөгийг тус тус олголоо. | 100 |
| | | | ОНТ-84.4 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тоон судалгаа | 2019 | 1 | 1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.9.2, 29.9.3, 29.9.7, 29.9.9 дэх хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, шинэчлэх судалгааны ажлыг зохион байгууллаа. Судалгаанд аж ахуйн нэгж, байгууллага, албан бус хөдөлмөр эрхлэгч, малчин /200 хүртэл малтай/, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажилгүй иргэн хамрагдлаа.<br>Аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчийн судалгаа: Аймгийн хэмжээнд. 856 аж ахуйн нэгж байгууллагад 7657 ажилтан ажиллаж байна. Хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл Төсөвт байгууллага- 183, ХХК – 547, Хоршоо – 60, Нөхөрлөл – 16, Төрийн бус байгууллага -33, Холбоо- 6, Хувьцаат компани- 3, ОНӨААТҮГ-3, ТӨААТҮГ-5 байна.<br>Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн судалгаа: Аймгийн хэмжээнд нийт 746 албан бус хөдөлмөр эрхлэгч байна. Үүний 49.2 хувь нь буюу 367 эмэгтэй, 50.8 хувь нь буюу 379 эрэгтэй байна. Албан бус хөдөлмөр эрхлэгчийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл 12 хувь буюу 87 нь авто засвар, 3 хувь буюу 21 нь гутал үйлдвэрлэл, 14 хувь буюу 101 нь оёдлын үйлдвэр, 16 хувь буюу 119 нь хүнс үйлдвэрлэл, 56 хувь буюу 418 нь бусад байна<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний судалгаа: Хөгжлийн бэрхшээлтэй 2294 иргэн байна. Үүний 38.1 хувь буюу 876 нь эмэгтэй, 61.9 хувь буюу 1418 нь эрэгтэй байна. Нийт 2294 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 56.3 хувь буюу 1293 нь нийгмийн даатгалын сангаас, 43.7 хувь буюу 1001 нь нийгмийн халамжийн сангаас тус тус тэтгэвэр авч байна. Ажилгүй иргэдийн судалгаа: Аймгийн хэмжээнд 2348 ажилгүй иргэн, үүнээс 47.5 хувь буюу 1418 нь эмэгтэй байна. Бүртгэлтэй ажилгүй 837 иргэн, үүнээс 45.8 хувь буюу 384 эмэгтэй байна. Мэргэжил олгох танхимийн сургалтын судалгаа Ажил олгогч, ажилгүй иргэдийн мэргэжил олгох түр сургалтын эрэлт хэрэгцээний судалгааг зохион байгууллаа. Судалгааны дүнг нэгтгэн авч үзвэл хүнд машин механизмын оператор, оёдол эсгүүр, хүлэмжийн аж ахуйн сургалтад хамрагдах хүсэлтэй иргэд 51,2 хувийг эзэлж байна. | |
| 48 | 3.1.6 | Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тооллогыг зохион байгуулж,бүрт-гэл,мэдээллийг сайжруулна. | | Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тооллого, судалгаа | | - | 1 | Аймгийн хэмжээнд 746 иргэн албан бусаар хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс 49,2 хувь буюу 367 нь эмэгтэй байна. Байршлаар нь авч үзвэл 34,3 хувь Есөнбулаг, 6,7 хувь Цогт, 6,0 хувь Чандмань, 5,6 хувь Тонхил, 5,2 хувь Баян-Уул сумдад ажиллаж байна. Үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл 16 хувь буюу 119 хүнс үйлдвэрлэл, 14 хувь буюу 101 оёдол, 12 хувь буюу 87 авто засвар байна. | 100 |
| **Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл** | | | | | | | | | |
| **Зорилт3.2.Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдийн нийгмийн баталгаа, амьжиргааг дээшлүүлнэ:** | | | | | | | | | |
| 49 | 3.2.1 | Өрхийн амьжиргааны түвшинг шинэчлэн тогтоож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, халамж хүртэгч иргэдийн хүрээг багасгаж ядуурлыг бууруулна. | ОНТ-242,1 | Амьжиргааны түвшин доогуур өрх | 2019 | 3700 | 3200 | Өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх зорилгоор орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны ажлыг зохион байгуулан 2023 онд 335, 2024 онд 282, 2025 онд 1750, нийт 2367 өрхийг хамруулаа. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэдэд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2021 онд 682 өрхөд 484,792,0 мян, 2022 онд 533 өрхөд 367,344,0 мян 2023 онд 458 өрхөд 324,304,0 мян, 2024 онд 398 өрхөд 280504,0 мян, 2025 онд 373 өрхөд 222,632,0 мян нийт 1,679,576,0 мян төгрөгийн хүнсний бараа бүтээгдэхүүн олгосон байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд 2021 онд 56 иргэн 28 бүлэгт 42.0 сая төгрөг, 2022 онд 50 иргэн 25 бүлэгт 49,5 сая төгрөг, 2023 онд 36 иргэн 18 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүлэгт 36,0 сая төгрөг, 2024 онд 42 иргэн 21 бүлэгт 33,0 сая төгрөг, 2025 онд 35 иргэнд 81,6 сая төг, нийт 88 бүлгийн 211 иргэнд 242,1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулан өрхийн орлогыг нэмэгдүүлсэн байна. | |
| 50 | 3.2.2 | Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ. | - | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэн | 2020 | 25524 | 25000 | 2021 онд 29931 иргэнд 10.181,8 мянга, 2022 онд 30975 иргэнд 10.402,2 мянга, 2023 онд 31879 иргэнд 11.923,3 мянга, 2024 онд 26228 иргэнд 14.568,0 мянга, 2025 оны 10 дугаар сарын байдлаар 22891 иргэнд 12.942,0 мянган төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүллээ. | 100 |
| 51 | 3.2.3 | Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, даатгалын албан журмын болон сайн дурын даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлнэ. | - | Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин иргэд | 2020 | 3500 | 7200 | 2021 онд 3102, 2022 онд 3261, 2023 онд 3273, 2024 онд 3866 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдлаа.<br>2025 онд 3452 даатгуулагч сайн дурын даатгалд даатгуулсан. Үүнээс малчин 2594, энгийн болон 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эх, эцэг, хувиараа хөдөлмөр эрхлэгч 858 даатгуулагч байна. | 90 |
| 52 | 3.2.4 | Татварт бүртгэлтэй үйл ажиллагаа идэвхтэй явуулж буй аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлнэ. | - | Татварт бүртгэлтэй нийгмийн даатгалд шинээр бүртгүүлсэн ажил олгогчид | 2020 | 715 | 920 | 2021 онд 11 ажил олгогчийг шинээр нийгмийн даатгалд хамруулж, 704 ажил олгогч, 2022 онд 13 ажил олгогчийг шинээр хамруулж, 739 ажил олгогч, 2023 онд 38 ажил олгогчийг шинээр хамруулж, 707 ажил олгогч, 2024 онд 34 ажил олгогчийг шинээр хамруулж, 751 ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. 2025 онд 40 ажил олгогчийг шимтгэл төлөгчөөр бүртгэж 768 ажил олгогч тайлан гаргасан байна. | 90 |
| **Орлогод нийцсэн орон байр** | | | | | | | | | |
| **Зорилт3.3.Стандартын шаардлага хангасан хямд өртөгтэй орон сууцаар иргэдийг хангах бодлогыг хэрэгжүүлнэ:** | | | | | | | | | |
| 53 | 3.3.1 | Алтай хотын Солонго хорооллын инженерийн дэд бүтцийн угсралтын ажлыг ашиглалтад оруулж, иргэд, төрийн | - | Орон сууцанд хамрагдсан өрх, тоо | 2020 | 120 | 600 | 2021 оноос хойш Солонго хороололд байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн 7 блок 330 айл, UB-апартментын 72, иргэн Ч.Нямцэрэнгийн 26, иргэн Д.Төгсбаярын 56, иргэн М.Бүрэнзаяагийн 24, иргэн М.Болдбаатарын 16, иргэн Д.Пунсалмаагийн 30, Д.Цогбаярын 16, “Мандал голомт” ХХК 20, “Өргөө засал” ХХК 30, нийт 620 айлын орон сууцны барилгыг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | албан хаагчдыг орон сууцаар хангана. | | | | | | ашиглалтад оруулсан байна. 368 айлын орон сууцны барилга 2026 онд ашиглалтад орохоор хүлээгдэж байна. | |
| 54 | 3.3.2 | Сумдын инженерийн шугам сүлжээний дэд бүтцийг шийдвэрлэж, сум бүрт орон сууц барих нөхцөлийг бүрдүүлнэ. | ОНТ-718.9 | Инженерийн дэд бүтэц бүхий орон сууцтай өрх, тоо | 2020 | 1336 | 2836 | Засгийн газрын 202 дугаар тогтоолоор батлагдсан “150 мянган айлын орон сууц” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ОНХС-ын 98.9 сая төгрөгөөр 17 сумд 120 айлын цогцолбор бүхий хотхон байгуулах ажлын зураг төслийг “Тоонот констракшн” ХХК-аар боловсруулж эхний ээлжинд Бигэр сумд 45 айлын бүрэн цутгамал бетон орон сууцны ажлыг “Макс өргөө” ХХК гүйцэтгэж, 2025 онд ашиглалтад оруулсан.<br>Бигэр, Цогт, Тонхил, Жаргалан сумдын 120 айлын орон сууцны гадна шугам сүлжээний ажлын зураг төслийг "ДНТ" ХХК-аар боловсруулж, Бигэр сумын 120 айлын орон сууцны гадна цахилгааны шугам сүлжээний угсралтын ажлыг 2022 оны орон нутгийн төсвийн 147.7 сая төгрөгийн хөрөнгөөр "Хуруу цахир" ХХК-аар, Тонхил сумын 120 айлын орон сууцны гадна цахилгааны шугам сүлжээний угсралтын ажлыг орон нутгийн төсвийн 148.7 сая төгрөгийн хөрөнгөөр "Сутайн гэрэл" ХХК-аар тус тус гүйцэтгүүллээ.<br>Улсын төсвийн 2,493.8 сая төгрөгийн хөрөнгөөр Бигэр сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилгын ажлыг улсын төсвийн 2493,8 сая төгрөгийн хөрөнгөөр “Сити агро эх” ХХК гүйцэтгэж, 2025 оны 3 сард ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>Улсын төсвийн 6,000.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамжийн төсөл /Говь-Алтай аймаг, Алтай сум/-ийн ажлыг улсын төсвийн 10,192.7 сая төгрөгийн хөрөнгөөр "Тунгалаг говь транс" ХХК, "Билгүүн од констракшн" ХХК гүйцэтгэж байна. Ажлын явц 70%-тай.<br>Улсын төсвийн хөрөнгөөр 5,714.0 сая төгрөгийн хөрөнгөөр Цогт, Тайшир, Төгрөг, Алтай сумдад баригдах төрийн албан хаагчдын 8 айлын түрээсийн орон сууцны барилгын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлагдаж 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр “МГБИ” ХХК шалгарч, гэрээ байгуулсан.<br>Мөн УТ-ийн 900.0 сая төгрөгийн хөрөнгөөр Бугат сумд Төрийн албан хаагчдын түрээсийн 8 айлын орон сууц барих ажлын хүрээнд “Дрийм легон хаус” ХХК гүйцэтгэж 06 сарын 04-ны ГАА-БАЭҮЗ-05/26 дугаартай барилгын эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгосон. Барилга угсралтын ажил эхэлсэн. Ажлын явц 20 хувьтай.<br>Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн 5,464.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 сум ариутгах татуургын төв шугам сүлжээнд холбогдож, 8 сумд цэвэрлэх | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгууламжийн барилгыг барьж, 3 сумд цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг эхлүүлж, 30-90 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 55 | 3.3.3 | Зорилтот бүлгийн иргэдийг “Түрээсийн орон сууц”-аар хангах бодлогыг баримтална. | - | Түрээсийн орон сууцаар хангагдсан иргэд, тоо | 2020 | 120 | 300 | Цогт, Тайшир, Төгрөг, Алтай сумдад баригдах төрийн албан хаагчдын 8 айлын түрээсийн орон сууцны барилгын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлагдаж 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр “МГБИ” ХХК шалгарч, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах ажил хийгдэж байна. Бугат сумд Төрийн албан хаагчдын түрээсийн 8 айлын орон сууц барих ажлын хүрээнд “Дрийм легон хаус” ХХК гүйцэтгэж 06 сарын 04-ны ГАА-БАЭҮЗ-05/26 дугаартай барилгын эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгосон. Барилга угсралтын ажил эхэлсэн. Ажлын явц 20 хувьтай. | 30 |
| 56 | 3.3.4 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг түшиглэн хайрга, дайрга, элсний нөөцийг тогтоож, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэн барилга байгууламжийн насжилт, чанарыг сайжруулна. | - | Барилгын материалын үйлдвэр, тоо | 2020 | 7 | 15 | Зэвсэгт хүчний 341-р барилгын цэргийн анги барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, барилга байгууламжийн насжилт, чанарыг сайжруулах ажлын хүрээнд тус аймгийн “Мандалтын дөрөлж” -д хайгуул хийн хайрга, чулуу бутлан үйлдвэрлэж барилгын материалыг нийлүүлэх, бетон эдлэл, явган замын хавтан зэргийг хийж байна. Мөн “Цэн газар” ХХК шохойн үйлдвэрлэлийн ашиглалтад оруулан түүхий эдийг зах зээлд нийлүүлж эхэлсэн. Евро стандартын хөнгөн блокийн үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүллээ. Орон нутагт хар замаскийн үйлдвэрлэлийг “Харшийн цуурай” ХХК эрхэлж байна. | 70 |
| 57 | 3.3.5 | Барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлж, хийгдэх сорил шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэнээр стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх нөхцөл бүрдүүлнэ. | УТ-63.1 | Сорил шинжилгээний нэр төрөл, тоо | 2020 | 2 | 4 | Монгол Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд ЗамТээвэр Барилга Хот Байгуулалтын Яамны Сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албанаас аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт барилгын материалын сорилт шинжилгээний 3 төрлийн 9,331,132 төгрөг үнэ бүхий тоног төхөөрөмж нийлүүлсэнээр орон нутагт барилгын материалын сорил, шинжилгээний лаборатори үндэс суурь тавигдсан.<br>2020 онд захиалагчийн техникийн хяналтын зардлаас 24 нэр төрлийн багаж тоног төхөөрөмжийг 15,7 сая төгрөгөөр нэмж авсан. Ажлын байрны ажиллах орчин нөхцлийг сайжруулах ажлын хүрээнд лабораторийн өрөөний засварын ажилд 3 сая төгрөг, тоног төхөөрөмж байрлуулах тавиурт 2 сая төгрөг, шинжилгээнд шаардлагатай урвалж, бодис авах, лабораторийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | багаж тоног төхөөрөмж баталгаажуулахад 1,5 сая төгрөг нийт 6,5 сая төгрөг, нийт 13 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Мөн 2021 онд Барилга, барилгын материалын лабораторит шаардлагатай 6 төрлийн тоног төхөөрөмжийг барилгын захиалагчийн хяналтын зардлаас 60,420,300 төгрөгөөр тоног төхөөрөмж нийлүлэх Төрийн болон орон нутгийн өмчгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендер зарлан шалгарсан “Юнилаб” ХХК-тай тоног төхөөрмөж нийлүүлэх гэрээ байгуулан 2022 онд хүлээн авсан. Барилгын материалын лаборатори нь 2019 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд 2025 оны байдлаар 6 төрлийн шинжилгээг хийж гүйцэтгэн шинжилгээний нэр төрлөө нэмэгдүүлэн ажиллаж байна. | |
| **Газрын харилцаа** | | | | | | | | | |
| **Зорилт 3.4.Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ:** | | | | | | | | | |
| 58 | 3.4.1. | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан аймаг, сумын газар зохион байгуулалтын хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, мөрдүүлнэ. | - | Шинэчилсэн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, тоо | 2020 | 1 | 1 | Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголын ажлыг Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Нью урбанизм” ХХК гүйцэтгэж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 16 дугаар тогтоолоор хүлээлгэн өгсөн.<br>Говь-Алтай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2022-2024 онд мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй “Геоботаник” ХХК гүйцэтгэж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2024 оны 04 сарын 25-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлуулан хүлээлгэн өгсөн.<br>Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 6 бүлэг 32 арга хэмжээний дагуу хэрэгжилтийг 2025 онд зохион байгуулж байна.<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчээр мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй “Вектор меп” ХХК нь 567 сая төгрөгөөр гүйцэтгэх үнийн саналыг ирүүлэн шалгарсан. Гүйцэтгэгчийн ирүүлсэн ажил гүйцэтгэх графикийн дагуу сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын үе шатны ажлууд хийгдэж Алтай, Баян-Уул, Бигэр, Дарив, Дэлгэр, Есөнбулаг, Жаргалан, Тайшир, Төгрөг, Хөхморьт сумдад сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдаж, Бугат, Халиун, Тонхил, Шарга, Цээл сумдад сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдаж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Гүйцэтгэгч “Вектор мэп” ХХК нь 2025 оны 06 сард зөвлөх үйлчилгээний тайланг батлуулахаар ГААХААГ/20240103082-2 дугаартай нэмэлт гэрээг байгуулан ажиллаж байна. | |
| 59 | 3.4.2. | Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг иргэдийн оролцоотой боловсруулж, газар олголтыг ил тод нээлттэй болгоно. | - | Газар өмчилж авсан иргэд, тоо | 2020 | 7530 | 13000 | Говь-Алтай аймгийн төв Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголын ажлыг Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Нью урбанизм” ХХК гүйцэтгэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 16 дугаар тогтоолоор хүлээлгэн өгсөн. Дээрх төлөвлөгөөний ажил хийгдсэнтэй холбогдуулан Хот байгуулалтын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны хүрээнд иргэнд газар өмчлүүлэх ажлыг төлөвлөгөөг батлагдах хүртэл хугацаанд зогсоосон.<br>Хөдөөгийн 17 сумд нийт хашааны 90-98 хувьд нь газар өмчлөх шийдвэр гарсан.<br>Аймгийн хэмжээнд Дарив, Халиун, Хөхморьт, Цогт, Чандмань, Жаргалан, Эрдэнэ сумд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй, Бусад 11 сумдаас 2025 онд иргэнд газар өмчлүүлэх саналгүй тухай албан бичиг ирж “Монгол Улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 119 дүгээр тогтоолд аймгийн хэмжээнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил батлагдаагүй болно.<br>Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим системд 2026 онд өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын төлөвлөгөөний төслийн саналыг цаасаар болон egazar.gov.mn сайтаар хүлээн авч 2026 онд иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх газрын хэмжээ байршлын саналын төслийг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд зураглан оруулж, ГЗБГЗЗЕГазраас дүгнэлт авах ажил хийгдэж байна. | 50 |
| 60 | 3.4.3. | Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг сумдын түвшинд нэвтрүүлж, ашиглана. | - | Газрын биржийн системд нэвтэрсэн сум | 2020 | 1 | 18 | Газрын биржийн цахим системийг 18 сумд хэрэглээнд нэвтрүүлэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 дугаар тушаалаар Газрын биржийн цахим системийн шинэчилсэн 3.0 хувилбарыг 2025 оны 02 сарын 10-ны өдрөөс улсын хэмжээнд нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахим системээр зохион байгуулах, газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг тогтмол бүртгэж байна. | |
| 61 | 3.4.4. | Газар ашиглалт, газрын мониторин-гийн байнгын ажиллагаа-тай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээнэ. | - | Газрын фото мониторинг хийгдсэн цэг, тоо | 2020 | 330 | 330 | 18 сумын хэмжээнд 8149010 га бэлчээрийн талбайд 2-7 хоногийн хугацаанд 345 мониторингийн цэгүүдэд хээрийн судалгаа хийсэн. Мал бэлчээрлэх хоногийн тоо өвөл 120 хоног, намар 90 хоног, хавар 60 хоног, зун 90 хоног, боломжит даац нь аймгийн дундаж дүнгээр 152992 байгаа бөгөөд хонин толгойд шилжүүлснээр 238444 болж бэлчээрийн даац 85452 хонин толгойгоор хэтэрсэн үзүүлэлттэй байна. | 100 |
| 62 | 3.4.5 | Хаягжилтын нэгдсэн системийг нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулна. | ОНТ-68.9 | Хаягжилт хийгдсэн сум, тоо | 2020 | 11 | 18 | Аймгийн хэмжээнд хаягжуулалтын тэмдэг тэмдэглэгээ суурилуулах ажил 16 сумд бүрэн хийгдэж дууссан. 2026 оны төсөвт 2 сумын хаягийн ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна. | 90 |
| **ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ** | | | | | | | | | |
| **Зорилго 4.Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, хариуцлагатай уул уурхай, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар төр хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийн бодлогыг хэрэгжүүлж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг хангахад чиглэсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| **Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд, Тогтвортой хөдөө аж ахуй, үйлдвэрлэл** | | | | | | | | | |
| **Зорилт 4.1.Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангана:** | | | | | | | | | |
| 63 | 4.1.1 | “Газар тариалан, жимс, жимсгэнэ” төслийг хэрэгжүүлнэ. | ОНХС-2,000.0 | Тариалсан талбайн хэмжээ, га | 2020 | 1520 | 2120 | “Газар тариалан, жимс, жимсгэнэ” төслийн хүрээнд 2021 онд жимс жимсгэний тариалалт 33 га, 2022 онд 14 га, 2023 онд 3 га талбайд жимс, жимсгэнэ тариалж, тариалсан талбайн хэмжээг 50 га талбайгаар нэмэгдүүллээ.<br>Хүнсний ногооны үйлдвэрлэл “Усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Ёлтон болон Цахирын услалтын системийг ашиглалтад оруулснаар тариалах талбайн хэмжээг 1954,3 га талбайд хүргэлээ. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 64 | 4.1.2 | Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хүнсний нарийн ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | ОНХС-304,9 ЖДҮХС-74,0 сая Төсөл хөтөлбөр-150,0 | Байнгын ажиллагаатай өвлийн хүлэмжийн хэмжээ, м2 | 2020 | - | 600 | Тайшир сумд 2021 онд байгуулагдсан “Агро инноваци сургалт судалгаа”-ны төвийг өргөжүүлж 2022 онд 400м2 бүхий өвлийн хүлэмжийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 204.9 сая төгрөгөөр “Тэгш-Алтай” ХХК хийж гүйцэтгэсэн. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 74.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр “Их говийн арвин ургац” ХХК 220 м2 талбай бүхий өвлийн хүлэмжийг барьж ашиглалтад оруулсан.<br>2023 онд Есөнбулаг сумд ТИКА олон улсын зохицуулах агентлагийн 150.0 сая төгрөгийн санхүүжилтээр 300 м2 өвлийн хүлэмжийг барьж ашиглалтад оруулсан.<br>2025 онд Есөнбулаг сумын Естийн аманд орон нутгийн хөгжлийн сангийн 100.0 сая төгрөгийн санхүүүжилтээр 300 мкв зуны хүлэмж 2 ширхэг, уртасгасан хугацаатай 300 мкв бүхий давхар хүлэмж 1 ширхэг, нийт 900 мкв 3 ширхэг хүлэмж барьж ашиглалтад оруулж, 4 төрлийн нарийн ногоо тариалж 1 тн ургац хураан авлаа. | 100 |
| 65 | 4.1.3 | Төмс, хүнсний ногоо, үрийн нөөцийг хадгалах зоорийн аж ахуйг хөгжүүлнэ. | ОНХС-20,0 Төсөл хөтөлбөр-80,0 ЖДҮХС-20,0 | Төмс, хүнсний ногооны зоорийн багтаамж, тн | 2020 | 1082 | 2100 | Газар тариалан эрхлэгчдийн төмс, хүнсний ногоог худалдан борлуулах нөхцөлийг хангах зорилгоор 2021 онд Есөнбулаг сумын Индэрт багт Германы иргэдийн сайн дурын бүлгийн 80,0 сая төгрөгөөр 60 тн болон 20 тн-ын багтаамжтай 2 хүнсний ногооны зоорийг барьж ашиглалтад оруууллаа.<br>2022 онд Цогт сумын “Мөнгөлөг тоорой” хоршоонд Хоршоо хөгжүүлэх сангаас 20,0 сая төгрөгийн зээлийг олгож 20тн-ын багтаамжтай зоорь, Бигэр сумд ОНХС-ийн хөрөнгөөр 20 тн-ын багтаамжтай зоорийг тус тус ашиглалтад оруууллаа.<br>2025 онд “Атар-IV” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд 150,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр Дэлгэр сумд “Гуулин Буудай” ХХК 100 тн-ын зоорийг барьж ашиглалтад оруууллаа.<br>Аймгийн хэмжээнд 11 сумын 25 өрх 808 тн-ын багтаамжтай зоорийг өөрийн хэрэгцээнд ашиглалтад оруулснаар нийт 2110 тн-ын багтаамжтай төмс, хүнсний ногоо, үрийн нөөц хадгалах зоорь ашиглагдаж байна. | 100 |
| 66 | 4.1.4 | Хүнсний аюулгүй байдлыг хангаж, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловс-руулах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | ОНХС-19,9 | Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр | 2020 | 9 | 15 | Мах боловсруулах болон мал нядалгааны 4, хиаман бүтээгдэхүүний 1, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах 5, бууз баншны 9, нийт 19 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн Засаг даргын санаачилсан “Сүү” хөтөлбөрийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд сүү өгөх ажлыг эхлүүлэхээр “Энх таян” ХХК-д 4 нэр төрлийн 19,9 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 67 | 4.1.5 | Стандартын шаардлага хангасан мал нядалгааны цех, хөргүүртэй агуулах, малын гаралтай түүхий эд, бүтээг-дэхүүнийг боловсруулах үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлнэ. | ЖДҮХС-300.0 сая | Мах нядалгааны цех, хөргүүртэй агуулах | 2020 | 2 | 4 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2024 онд Баян-Уул сумын 1 аж ахуйн нэгжид 300.0 сая төгрөгийн зээл олгож, 150тн-ын багтаамжтай хөргүүртэй агуулах, мах ангилан вакумдах үйлдвэр, ТИКА олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар тус бүр 40 тн-ын 2 ширхэг хөргүүртэй агуулахыг ашиглалтад оруулснаар махны хөргүүртэй 5 агуулахтай боллоо. | 100 |
| 68 | 4.1.6 | Худалдаа, нийтийн хоол, хоршоо, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ | ОНХС-30,0 ЖДҮХС-100,0 | Ахуйн үйлчилгээ | 2020 | 6 | 20 | Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2023 онд Шадар туслах ХХК-ийн ахуйн үйлчилгээний төвийн өргөтгөлийн төсөлд 100,0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс тайлант онуудад 436 иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд 5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож 100 байнгын болон түр ажлын байр бий болгож 300 гаруй ажлын байр хадгалагдсан байна. | 100 |
| 69 | 4.1.7 | Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамруулан, хөнгөлөлттэй зээл авахад дэмжлэг үзүүлж, Бизнес мэдээлэл, судалгаа хөгжлийн “GATE CENTER” төвийг байгуулна. | - | Хөнгөлөлттэй зээл, дэмжлэгт хамрагдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид | 2019 | 124 | 300 | Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2021 онд 3 аж ахуйн нэгжид 286.9 сая төгрөг, 2022 онд 6 аж ахуйн нэгжид 730.6 сая төгрөг, 2023 онд 11 аж ахуйн нэгжид 1,115.5 сая төгрөг, 2024 онд 11 аж ахуйн нэгжид 1,111.8 сая төгрөг, нийт 31 аж ахуйн нэгжид 3,244.8 сая төгрөгийн зээлийг олголоо.<br>Хоршоо хөгжүүлэх сангаас 2021 онд 163 иргэн, аж ахуйн нэгжид 1,119.6 сая төгрөг, 2022 онд 46 иргэн аж ахуйн нэгжид 1,164.9 сая төгрөг, 78 иргэн, аж ахуйн нэгжид 1,103.6 сая төгрөг, 2024 онд 13 иргэн, аж ахуйн нэгжид 349.0 сая төгрөг, 2025 онд 10 аж ахуйн нэгжид 466.0 сая төгрөг нийт 310 иргэн, аж ахуйн нэгжид нийт 4,203.1 сая төгрөгийн зээлийг олгосон байна. “Атрын IV” аян хүрээнд 2025 онд 2 аж ахуйн нэгжид 500.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна. Тайлант хугацаанд нийт 343 иргэн, аж ахуйн нэгжид нийт 7,947.9 сая төгрөгийн зээлийг олголоо. | 100 |
| 70 | 4.1.8 | Малын чанар, ашиг шимийг сайжруулан, генийн санг хамгаалж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ. | УТ-21,7 СОНХС -4,5 | Ангилалд хамрагдсан мал | 2020 | 9000 | 50,000 | 2021 онд Бугат, Цогт сумдад үржүүлж буй Говь-Алтай үүлдрийн 8000 хонь, Дэлгэр сумд үржүүлж буй Алтайн улаан үүлдрийн Д хэвшлийн 3500 ямаа, Бугат, Цогт сумдад үржүүлж буй нутгийн 3000 ямаа, нийт 14500 толгой малд үзлэг ангилалтыг улсын төсвийн 21.7 сая төгрөгөөр, 2022 онд Бугат сумд өсгөн үржүүлж байгаа нутгийн Хөвчийн улаан 3000 ямаанд сумын орон нутгийн хөгжлийн сангийн 4.5 сая төгрөгөөр, 2023 онд үржилд ашиглаж байгаа 6220 толгой хуц, 9822 толгой ухна, нийт 16042 толгой | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хээлтүүлэгчийг улсын төсвийн 24.0 сая төгрөгөөр, 2024 онд Бугат, Тонхил сумдад үржүүлж байгаа Говь-Алтай үүлдрийн 5000 хонь, нутгийн Хөвчийн улаан 3000 ямаа, нийт 8000 толгой бог мал, Төгрөг, Халиун, Шарга сумдад үржүүлж буй Төхөм тунгалгийн хүрэн үүлдрийн 2900 тэмээ, Дэлгэр сумд үржүүлж байгаа Алтайн улаан үүлдрийн Д хэвшлийн 3000 ямаа, Цээл сумд үржүүлж байгаа нутгийн Монгол үүлдрийн 3000 ямаа, нийт 7 сумын 16900 толгой малд улсын төсвийн 28.2 сая төгрөгөөр үзлэг ангилалт тус тус хийлээ. 2021-2025 онд аймгийн хэмжээнд 2900 толгой тэмээ, 28322 ямаа, 19220 хонь, нийт 50442 толгой малд үзлэг ангилалт хийлээ. | |
| | | | | Баталгаажсан үүлдэр, омог | 2020 | 3 | 4 | Бугат сумд үржүүлэгдэж байгаа “Хөвчийн улаан ямааны аж ахуй, биологийн онцлог, ашиг шимийн үндсэн үзүүлэлтийг тогтоох” ажлыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зохион байгуулж байна. Монгол Улсын Төрийн Соёрхолт зөвлөх малзүйч Б.Мандахтай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан, Хөвчийн улаан ямааны тодорхойлолт болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулаад байна. Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Их эрдмийн зөвлөлийн хурал, ашиг шимийн зөвлөлийн хурал, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлийн хурлаар 2025 оны 12 дугаар сард хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. | |
| | | | | Дэмжлэгт хамрагдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид | 2019 | 7 | 10 | Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр 1 иргэнд Керей үүлдрийн 50 толгой хонь эзэмшүүлээд байна.<br>Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сүүний үйлдвэрийг дэмжих хүрээнд Алатау үүлдрийн тугалтай үхрийг худалдан авах гэрээ хийн, хүлээн авах ажлыг зохион байгуулж байна.<br>Мал хамгаалах эргэлтийн сангаас сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр 50 сая төгрөгийн зээлийг 1 иргэнд олгоод байна. | |
| 71 | 4.1.9 | Малын гоц халдварт өвчингүй “Эрүүл бүс” нутгийг хадгалж, мал амьтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | УТ-551,5 ОНТ-2,366.0 | Халдварт, паразитлах өвчнөөс урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулсан мал, тоо/ сая | 2020 | 3 | Жилд 2.5 сая малыг хамруулна. | Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2021 онд 204.9 мянган мал, 2022 онд 213.4 мянган мал, 2023 онд 149.6 мянган мал, 2024 онд 108.0 мянган мал, 2025 онд 448.9 мянган мал хамрууллаа.<br>Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2021 онд 1049.6 мянган мал, 2022 онд 1035.1 мянган мал, 2023 онд 1047.0 мянган мал, 2024 онд 1130.2 мянган мал, 2025 онд 837.3 мянган мал хамрууллаа.<br>Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2021 онд 3408.8 мянган мал, 2022 онд 2904.9 мянган мал, 2023 онд | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 2536.5 мянган мал, 2024 онд 1354.6 мянган мал, 2025 онд 1352.0 мянган мал хамрууллаа.<br>Жилд дунджаар 3556160 мал, амьтныг хамрууллаа. | |
| 72 | 4.1.10 | Бэлчээрийн менежмент хөтөлбөрийг хэрэгжүүлж, бэлчээрийг доройтлоос хамгаалж, нөхөн сэргээж, ашиглалтыг сайжруулна. | УТ-894.7<br>ОНХС-2,326.6<br>Төсөл хөтөлбөр-50.0 | Гүн өрмийн худаг | 2019 | 536 | 576 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн 138.0 сая төгрөгөөр 6, гадаадын төсөл хөтөлбөрийн 50.0 сая төгрөгөөр 2, 2022 онд улсын төсвийн 105.0 сая төгрөгрөөр 3, орон нутгийн хөгжлийн сангийн 584.7 сая төгрөгөөр 19, 2023 онд улсын төсвийн 324.0 сая төгрөгөөр 9, орон нутгийн хөгжлийн сангийн 610.0 сая төгрөгөөр 22, 2024 онд улсын төсвийн 396.0 сая төгрөгөөр 11, орон нугийн хөгжлийн сангийн 680.9 сая төгрөгөөр 22, 2025 онд улсын төсвийн хөрөнгөөр 69.7 сая төгрөгөөр 2, орон нутгийн хөгжлийн сангийн 313.0 сая төгрөгөөр 12, нийт 120 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргаж 120 мян/га бэлчээрийн талбайг усжуулаад байна. Нийт инженерийн хийцтэй 656 худаг ашиглаж байна. | 70 |
| | | | - | Энгийн уурхайн худаг | 2019 | 1341 | 1441 | Малчдын санаачилгаар 2021 онд 12, 2022 онд 13, 2023 онд 10, 2024 онд 6, 2025 онд 12, нийт 53 энгийн уурхайн худгийг шинээр гаргаж 31.8 мян/га бэлчээрийн талбайг усжуулсан байна. Нийт энгийн уурхайн 1394 худаг ашиглагдаж байна. | |
| 73 | 4.1.11 | Мал сүргийг байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалан аймаг, сумдын өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлнэ. | ОНТ-70.0 | Аймгийн аюулгүй нөөцийн өвс, тэжээлийн хэмжээ | 2020 | Өвс 500<br>Тэжээл 100 | Өвс 2500<br>Тэжээл 500 | Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хүрээнд 2021 онд 150 тн өвс, 50 тн тэжээл, 2022 онд 200 тн өвс, 50 тн тэжээл, 2023 онд 400 тн өвс, 50 тн тэжээл, 2024 онд 300 тн өвс, 50 тн тэжээл, 2025 онд 100 тн өвс, 170 тн тэжээл, нийт 1150 тн өвс, 370 тн тэжээлийг аюулгүйн нөөцөд бүрдүүлсэн. | 70 |
| **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ** | | | | | | | | | |
| **Зорилт 4.2 Байгаль, түүх соёлын, өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 74 | 4.2.1 | Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын шинэлэг, брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | - | Жилд ирэх амрагч жуулчид | 2020 | 18741 | 30000 | Аймгийн “Аялал жуулчлалын салбарыг 2021-2031 онд хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг”-ийг боловсруулан хэрэгжүүлж байна. Бодлогын баримт бичигт тусгасны дагуу гурван бүс болгон хөгжүүлж байна. Үүнд:<br>- I-р бүс Алтай хотоос зүүн, зүүн хойд нутаг (Дэлгэр, Тайшир, Жаргалан, Баян- Уул, Хөхморьт сумд),<br>-II-р бүс Алтай хотоос баруун, баруун хойт нутаг (Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга сумд) | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | -III-р бүс Алтай хотоос урагш (Бигэр, Халиун, Цээл, Цогт, Эрдэнэ, Чандмань, Баянтоорой) маршрутыг сурталчлаж хэрэгжилтийг ханган ажиллалаа.<br>Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 4 сувилал, 9 жуулчны бааз үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд орон нутгийг зорин ирэх жуулчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж 2025 оны байдлаар дотоод 27681, гадаад 891 гадаад жуулчид ирсэн байна. | |
| 75 | 4.2.2 | Монгол төдийгүй дэлхийд ховордсон нэн ховор, ховор амьтдыг түшиглэсэн тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | - | Жилд ирэх амраргч жуулчид | 2020 | 18741 | 30000 | Монгол төдийгүй дэлхийд ховордсон нэн ховор, ховор амьтдыг түшиглэсэн тусгай сонирхлын чиглэлээр Олон улсын тахь групптэй хамтран "Говийн их дархан цаазат газрын Б" хэсэгт 5 удаагийн аялал зохион байгууллаа. Говийн их дархан цаазат газрын "А", "Б" хэсэг болон Монгол элсний байгалийн цогцолбор газарт зорилтот аялал жуулчлалаар 2021-2025 онд нийт 50,000 орчим жуулчин ирсэн үзүүлэлттэй байна. | 100 |
| 76 | 4.2.3 | Байгалийн үзэсгэлэнт тогтоц бүхий газруудыг түшиглэн аялал жуулчлалын баазыг шинээр байгуулна. | УТ 374,0<br>ОНТ 80,0<br>ОНХС 60,0 | Жуулчны бааз | 2020 | 3 | 5 | Цогт сумын түүх соёлын үзэсгэлэнт газар "Ээж хайрхан"-ы дэргэд "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төслийн баг, төсөлд бүртгэлтэй "Малчны бүлэг" хамтран байгальд ээлтэй эко ариун цэврийн байгууламж бүхий бүхий пассив хаусыг барьж ашиглалтад оруулсан бөгөөд, тус төсөлд орон нутгийн төсвөөс 80,0 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 60,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>Хөхморьт сумын "Дөргөн нуур"-ын эрэг дээр улсын төсвийн 374,0 сая төгрөгийн хөрөнгөөр "25 майхантай отоглох цэг" байгуулах төслийг "Хос Гандирс" ХХК гүйцэтгэлээ.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн 149,8 сая төгрөгөөр Тонхил сумд Сутай хайрхан жуулчны бааз, хувийн хөрөнгө оруулалтаар 2021 онд “Happy nomadic camp” жуулчны бааз, 2022 онд Тайшир сумд “Баян-Өндөр” гэр буудал, 2023 онд “Тахийн тал” жуулчны бааз, “Хантайшир” амралтын газрууд ашиглалтад орлоо. | 100 |
| 77 | 4.2.4 | Аялал жуулчлалын салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, ур чадварыг нэмэгдүүлнэ. | - | Зочид буудлын хүчин чадал | 2020 | 65 өрөө, 138 ор | 90 өрөө, 188 ор | 2021-2025 онд хувийн хөрөнгө оруулалтаар шинээр байгуулагдсан зочид буудлууд<br>-2023 онд Минж зочид буудал- 58 ор, 30 өрөө,<br>-2025 онд Хүслэнт хүдэр зочид буудал- 20 ор, 9 өрөө<br>-2022 онд Бигэр бор гол зочид буудал-12 ор, 4 өрөө<br>-2022 онд Тайшир сумд “Баян-Өндөр” гэр буудал-10 ор, 3 гэр<br>-2023 онд Талын хүрхрээ гэр буудал, 20 ор, 5 гэр<br>2025 оны байдлаар аймгийн хэмжээнд 7 зочид буудал, 30 дэн буудал үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт 610 ор, 203 өрөөтэй болж зочид буудлын хүчин чадал нэмэгдлээ. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Жуулчны баазын хүчин чадал | 2020 | 31 өрөө, 138 ор | 50 өрөө, 198 ор | Аймгийн хэмжээнд 10 жуулчны бааз, 8 амралт, сувиллын газар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2025 оны байдлаар нийт 475 ор, 158 өрөөтэй болж жуулчны баазын хүчин чадал нэмэгдлээ. | |
| 78 | 4.2.5 | Элсний фестиваль эвент арга хэмжээг улс үндэстний хэмжээн дэх брэнд эвент болгож хөгжүүлнэ. | ОНТ-400,0 | Эвент арга хэмжээнд оролцогч жуулчид | 2020 | 500 | 1500 | Элсний фестиваль аялал жуулчлалын эвент арга хэмжээг “Жангар фестиваль” нэрээр Хөхморьт сумын Дөргөн нуурын эрэг дээр 2022 оноос хойш нийт 4 удаа зохион байгууллаа. Дээрх 4 удаагийн арга хэмжээнд БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орон, Улаанбаатар хот, Ховд, Увс, Завхан, Архангай аймгуудаас нийт 5000 гаруй залуучууд хамрагдлаа. | 100 |
| 79 | 4.2.6 | Аялал жуулчлалын салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, ур чадварыг нэмэгдүүлнэ. | ОНТ-6,0 | Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт ажиллаж буй хүний нөөц | 2020 | 474 | 574 | Аялал жуулчлалын салбарын нэгдсэн “Боломж ба шийдэл” анхдугаар зөвлөгөөнийг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнд сум бүрийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар, малчдын төлөөлөл, аж ахуй нэгжүүдийн төлөөлөл, аймгийн төвийн зочид буудал, ресторан, амралт сувиллын үйлчилгээ үзүүлдэг иргэд нийт 100 гаруй төлөөлөгч оролцож, аялал жуулчлалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашид хэрэгжүүлэх бодлого, хөгжлийн хөтөлбөрүүд болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр сургалтууд зохион байгууллаа.<br>Аймгийн хэмжээнд зочлох үйлчилгээний нийт 52 байгууллагад 2025 оны байдлаар 624 ажилтан ажиллаж байна | 100 |
| 80 | 4.2.7 | Аялал жуулчлалын гол маршрутыг шинэчлэн баталж, цахилгаан хангамж авто замын дэд бүтцийг сайжруулна. | ОНХС-150,0 | Нэн ховор, ховор амьтдыг түшиглэн тусгай сонирхлын аялал жуулчлалын бааз | 2020 | 0 | 3 | Аймгийн хэмжээнд нийт 4 жуулчны бааз 2021-2025 оны хооронд шинээр байгуулагдлаа. Цогт сум “Ээж хайрхан” жуулчны бааз, Хөхморьт сум Дөргөн нуурын эрэг “Дөргөн хатан” жуулчны бааз болон Тайшир сумын Гэгээн нуур, УЦСын ойролцоо байрлах “Гурван гал” жуулчны бааз, Тонхил сумын “Сутай хайрхан” жуулчны бааз шинээр байгуулагдан 6-9 сарын хооронд тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна. | 90 |
| | | | УТ 100,0 | Байгуулагдсан отоглох цэг | 2020 | 0 | 3 | Ээж уулыг түшиглэн улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд 1 отоглох цэг, Хөхморьт сумын Дөргөн нуурийг түшиглэн улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд 1 отоглох цэгийг хийж нийт 2 отоглох цэг ашиглалтад орсон байна. | |
| | | | - | Замын тэмдэг тэмдэглэгээ | 2020 | 10 | 25 | Говийн их дархан цаазат газрын “А”, “Б” хэсэг, Монгол элсний улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын бүс, орчны бүсүүдэд аялал, жуулчлалд зориулсан 54 замын тэмдэг тэмдэглэгээнүүдийг хийж байршуулсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - | Мэдээллийн самбар | 2020 | 12 | 25 | Аймгийг зорин ирэх жуулчдад зориулсан аялал жуулчлалын 3 маршрут, “Говийн гайхамшигт-6” амьтны мэдээллийн самбарыг орон нутгийн төсвөөр хийж аймгийн орох, гарах хаалган дээр байршуулсан. Мөн сумдын 100 жилийн ой болсонтой холбогдуулан 18 сум, 2 тосгон, Монгол элсний улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын бүс, Говийн их дархан цаазат газрын “А”, “Б” хэсэг, орох хаалган дээр маршрутын нийт 30 самбарыг байршуулсан. | |
| **УУЛ УУРХАЙ** | | | | | | | | | |
| **4.3. Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 81 | 4.3.1 | Ашигт малтмалын томоохон ордуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | - | Ашиглалтад орсон цементийн үйлдвэр | 2020 | 0 | 1 | Тайшир сумын нутагт 34.6 сая тонн батлагдсан нөөцтэй, хоногт 400 тонн, жилд 120.0 мянган тонн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай Дөрвөлжингийн шохойн үйлдвэрийг 100 гаруй тэрбум төгрөгийн дотоодын хөрөнгө оруулалтаар 2025 онд барьж дуусган, ашиглалтанд оруулаа.<br>Тус үйлдвэр ашиглалтанд орсноор 2025 оны эхний 10 сарын байдлаар 111, үүнээс орон нутгаас 52 хүнийг байнгын ажлын байраар хангаж ажиллаж байна. | 70 |
| | | | | Ашиглалтад орсон төмрийн хүдрийн уурхай | 2020 | 1 | 2 | Тайшир хүдэр ХХК-ийн төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрийг барьж эхэлсэн боловч санхүүгийн бэрхшээлээс шалтгаалан бүтээн байгуулалтын ажил 35%-тай зогсонги байдалтай байна. | |
| 82 | 4.3.2 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын илэрцийн нөөцийн судалгааг хийж, орд газрын нөөцийг тогтоон барилгын материалын үйлдвэрлэлийг стандартад нийцсэн түүхий эдээр хангана. | - | Түгээмэл тархацтай ашигт малтмалын судалгааны ажил | 2020 | 0 | 1 | Аймгийн хүн амын орон сууцны хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа, зам барилгын ажил эрчимтэй явагдаж байгаагаас шалтгаалан түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газруудын нөөц тогтоолгох, улмаар ашиглуулах зорилгоор хайгуулын тусгай зөвшөөрөл 11-ийг олголоо. | 70 |
| | | | | Олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо | 2020 | 6 | 10 | 2021-2025 онуудад түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 11 тусгай зөвшөөрлийг олгосон байна. | |
| | | | | Нөөц тогтоогдсон ордын тоо | 2020 | 0 | 4 | Есөнбулаг сумын нутагт 2025 онд Цэргийн 341-р анги, “Баян боролдой” ХХК зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид хайгуулын ажлын төлөвлөгөө батлуулан хайгуул хийж байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Олборлолтын үйл ажиллагаа эхлүүлсэн аж ахуйн нэгжийн тоо | 2020 | 0 | 3 | Тайлант хугацаанд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдоогүй. | |
| 83 | 4.3.3 | Үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжийн нийгмийн хариуцлагыг сайжруулж орон нутгийн хөгжилд оролцох оролцоог сайжруулна. | - | Хамтран ажиллах гэрээ байгуулсан аж ахуй нэгж | 2020 | 0 | 20 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэсшигч аж ахуйн нэгжтэй орон нутагтай хамтран ажиллах гэрээг 2022 онд 25, 2023 онд 12, 2024 онд 4, 2025 онд 21 гэрээг байгуулан, эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд https://www.iltodgeree.mn/ байршуулллаа.<br>2025 онд 11 сум тусгай зөвшөөрөл эзэмшигч 20 аж ахуйн нэгжтэй "нийт ажилтны 50-аас доошгүй хувьд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах бодлогыг баримтлан , аймаг сумын хөгжилд 2414,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр, 31.3 мянган мод суулгац тарьж ургуулах, нийлүүлэхээр" гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| | | | | Шинээр нэмэгдсэн ажлын байр | 2020 | 350 | 550 | 2021-2025 онд Хан-Алтай ресурс ХХК, Цэн газар ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд алтны болон шохойн уурхай, баяжуулах үйлдвэрүүдийг ашиглалтанд оруулж, 2025 оны эхний 10 сарын байдлаар орон нутгаас 449 иргэнийг ажлын байраар хангаж ажиллаж байна. | |
| 84 | 4.3.4 | Нэгдсэн зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгчдийг дэмжинэ. | | Бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээний газарт авсан талбай | 2020 | 2 | 4 | Бичил уурхайн зориулалтаар 2021-2025 онд Есөнбулаг, Дарив, Чандмань сумдад 6 газрыг тусгай хэрэгцээнд авсан бөгөөд Ашигт малтмал, газрын тосны газраас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломжтой гэсэн 2 дүгнэлт гарч, 2024 онд 2, 2025 онд 6 нөхөрлөлтэй гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Мөн Марко поло ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2024-2025 онд 78 нөхөрлөл гэрээ байгуулан, 702 иргэнийг ажлын байраар хангаж ажилласан бөгөөд 321 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн байна. | 100 |
| **БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА** | | | | | | | | | |
| **Зорилт 4.4 Гадаад хамтын ажиллагааг дэмжинэ.** | | | | | | | | | |
| 85 | 4.4.1 | Гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалж харилцаа | - | Хамтын ажиллагааг өргөжүүлэх хөрш болон | 2020 | 2 | 3 | БНХАУ-ын Ганьсу муж, ӨМӨЗО, ШУӨЗО-ны Хами, Цонж, Алтай аймгуудтай орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн хил дагуух бүс нутгийн гадаад хамтын ажиллагааг идэвхижүүлэн, уламжлалт харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж, гадаад | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамтын ажиллагааг өргөжүүлэн, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ гарц нээх асуудлыг судална. | | өндөр хөгжилтэй орнуудын тоо | | | | худалдаа, хөрөнгө оруулалт, соёл, боловсрол, дэд бүтэц, байгаль орчны хамгаалал зэрэг олон салбарт хамтын ажиллагааг өргөжүүлж, хоёр улсын бүс нутгийн харилцан ашигтай түншлэлийг бий болгон ажиллаж байна.<br>Мөн БНСУ, АНУ, Унгар улсуудтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн ажиллалаа.<br>2025 онд БНХАУ, Япон улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд нарын айлчлалыг зохион байгуулж, харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх уулзалтыг зохион байгуулсан. Мөн БНХАУ-ын Хами аймгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг тус аймагт айлчилсан. | |
| 86 | 4.4.2 | Олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлж хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | - | Орон нутагт хэрэгжүүлэх олон улсын төсөл хөтөлбөрийн тоо | 2019 | 10 | 15 | БНХАУ, БНСУ, Япон улстай соёл, боловсрол, эрүүл мэнд, газар тариалан, хөдөө аж ахуй, зам, барилгын бүтээн байгуулалт, аялал жуулчлал, эрчим хүч, боомтын бүтээн байгуулалтын чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүллээ.<br>2021-2025 онуудад аймгийн хэмжээнд нийгмийн хамгаалал, хөдөө аж ахуй, байгаль хамгааллын чиглэлээр нийт 143,102,196,959 төгрөгийн санхүүжилттэй 17 урт болон богино хугацаат төсөл хөтөлбөр хэрэгжлээ. | 100 |
| **ТАВ. ЗАСАГЛАЛ** | | | | | | | | | |
| **Зорилт 5. Төрийн үйлчилгээг цахимжуулж, авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэн, батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, иргэний оролцоотой, ил тод, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой, үр нөлөөтэй засаглалын бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| **Төрийн үйлчилгээ** | | | | | | | | | |
| **Зорилт 5.1. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, ил тод, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлнэ:** | | | | | | | | | |
| 87 | 5.1.1 | Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана. | - | Боловсон хүчин арга хэмжээний хэрэгжилт | 2019 | 79.1 | 100 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор shilen.gov.mn сайтад нийт 200 байгууллага бүртгэл хийн баталгаажуулж эрх нээлгэж, бүртгэл 100 хувь хийгдсэн. 2025 оны 11 сарын 10-ны байдлаар нийт давхардсан тоогоор 164 байгууллага тайлангаа мэдээллийн системд байршуулсан байна. Ил тод байдлыг хангах, мэдээллийг бүрэн оруулах зорилгоор shilen.gov.mn системийн сургалтыг төрийн 175 байгууллагын 358 албан хаагчид 6 удаагийн давтамжтай зохион байгууллаа. | 90 |
| 88 | 5.1.2 | "Цахим-Алтай" арга хэмжээ хэрэгжүүлж, үйлчилгээний нэгдсэн | - | Үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлэх | 2020 | 52 | 181 | Аймгийн ИТХ-ын 2025.03.31-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Цахим-Алтай хөтөлбөрийг батлуулан үндсэн 4 зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Аймгийн төвд 4 цэг, сумдад 18 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төвөөр үзүүлэх үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ. | | үйлчилгээний төрөл | | | | хурдан цэгээр дамжуулан иргэдэд 43 байгууллагын 453 үйлчилгээг нийт 34158 иргэнд, хуулийн этгээдэд лавлагаа тодорхойлолт гаргаж үйлчиллээ. Аймгийн хэмжээнд 21 киоск машин байршуулан 60 байгууллагын 612 үйлчилгээг авах боломжийг бүрдүүлээ. Аймгийн нэгдсэн эмнэлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай хэрэгцээний киоск машиныг суурилуулснаар эмнэлгийн цаг захиалах, шинжилгээний хариу хэвлэж авах боломжтой боллоо. | |
| 89 | 5.1.3 | Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, сахилга хариуцлагыг сайжруулна. | - | Зөрчил гаргасан албан хаагч | 2019 | 113 | 0 | 25 төрлийн ёс зүйн зөрчил илэрч, холбогдох байгууллагуудаар судлагдан шийдвэрлэгдсэн байна. Төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ойлголт, хандлагыг дээшлүүлэх зорилгоор танхимын болон цахим сургалтад 2440 төрийн албан хаагчийг хамрууллаа.<br>Ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлд үнэлгээ хийж, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээлэл, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлснээр төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн түвшинд тодорхой ахиц гарсан байна. | 70 |
| 90 | 5.1.4 | Сумдыг улсын бүртгэлийн онлайн системд холбох ажлыг үргэлжлүүлнэ. | Төсөл хөт-188.1 | Системд холбосон сум | 2020 | 7 | 18 | Тус ажлын хүрээнд аймгийн 18 сумыг улсын бүртгэлийн онлайн системд бүрэн холбосон. | 100 |
| 91 | 5.1.5 | Төрийн архивыг зориулалтын байртай болгож, тоног төхөөрөмжийг шинэчилнэ. | ОНТ-4.5 | Төрийн архивын байр | - | - | 1 | Төрийн архивын барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.550.0 сая төгрөгөөр “Вентана констракшн” ХХК гүйцэтгэж, ашиглалтад орууллаа. “Цахим-Алтай” хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагуудын архивын хөмрөгийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, архивын үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор 9,7 сая төгрөгөөр тоног төхөөрөмжийг шинэчиллээ. | 100 |
| 92 | 5.1.6 | Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлнэ. | УТ-4,853.4 ОНХС -494.6 | Шинээр барьж, засварлах тохижуулах Засаг даргын Тамгын газрын, багийн төвийн барилга | 2020 | 3 | 9 | 2021 оноос хойш Халиун сумын 3 багийн төвийг шинээр барьж Хөхморьт сумын Хүйсийн говь багийн төв, Цогт сумын 5 багийн төвийг сэргээн засварласан. Аймгийн ОНХС-ийн 494.6 сая төгрөгөөр Бигэр, Шарга, Чандмань, аймгийн ЗДТГ-ын барилгыг 2022 онд засварласан. 2024-2025 оны улсын төсвийн 4,853.4 сая төгрөгийн хөрөнгөөр Баян-Уул, Тайшир сумын ЗДТГ-ын барилгыг буулгаж, шинээр барьж, 2025 онд ашиглалтад хүлээн авлаа. | 100 |
| **Авилгагүй засаглал** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 5.2. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийг дээдэлсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 93 | 5.2.1 | Төрийн үйл ажиллагааны бүх шатанд хуулийн зөв хэрэглээг төлөвшүүлж, авлигыг таслан зогсоох, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэхэд төр, иргэн, иргэний нийгмийн байгууллагуудын мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлнэ. | - | Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээ | 2019 | 68.3 | 80 | Төрийн үйл ажиллагааны бүх шатанд хуулийн зөв хэрэглээг төлөвшүүлж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган, байгууллагуудын мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын хүрээнд “Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ”-г мэргэжлийн хараат бус байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулж, төрийн байгууллагын шударга байдлын талаар судалгааг нийт 165 хүнээс авч Бодлогын шийдэл төрийн бус байгууллагатай хамтран ажиллалаа.<br>2021 онд 60,7, 2022 онд 62,9, 2023 онд 74,1, 2024 онд 72,5, 2025 оны хагас жилийн байдлаар авлигын индексээр 76 хувьтай байна.<br>“Авлигыг үл тэвчье” сэдэвт Нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025.04.14-ны өдөр Аймгийн ХХҮГ болон Нийгмийн Даатгалын газартай хамтран зохион байгууллаа. Шүгэл үлээхийн ач холбогдлын талаар мэдээллийг бэлтгэж иргэдэд гарын авлага брошюр тараан, авлигыг мэдээлэх 110 дугаарыг үйлчилгээний танхимын мэдээллийн самбарт байршуулж, АТГ-аас бэлтгэсэн тв шторк 2, инфографик 1, цахим ном, гарын авлага, контент зэргийг цахим хуудсаар олон нийтэд хүргэлээ. | 90 |
| | | | - | Захиргааны хэм хэмжээний акт | | 14 | 30 | 2022 онд 34, 2023 онд 36, 2024 онд 39, 2025 онд 41 захиргааны хэм хэмжээний акт улсын нэгдсэн санд бүртгэлтэй хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. | |
| 94 | 5.2.2 | Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, зөрчлийг бууруулах, бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлнэ. | - | Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоо | 2020 | 375 | 5000 | Аймгийн хэмжээнд хүний эрхийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/474 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргын дэргэд “Хүний эрх хамгаалах зөвлөлийг” 17 хүний бүрэлдэхүүнтэй, 18 сумын Засаг даргын Тамгын газрын дэргэд “Хүний эрх хамгаалах” зөвлөлийг байгуулан хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зөрчигдсөн тохиолдолд нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ авч ажиллаж байна.<br>Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийг сурталчлах, иргэд олон нийтийг эрэлт хэрэгцээт шаардлагатай мэдээллээр хангах, тэдний хууль зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор жилд 15-20 танхимын сургалт зохион байгуулж, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | авлигын эсрэг уриалсан 32 видео контентыг бүтээж жилд дунджаар 2945 иргэнд хүрч иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүллээ.<br>Мөн Авлигын эсрэг уриалсан видео контентыг бүтээж Миний Алтай сошиал ТВ, Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас, Сүбээдэй.МН сайт, UBS телевизээр иргэдэд түгээн 8,000 иргэний хандалт авсан байна.<br>шинээр батлагдсан хууль тогтоомжууд болон “Төрийн болон албаны нууцын тухай”, “Төрийн болон албаны нууц хамгаалах журам”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцооны тухай ойлголт”, “Хүүхэд хэрэглэгч”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Үндэсний аюулгүй байдлын тухай” “Авлигын эсрэг хууль”, “Төрийн албаны тухай”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай”, “Зөрчлийн тухай”, “Эрүүгийн тухай”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай”,” Цахим гарын үсгийн тухай тухай хууль”, “Хүний эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцооны тухай ойлголт”,”Хуульчийн Про боно” өдөрлөг зэрэг арга хэмжээний хүрээнд 15 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, аймаг, сумын хэмжээнд давхардсан тоогоор 3200 иргэнд эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна. | |
| | | | - | Сумдын эрх зүйн хөтөч | 2020 | 0 | 18 | Аймгийн хэмжээнд нийт 79 эрх зүйн хөтөч чиг үүргийн дагуу ажиллаж, 4,150 хүнд хууль сурталчлах ажлыг зохион байгууллаа.<br>Аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд байрлуулсан эрх зүйн хөтчийн булангийн мэдээллийг 7 хоног бүр шинэчлэн ажиллаж байна. | |
| **Төсөв, санхүү** | | | | | | | | | |
| **Зорилт 5.3: Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, үр ашгийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 95 | 5.3.1. | Төсвийг төлөвлөх хэрэгжүүлэх, тайлагнах бүх үе шатанд иргэдэд нээлттэй байж, шилэн дансны тухай хуулийн | - | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 2020 | 95.75 | 100 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2022 онд 96.97 хувь, 2023 онд 95.24 хувь, 2024 онд 95.31 хувь, 2025 оны 10 сарын байдлаар 96.77 хувьтай байна.<br>2025 оны 10 сарын байдлаар хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн нийт 17 төсөвт байгууллага, сан, нэгдсэн системийн мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан тушаалтнуудад зөрчлийг арилгах чиглэл хүргүүлэн ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтийг хангуулна. | | | | | | | |
| 96 | 5.3.2. | Татварын бааз суурийг өргөжүүлэн, хамрагдалтын түвшинг нэмэгдүүлнэ. | - | Татварт хамрагдалтын түвшин | 2020 | 73 | 78 | Татварт хамрагдалтын түвшин 2021 онд 74%, 2022 онд 75%, 2023 онд 76%, 2024 онд 77%, 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 78 хувьтай байна. | 100 |
| 97 | 5.3.3. | Төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлж, эрсдэлийг бага түвшинд хүргэнэ. | - | Төсвийн хэмнэлт | 2020 | 4.1 | 1 | 2021 онд 9515.5 сая төгрөг буюу 11.6 хувиар, 2022 онд 7084.2 сая төгрөг буюу 13.7 хувиар, 2023 онд 7321.4 сая төгрөг буюу 11.5 хувиар, 2024 онд 19512.1 сая төгрөг буюу 20.3 хувиар, 2025 оны 10 дугаар сарын байдлаар 29.1 хувиар тус тус хэмнэсэн байна. | 100 |
| | | | - | Төрийн сангийн эрсдэлийн үнэлгээ | 2020 | Дунд | Бага | Төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг 18 сум 2 тосгон, аймгийн төрийн сан, нийт 21 нэгжид 20 асуулга бүхий эрсдэл үнэлэх хуудсаар үнэлэхэд эрсдэл 2021 онд 23.8 хувьтай буюу дунд, 2022 онд 23.1 хувьтай буюу дунд, 2023 онд 22.6 хувьтай буюу дунд, 2024 онд 21 хувьтай буюу бага эрсдэлтэй үнэлгэдэж эрсдэлийн түвшин буурсан байна. | |
| | | | - | Хувийн секторын санхүүгийн тайлагнал, хувь | 2020 | 83 | 90 | Аймгийн Аж ахуйн нэгж байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлан 2021 онд 82.3%, 2022 онд 85%, 2023 онд 84%, 2024 онд 83%-ийн ирцтэйгээр цахим системээр хүлээн авч хянан баталгаажуулсан. 2025 оны хагас жилийн тайланг э-баланс системээр 100 хувийн ирцтэйгээр хүлээн авч баталгаажууллаа. | |
| 98 | 5.3.4 | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын менежментийг сайжруулж, алдагдлыг бууруулна. | - | Алдагдал бууруулах хувь | 2019 | 15 | 10 | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой болон улсын төсөвт 10 үйлдвэрийн газар байснаас 2022 онд Гэгээн нуур, 2023 онд Дарив эрчим хүч, Эрдэнэ эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан. Улсын төсөвт 3 үйлдвэрийн газар (Нийтлэг үйлчилгээний газар, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн төв, Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв) аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан ажиллаж байна.<br>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын менежментийг сайжруулж, алдагдлыг бууруулахаар онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг жил бүр аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дүгнэн, цаашид хэрхэн ашигтай ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажилладаг.<br>Орон нутгийн өмчит 4 аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (Солонго дулааны станц, Алтай орон сууцны корпораци, Ундарга-Алтай, Жаргалан сумын Суурин дулаан)-ын 2024 оны онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэхэд 2021 оноос хойш анх удаа ашигтай ажилласан бөгөөд аймгийн өмч хувьчлалын орлогын дансанд тус бүр 1,000,000 төгрөгийг төвлөрүүлээд байна. | |
| **ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ** | | | | | | | | | |
| **Зорилго 6. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |
| **Эх байгаль анхдагч экосистем** | | | | | | | | | |
| **Зорилт 6.1 Экосистемийн чухал ач холбогдол бүхий газар нутгуудыг тусгай хамгаалалтад авч, хамгааллын загвар менежментийг бий болгоно.** | | | | | | | | | |
| 99 | 6.1.1 | Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж 60 хувьд хүргэнэ | | Тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь | 2020 | 57.9 | 60 | Аймгийн нийт газар нутгийн 8,186,884.73 га буюу 58.9 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад аваад байна. Улсын тусгай хамгаалалтад шинээр болон өргөтгөж ангилал ахиулахаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 1,121,419,88 га талбайг улсын тусгай хамгаалалтад авснаар аймгийн нийт газар нутгийн 66,8 хувийг тусгай хамгаалалттай газар нутаг эзлэх юм. | 70 |
| | | | | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ | 2020 | 4784270 | 5184270 | Аймгийн хэмжээнд 14 сумын нутаг дэвсгэрийг дамнан орших 4,784,270.43 га газрыг Улсын тусгай хамгаалалтад авсан нь нийт газар нутгийн 33.8%-ийг эзэлж байна.<br>Хүйсийн говь, Чандмань хайрхан уул, Шаахар толгой зэрэг газруудыг шинээр авах, Хантайширын нуруу, Бурхан буудай уул, Хар азаргын нуруу зэрэг УТХ-д байгаа газруудыг өргөтгөх, ангилал ахиулахаар нийт 1,121,419,88 га талбайн судалгааны ажлыг гүйцэтгэж аймгийн ИТХ-аар дэмжүүлэн БОУӨЯ болон УИХ-аар оруулж батлуулахаар өргөн мэдүүлсэн. Дээрх газруудыг улсын тусгай хамгаалалтад авах шийдвэрийг УИХ гаргасанаар нийт газар нутгийн 5,905,690,31 га талбай буюу 41,7 хувийн УТХ-тай газар эзлэхээр байна. | |
| | | | | Орон нутгийн тусгай хамгаалалттай | 2020 | 3417216 | 3427216 | Аймгийн хэмжээнд 18 сумын 138 нэр бүхий нутаг дэвсгэрт 3,438,035,21 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан нь нийт газар нутгийн 25.1%-ийг эзэлж байна. 2022 онд Тайшир | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | газар нутгийн хэмжээ | | | | сумын Хуримт, Жонгийн нуруу зэрэг 35421.03 га газрыг сум ИТХ-аар хэлэлцүүлэн орон нутгийн тусгай хамгаалалтад авч Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын бүртгэлийн системд бүртгүүлж баталгаажуулж, орон нутгийн ТХГ 3,473,456,24 га болж нийт газар нутгийн 25,2 хувийг ОНТХГ эзэлж байна. | |
| 100 | 6.1.2 | Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн загвар менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, төр хувийн хэвшил төрийн бус байгууллагын түншлэлийн зарчмаар хамгаална. | Төсөл хөтөлбөр-65.7 сая | Менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэн ажиллаж буй улс орон нутгийн тусгай хамгаалалт | 2020 | 3 | 5 | Цогт сумын “Ээж хайрхан уул”-ын УТХГ-ыг хамгаалах менежментийн төлөвлөгөөг ZSL ОУ-ын төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран, Тонхил, Дарив сумыг дамнан орших “Сутай хайрхан” уулын УТХГ-ыг хамгаалах менежментийн төлөвлөгөөг TNC ОУ-ын төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран, Эрдэнэ сумын Зармангийн говийн ОНТХГ, Цогт сумын Гичгэнийн нурууны ОНТХГ, Баянтооройн бүрдийн ОНТХГ-уудыг хамгаалах менежментийн төлөвлөгөөг Ensure ОУ-ын төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран улсын тусгай хамгаалалттай 2, орон нутгийн тусгай хамгаалалттай 3 газрыг хамгаалах загвар менежментийн төлөвлөгөөнүүдийг батлуулан ажиллалаа. Цаашдын хамгаалалтын ажлыг аймаг орон нутаг хариуцан төр, хувийн хэвшил, ТББ, ААН, ОУ-ын төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах жилийн төлөвлөгөө, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| **Байгалийн баялгийн үр өгөөж** | | | | | | | | | |
| **Зорилт 6.2 Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомстлыг бууруулан, ногоон хөгжлийн замаар байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 101 | 6.2.1 | Цөлжилт эрчимтэй явагдаж буй газрууд, төв суурин газарт салхинаас хамгаалах зорилгоор ойжуулах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж 100 га-аас доошгүй талбайд хийж гүйцэтгэнэ. | | Төв суурин газарт салхинаас хамгаалах ойн зурвасын хэмжээ га | 2009-2020 | 139 | 239 | Цөлжилтийг сааруулах, төв сууринг салхинаас хамгаалах зорилгоор 2021, 2022 онд Хөхморьт сумд тус бүр 10га, 2023 онд Хөхморьт сумд 30га, Бигэр сумд 5га, Шарга сумд 3га, Тайшир сумд 7га, 2024 онд Хөхморьт сумд 11га, Цээл сумд 10га, Бигэр сумд 50га, Шарга сумд 10га, 2025 онд Хөхморьт сумд 15 га-д 8 төрлийн 86500 ширхэг мод тарьж салхинаас хамгаалах ойн зурвас байгуулж, 161га-аар нэмэгдүүлэн, хамгаалах ойн зурвасын талбайг 300 га-д хүргэлээ. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 102 | 6.2.2 | Төв суурин газрын ногоон байгуулам-жийн усалгаа, арчилгаа хамгаалалтыг цогцоор шийдвэрлэж, амьдралтын хувийг 90-өөс доошгүй хувьд хүргэнэ. | | Төв суурин газрын ногоон байгууламжийн амьдралтын хувь | 2020 | 50 | 90 | Есөнбулаг сумд 2022 оноос хойш 12 байршилд 24га талбайг хашиж хамгаалан 13 ширхэг нөөцийн сав, 11800 метр услалтын систем, 850м усалгааны зөөврийн шаланк, гүн өрмийн 5 ширхэг худгийг гаргаж, 2 худагт нарны өргүүртэй цахилгааны эх үүсвэрийг суурилуулж 33000 ширхэг мод тариаллаа. Усалгаа, арчилгаа хамгаалалтыг 9 албан байгууллагатай гэрээ байгуулан хариуцлагажуулан ажилласнаар ногоон байгууламжийн амьдралтын хувь 94-ээс дээш байна. Жил бүр нөхөн тарилтын ажлыг тогтмол хийж байна. | 100 |
| 103 | 6.2.3 | Заган ой бүхий 10 сумын 1.6 сая га талбайд, ой зохион байгуулалтын судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж үр дүнд үндэслэн нөхөн сэргээх,үржүүлэх, ойжуулах ажлыг хийнэ. | Төсөл хөтөл-бөр 68.0 | Заган ойг нөхөн сэргээх, ойжуулалтын хэмжээ га | 2020 | 3 | 23 | Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд заган ойн сан бүхий 10 сумд загийн тооллого, судалгааны ажлыг ойн мэргэжлийн байгууллага болох “Залуу төгөл” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүллээ. Тооллого судалгааны үр дүнд заган ойн тархалтын хэмжээ 383577га талбайгаар нэмэгдэж, шинээр Хөхморьт сумын заган ойн тархалтыг улсын ойн санд бүртгүүлснээр нийт 11 сумын 2048345га талбайд заган ойн сантай боллоо.<br>Судалгааны хүрээнд 31,706 га-д заган ой доройтсон, сийрэгжсэн газарт ойжуулалт хийх, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх боломжтой гэсэн дүгнэлтийг үндэслэн байгалийн сэргэн ургалтыг дэмжих зорилгоор Эрдэнэ сумд Unsure төслийн хүрээнд 20га талбайг хашиж хамгаалах, ботоготой тарицаар 2 га талбайд 5000 ширхэг заг тарих ажлыг хийж гүйцэтгэн 90 хувьтай ургаж байна. 2024 онд Цогт сумд 5га талбайд бортоготой тарицаар заг 3000 ширхэг, хармаг 1000 ширхэг тарьж ургалт 85 хувьтай, Алтай сумд 2023 онд 8 га талбайд 20000 ширхэг заг тарих ажлыг “Ажийн харуул” ТББ гүйцэтгэж ургалт 90 хувьтай, Цогт сумын “Ээж хайрхан” уулын отголох цэгийг түшиглэн үрээр 8 сая загийг ургуулах туршилтын ажлыг зохион байгуулж, ургалт 10 хувьтай, Японы хөрөнгө оруулалтаар 10000 ширхэг заг 2500 ширхэг сухай 2500 ширхэг тоорйо тарих ажли хийгдсэн. Аймгийн хэмжээнд нийт 33 га талбайд 843000 ширхэг заг ургаж байна. | 100 |
| 104 | 6.2.4 | Шинэсэн ойд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг 15 га талбайд, ойн хөнөөлт шавж өвчинтэй тэмцэх ажлыг 1900 га талбайд, ойн | - | Байгалийн сэргэн ургалтын хэмжээ га | 2020 | 4 | 19 | Халиун сумын Гүү бариач багийн “Бугын толгойт”-д 2000га шинэсэн ойн талбайд сийрэгжилт, доройтлын судалгааг хийж, “Өвгөн овоо” нэртэй газарт 10 га талбайг хашиж хамгаалан, нийт 14 га талбайд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг хийж гүйцэтгэлээ. | 90 |
| | | | | Ойн хөнөөлт шавж хортонтой | 2020 | 1900 | 3900 | 2023, 2025 онд хөнөөлт шавж хортны судалгааны ажлыг аймгийн хэмжээнд байгаа шинэсэн ойн 10450 га талбайгаас | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цэвэрлэгээний ажлыг 500 га талбайд зохион байгуулна. | | тэмцэх ажил хийсэн талбайн хэмжээ га | | | | 5400 га талбайд "Мөнх ногоон жодоо" ХХК-аар гэрээ байгуулан гүйцэтгүүллээ. Судалгаагаагаар 3500 га талбайд "Шилмүүс хуулигч" хортон илэрч, 2024 онд Халиун сумын Хантайширын нуруунд 1000 га, 2025 онд Жаргалан сумын Хасагт хайрханы нуруунд 2500 га талбайд микробиологийн аргаар тэмцлийн ажлыг хийлээ. Ойн хөнөөлт шавж хортонтой тэмцэх ажил хийсэн нийт талбайн хэмжээг 5400 га-д хүргэлээ. | |
| | | | | Ойн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан талбайн хэмжээ | 2020 | 1400 | 1900 | Ойн цэвэрлэгээ хийх талбайн хэмжээг жил бүр аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж 2020 онд 23 га , 2022 онд 21га , 2023 онд 18га, 2024 онд 17 га 2025 онд 13 га нийт 94 га талбайд ой цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж нийт 290м3 мод цэвэрлэх ажлыг 322 нутгийн иргэд, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлэн. Жаргалан сумд 93 м3, Халиун сумд 117м3, Есөнбулаг сумд 99м3 бэлтгэж орон нутгийн төсөвт 4,891,190 төгрөг төвлөрүүлсэн. | |
| 105 | 6.2.5 | Монгол бөхөнг Улаан шалын хойлойд Халиун бугыг Хантайширын нуруунд, Монгол тарвагыг Шарга, Баян-Уул, Есөнбулаг сумдад сэргээн нутагшуулах ажлыг үе шаттай зохион байгуулна. | Хувийн хөрөнгө оруулалт-10.0 сая, | Нутагшуулсан бөхөнгийн тоо толгой | 2020 | 0 | 100 | ДБХСангийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран Монгол бөхөнг хамгаалах сүлжээ багийг байгуулж хяналт шалгалтыг сайжруулснаар Монгол бөхөнгийн тоо толгой 2024 оны жилийн эцсийн тооллогоор 23,000 хүрсэн байна. Бөхөнгийн тоо толгой өссөнөөр түүхэн тархац нутгаа тэлж Халиун сумын хойд, урд хэсэг Бигэр сумын Улаанявар хүртэл 55км газар нийт 1500$км^2$ хавтгай дөрвөлжин нутагт 5 сүргийн 138-260 толгой Монгол бөхөн шинээр байршиж тархац нутгаа тэлж байна. 2026-2027 онуудад бөхөнгийн тархац Улаан шалын хоолойд хүрч нутагших боломжтой байна. | 100 |
| | | | | Нутагшуулсан тарвага тоо толгой | 2020 | 0 | 200 | 2022, 2023, 2025 онуудад Баян-Уул сумд 160 толгой, 2024, 2025 онд Есөнбулаг сумд 100 толгой, 2024 онд Тайшир сумд 50 толгой, нийт 310 толгой тарвагыг сэлгэн болон сэргээн нутагшуулж хамгаалалтын ажлыг сайжруулснаар 900-1000 тоо толгой болж өссөн нь мониторинг судалгаагаар тогтоогдлоо. | |
| | | | | Нутагшуулсан буга тоо толгой | 2020 | 40 | 100 | Халиун сумын Гүү бариач багийн нутаг Хантайширын нуруунд Халиун бугын цус сэлбэх, үржил сайжруулах зорилгоор "Алтай халиун буга" ТББ-тай хамтран Төв аймгийн Хустайн нуруунаас нийт 53 бугын илийг нутагшуулснаар нийт бодгалийн 86 хувь буюу 45 толгой буга байгальд амьдараа гарч үржлийн сүрэг үүсгэн амжилттай нутагшсан бөгөөд нөөцийн үнэлгээний тойм байдлаар Хантайширын нуруунд 200 гаруй буга байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 106 | 6.2.6 | Сумдад хийгдсэн агнуур зохион байгуулалтын нарийвчилсан төлөвлөгөөний дагуу агнуурын бүс нутгийг шинээр ашиглана. | - | Ашиглаж буй агнуурын бүс тоо | 2020 | 6 | 8 | Агнуур зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, судалгааг батлуулан ажилласнаар агнуурын 7 бүс нутгийг шинээр нэмж нийт 10 сумд 13 агнуурын бүстэй боллоо. Агнуурын бүс нутгуудад аймгийн хэмжээнд 2 толгой угалз, 20 толгой тэх агнуулж, орон нутгийн төсөвт 322,9 сая төгрөг төвлөрүүллээ. | 100 |
| 107 | 6.2.7 | Элсний нүүлт эрчимтэй явагдаж буй Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдын 20-иос доошгүй га талбайд элсний нүүлтийг сааруулах механик хамгаалалтыг турших, нүүсэн үржил шимгүй элсийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг судална. | | Элс бэхжүүлэх механик хамгаалалт хийсэн талбайн хэмжээ га | 2020 | 20 | 40 | 2021-2022 онд элсний нүүлт цөлжилтөд өртөж буй Хөхморьт сумын Сангийн далай нуурын зүүн хойд талын манханд 2 га, сумын төвийн зүүн хойд хэсэгт 3 га, Гүн нуурын хойд талын манханд 2 га, Жаргалан сумын Эрээн нуурын хойд манханд 2 га нийт 9 га талбайд байгалийн гаралтай материал буюу сулийн иш, нуурын зэгс, хөх шавар, байгальд ээлтэй эко тороор элс тогтоон барих механик хамгаалалтын ажлыг Монгол элсний улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, сумын иргэдтэй хамтран хийж гүйцэтгэн, элс бэхжүүлэх механик хамгаалалт хийсэн талбайн хэмжээг 29 га-д хүргэлээ.<br>2025 онд “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн санхүүжилтээр Хөхморьт сумд 90га талбайд элсний механик хамгаалалтын ажлыг хийж гүйцэтгэх сонгон шалгаруулалт хийгдэж байна. | 70 |
| 108 | 6.2.8 | Газрын доройтол, цөлжилтийн нөлөөл-лөөс тархац нь багассан суль, цулхир, хармаг зэрэг ашигт ургамлыг Хөхморьт, Шарга, Цогт, Эрдэнэ сумдад 20-иос доошгүй га талбайд тарималжуулан, нөхөн тарих замаар хөрсний үржил шимийг нэмэгдүүлэн, эдийн засгийн эргэлтэд оруулна. | УТ-77.5 Төсөл хөтөл-бөр-ХХО-16.0 | Ашигт ургамал тариалсан талбайн хэмжээ га | 2020 | 13 | 33 | 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр Хөхморьт сумын газрын доройтол, цөлжилтийн нөлөөгөөр тархац нь хомсдож сийрэгжсэн 10 га талбайд хайс хамгаалалт хийн, усалгааны хэрэгслүүдийг суурилуулж, ашигт ургамал болох суль, сульхирийг үрээр тариалах ажлыг “Бодонгийн ам” ХХК-аар гэрээ байгуулан гүйцэтгүүллээ.<br>2022 онд НҮБ-ын “ENSURE” төслийн санхүүжилтээр Эрдэнэ сумын Зармангийн говь, Цогт сумын Хаягийн услалтын системийг түшиглэж 5 га талбайд хармагийг лабораторийн нөхцөлд эд эсвэрийн аргаар үржүүлэн, үрслүүлж, хээрийн нөхцөлд тарималжуулах ажлыг “Дэлгэрэх Консалтинг” ХХК, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнтэй хамтран гүйцэтгэлээ.<br>2025 онд Хөхморьт сумын “Арвин хишиг булаг” хоршоо 5 га талбайд суль, сульхир тарих ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ.<br>Нийт 20 га талбайд ашигт ургамал тарималжуулснаар талбайн хэмжээг 33 га-д хүргэж, нутгийн иргэдэд эзэмшүүлэн эдийн засгийн эргэлтэд оруууллаа. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 109 | 6.2.9 | Дэд бүтэц, уул уурхай, хууль бусаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагаанаас болж эвдэрсэн газрын хэмжээг нөхөн сэргээлт хийх замаар үе шаттайгаар бууруулна. | ОНТ-71,5 ХХО-1.147,5 | Эвдрэлд орсон талбайн хэмжээ | Эвдрэлд орсон талбайг буурсан дүнгээр тооцно | 310.46 | 230.46 | Аймгийн хэмжээнд дэд бүтэц, уул уурхай, хууль бусаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 142.97 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэснээр эвдрэлд орсон талбайн хэмжээ 167,49 га болж буурлаа. Дээрх нөхөн сэргээлтийн ажилд орон нутгийн төсвөөс 71,5 сая, аж ахуйн нэгж байгууллагаас 1.147,5 сая, бичил уурхайчдаас 100,2 сая, нийт 1.319,3 сая төгрөг зарцууллаа. | 100 |
| | | | | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн талбайг нөхөн сэргээсэн хэмжээ | Өссөн дүнгээр тооцно. | 104.45 | 128.45 | 2021 онд Есөнбулаг сумын нутагт Зүүн сайрын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлж буй “Болдгянтболд” ХХК 1 га, 2024 онд Тонхил, Бугат сумын нутагт Бөөрөгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлж буй “Цогт эрин транс” ХХК 23,26 га, нийт 24,26 га талбайд нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэснээр уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн талбайг нөхөн сэргээсэн хэмжээг 128,71 га-д хүргэлээ. | |
| | | | | Хууль бус ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн талбайг нөхөн сэргээсэн хэмжээ | Өссөн дүнгээр тооцно | 97.64 | 147.64 | Аймгийн хэмжээнд хууль бусаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдрэлд орж орхигдсон 162.43 га талбайгаас 2021 онд 9.66 га, 2022 онд 14.13 га, 2024 онд 30.16 га, 2025 онд 33.11 га, нийт 87.06 га талбайд “Хан-Алтай Ресурс” ХХК, “Болдгянтболд” ХХК, “Цэнгазар” ХХК, “Сэкер ресорсус монголиа” ХХК-ууд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд, “Алтайн бичил уурхайчдын эв нэгдлийн холбоо” ТББ-ууд орон нутгийн төсөв, нийгмийн хариуцлагын гэрээ, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хүрээнд техникийн нөхөн сэргээлийг стандартын дагуу хийж хүлээлгэн өгсөн. Нийт 184,7 га талбайг нөхөн сэргээсэн байна. | |
| | | | | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээсэн хэмжээ | Өссөн дүнгээр тооцно | 52.77 | 58.77 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, дэд бүтэц бүтээн байгуулалтын улмаас 58.34 га талбай эвдрэлд орсноос 2021 онд 17.25 га, 2022 онд 14.4 га нийт 31.65 га талбайд хариуцагч аж ахуйн нэгжүүд болох “Алтайн хүдэр” ХХК, “Хан Алтай ресурс” ХХК, “Макс рөүд” ХХК-ууд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж хүлээлгэн өгсөн. Нийт 84,42 га талбайг нөхөн сэргээсэн байна. | |
| **Үнэт баялаг ус** | | | | | | | | | |
| **Зорилт 6.3 Усны нөөц эх үүсвэрүүдийг тогтоон, гадаргын усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усыг бохирдол хомсдолоос хамгаалан сумдын хүн амын ундны цэвэр усны хангамжийн асуудлыг шийдвэрлэж, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 110 | 6.3.1 | Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг хийж, нөөцийг тогтоон ундны усны чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангах бодлогыг олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | УТ-792,0 Төсөл хөтөлбөр-200,0 ХХО-190,0 | Хүн амын усан хангамжийн нөөц тогтоогдсон сум | 2020 | 1 | 2 | Улсын төсвийн 192,0 сая төгрөгөөр Цогт сумд 2021 онд, 600,0 сая төгрөгөөр Төгрөг сумд 2024 онд хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг хийж, нөөцийг тогтоолголоо. Цогт сумын төвийн газрын доорх усны ашиглалтын цооногуудын бодит ундарга 13.0л/с (1132.2 $м^3$/хоног), Төгрөг сумын ашиглалтын 2 цооног, мониторингийн 4 цооног өрөмдөж, ашиглалтын 2 цооногийн бодит ундрага нийт 5 л/с (432 $м^3$/хоног) хэмжээний нөөцтэй гэж тогтоогдсон.<br>2021 онд Алтай сумд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй “Эф Ви Эс Пи” ХХК Төхөмийн хөндий, Тооройн хоолойн 20 км радиус талбайд газар доорх усны эрэл хайгуул хийж, үйлдвэрлэлийн В+С зэргээр 30 л/сек (2592 $м^3$/хоног) хэмжээний нөөцтэй гэж тогтоогдсон.<br>2022 онд Есөнбулаг сумд ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа “Хан-Алтай ресурс” ХХК Наран багийн Улцангийн даваа, Хавчиг ус нэртэй газруудын 6 цэгийн 1 км радиус талбайд газрын доорх усны эрэл хайгуул хийж, үйлдвэрлэлийн В+С зэргээр 80.0 л/сек (6912 м3/хоног) ашиглах боломжит усны нөөцтэй гэж тогтоогдсон. | 100 |
| 111 | 6.3.2 | Хот, суурин газрын усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулж, усны нөөц бохирдож, хомстохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | УТ-2.463,0 БХНСЗ-130,4 Төсөл хөтөлбөр 17,6 | Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоосон талбайн хэмжээ | 2020 | 1 | 6 | Цогт сумын Төгрөг гол, Цээл сумын Цээл гол, Усан эхийн рашаан, Чандмань сумын Хүрхрээ гол, Халиун сумын Халиун гол, Төгрөг сумын Төгрөг гол, Эрдэнэ сумын Хар толгойн гол, Дарив сумын Ихэс гол зэрэг 8 голын усны сан бүхий 20,000$м^2$ талбайг хашиж хамгаалан, 42 ширхэг мэдээллийн самбар байршуулж, гадны нөлөөлөлд өртдөг 12 хэсэг газарт загон татаж хаалт хийлээ. Тайшир сумын Завхан гол, Гэгээн нуур, Жаргалан сумын Ажиг нуур, Шарга сумын Талын Хүрхрээ, Хөхморьт сумын Гүн нуур, Сангийн далай зэрэг 2 гол, 4 нуурын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийн дагуу тус бүр 3, нийт 18 ширхэг мэдээллийн самбарыг байршууллаа. Дээрх ажлуудыг Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал 130,4 сая төгрөгөөр гүйцэтгэлээ. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эрүүл ахуйн бүс шинээр тогтоосон сум | 2019 | 14 | 18 | Аймгийн хэмжээнд төв суурингийн хүн амын ундны эх үүсвэр болох 44 худаг байдгаас 34 худаг нь эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж, онцгой хамгаалалтын бүс тогтоож хайс хамгаалалт тэмдэгжүүлэлт хийгдэж дэглэм мөрдүүлсэн байдаг. Халиун, Төгрөг, Цээл, Алтай, Чандмань, Эрдэнэ, Тонхил, Жаргалан, Дарив сумдын 9 худагт эрүүл ахуйн хамгаалалтын бүс шинээр тогтоож дэглэмийг мөрдүүлснээр төв суурингийн 12,000 орчим иргэдийг эрүүл аюулгүй цэвэр усаар хангах боломж бүрдлээ. Төв суурингийн 44 ундны эх үүсвэр болох худгуудад онцгой хамгаалалтын бүс тогтоож, хайс хамгаалалт, тэмдэгжүүлэлт, эрүүл ахуйн дэглэм мөрдүүлэх ажил 100 хувь хийгдэж дууссан. | |
| | | | | Ундны найдвартай эх үүсвэртэй болсон сум | 2020 | 2 | 4 | НҮБ-ын Хүүхдийн сангийн “Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөр” төслийн хүрээнд Бугат, Тайшир сумдад ундны эх үүсвэрийн тус бүр 1 худагт ус зөөлрүүлэх төхөөрөмжийг 17,6 сая төгрөгөөр суурилуулж ашиглалтад оруулснаар 1500 гаруй иргэн ундны усны найдвартай эх үүсвэрээр хангагдсан.<br>“Сумдын шинэчлэл-хөдөөгийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд Халиун сумын ундны усан хангамжийн дэд бүтцийн ажлыг улсын төсвийн 2.463,0 сая төгрөгөөр голын эхээс 5.3 км ган хоолойгоор сумын төврүү ус татаж 1000 гаруй иргэн ундны усны найдвартай эх үүсвэрээр хангагдаж байна. | |
| 112 | 6.3.3 | Хөрсний үржил шим, чийгийг ойн зурвас, хөв цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хаших замаар хамгаална. | ОНТ-33,9 БХНСА ХЗ-220,0 Төсөл хөт-2.044,0 ХХО-144,2 | Хашиж хамгаалсан булаг шанд тоо | 2020 | 169 | 194 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/72 захирамжаар батлагдсан булаг шандны эхийг хашиж хамгаалах загвар, аргачлалын дагуу булгийн эхийн талбайн хэмжилтийг хийж булаг хаших материалыг тооцоолон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 220,0 сая төгрөгөөр 16, Дэлхийн байгаль хамгаалах сангийн төслийн 1.954,0 сая төгрөгөөр 57, Ensure төслийн 90,0 сая төгрөгөөр 10, малчдын 3,6 сая төгрөгийн хандиваар 1, орон нутгийн төсвийн 33,9 сая төгрөгөөр 2, ААНБ-ын 140,6 сая төгрөгөөр 9, ИННЗ төрийн бус байгууллагын 5,0 сая төгрөгөөр 1, нийт 96 булгийн эхийг хашиж хамгаалан, эзэнжүүлж гэрчилгээ олгосон булгийн эхийн тоо 265 боллоо. | 100 |
| | | | УТ-90,0 ОНТ-98,0 Төсөл хөт-106,0 | Шинээр байгуулсан хөв цөөрөм тоо | 2020 | 52 | 57 | Бигэр сумын Ихэр, Төгрөг сумын Далан түрүү, Дарив сумын Мараат, Чандмань сумын Ширээгийн ус, Эрдэнэ сумын Хөтөл ус, Буурын хяр, Чонын довон зэрэг газруудад 7 хөв цөөрөм шинээр байгуулж 15,100 м3 гадаргын ус хуримтлагдан бэлчээрийн усан хангамж нэмэгдэж, байгуулсан хөв цөөрмийн тоо 59-д хүрлээ. | |

| Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 6.4 Орчны бохирдлыг бууруулах зорилгоор байгальд ээлтэй хэмнэлттэй, дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.** | | | | | | | | | |
| 113 | 6.4.1 | Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах цогц үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ. | - | Эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн цэг тоо | 2020 | 16 | 20 | Аймгийн хэмжээнд 18 сум 2 тосгонд хог хаягдлын төвлөрсөн 20 цэг байна. Ашиглаж байгаа төвлөрсөн хогийн цэгүүдийг эрүүл ахуй, стандартыг шаардлагад нийцүүлэх ажлын хүрээнд 2021 онд Бугат, 2022 онд Бигэр, 2024 онд Тонхил, Төгрөг, Шарга, Эрдэнэ, 2025 онд Тайшир, Хөхморьт, Цээл, Цогт сумууд хогийн цэгүүдээ хумьж, талбайн хэмжээг багасган, хайс хамгаалалт, загон татлаа. | 70 |
| | | | | Хог хаягдлыг нягтаршуулах үйлдвэр тоо | 2020 | 0 | 1 | Аймгийн хэмжээнд 2021 оноос хойш дахивар хог хаягдал цуглуулдаг 1 иргэн, 2 аж ахуйн нэгжийн 3 цех, дахин боловсруулах 1 жижиг үйлдвэр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байна. Жилд 160 тн дахиврыг үйлдвэр дээр дахин боловсруулж, хашаа хамгаалалтад ашиглах шонгийн хөл, бохирын худгийн таг зэргийг үйлдвэрлэж байна. Дээрх 3 цех, 1 үйлдвэрийн үйл ажиллагааг тогтмолжуулах, өргөтгөх, дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны буцалтгүй санхүүжилтээс 60,0 сая төгрөгийн дэмжлэг, БОУАӨЯ-аас 8тн-ын хүчин чадалтай нягтаршуулах болон бутлах төхөөрөмжөөр хангалаа.<br>Хог хагдлыг нягтаршуулах үйлдвэрийн үйл ажиллагааг Алтай хотын тохижилт үйлчилгээний газар хариуцан ажиллаж байгаа бөгөөд, 9 ажлын байр шинээр бий боллоо. | |
| | | | | Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах тоо | 2020 | 0 | 3 | Санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай тул хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллуулах боломжгүй байна. | |
| | | | | Шинээр байгуулагдсан хог хаягдлын нэгдсэн цэг тоо | 2020 | 0 | 1 | Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр, Японы ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжсэн “Хот суурин газрын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах нь” төслийн 397,2 сая төгрөгийн санхүүжилтээр Алтай хотын хатуу хог хаягдлыг булшлах 4 га талбайд 2 дугаар зэрэглэлийн 10 жил ашиглах ландфиллийн нэгдсэн хогийн цэгийг шинээр байгууллаа. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 114 | 6.4.2 | Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор жуулчны бааз, төв суурин газрын гэр хорооллын айл өрхүүдийг эрүүл ахуйн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгоно | - | Стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болсон айл өрх тоо | 2019 | 73 | 200 | Аймгийн төвийн 111, хөдөөгийн сумдын 240, нийт 351 айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжүүд өөрийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан эко жорлонтой болсон. | 100 |
| | | | | Стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болсон жуулчны бааз тоо | 2020 | 0 | 3 | Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа амралтын газар, жуулчны бааз-6, сувиллын газар-3, нийт 9 аж ахуйн нэгж байгууллага байгаагаас 4 аж ахуйн нэгж 6 стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж хийж байршуулсан. Үүнд Тайшир сумын Гурван гал амралтын газар ариун цэврийн байгууламж-1, Бигэр сумын Шимт элс сувилал хөрснөөс тусгаарласан эко жорлон-3, Есөнбулаг сумын Хантайширын оргил амралтын газар бага оврын ариун цэврийн байгууламж-1, Тонхил сумын Сутай амралтын газар хөрснөөс тусгаарласан эко жорлон-1 тус тус байгуулж ашиглаж байна. | |
| 115 | 6.4.3 | Төв суурин газрын гэр хорооллын айл өрхүүдэд “Эрчим хүчний хэмнэлттэй Монгол гэрийн дулаалга” шийдлийг нэвтрүүлнэ. | ТХ-1360.0 сая, ХХ-880.0 сая | Монгол гэрийн дулаалга шийдэлд хамрагдсан өрх | 2020 | 50 | 550 | Төв суурингийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангийн "Монгол гэрийн дулаалга” төсөлтэй 2022 он дуустал хамтран ажиллаж гэр хорооллын зорилтот бүлгийн 710 айл өрхийг Чип төсөлд хамруулан Монгол гэрийн дулаалга, зуух агаар сэлгэлтийн багцад хамруулан ажиллалаа. Энэ ажлын хүрээнд нэмэлтээр Есөнбулаг болон бусад сумын гэр хорооллын шугамыг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай болсон тул НҮБ-ын Хүүхдийн сангаас санхүүгийн дэмжлэгээр Баянхайрхан, Индэрт багийн гэр хорооллын шугамыг өргөтгөх, 1000 метр сип кабель татах ажлыг 43,3 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүллээ. | 100 |
| 116 | 6.4.4 | Төв суурин газрын орчны бохирдлыг бууруулах, иргэдийн тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэх зорилгоор сэргээгдэх эрчим хүч, шинэ техник технологид тулгуурласан төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ | ОНХС-5,394.1 | Шинэ техник технологид тулгуурласан төсөл, арга хэмжээ тоо | 2020 | 2 | 4 | “Сумдын шинэчлэл - Хөдөөгийн хөгжил” төсөл арга хэмжээний хүрээнд сумдад 50 м3 хүчин чадалтай бага оврын цэвэрлэх байгууламж барих ажил хийгдэж, Бугат, Шарга, Баян-Уул сумдын цэвэрлэх байгууламжийн ажлыг “Жи голд” ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулаа.<br>Алтай хотын 3000 м3 цэвэрлэх байгууламжийн ажлыг улсын төсвийн 17,732.385.644 төгрөгийн хөрөнгөөр “Сайн констракшн” ХХК, “Сан” ХХК-ийн түншлэл гүйцэтгэхээр гэрээ байгуулж, барилга угсралтын ажил эхлэсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 117 | 6.4.5 | Ус цаг уурын ажиглалтын болон орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийн урьдчилан мэдээллэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, дэвшилтэд технологийг нэвтрүүлж байгалийн гамшгийн эрсдлийг бууруулна. | ОНХС-3.5 сая | Шинээр нэмэгдүүлсэн орчны хяналт шинжилгээний тоног төхөөрөмж | 2020 | 0 | 1 | "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II,III төсөл"-ийн санхүүжилтээр Финланд улсад үйлдвэрлэсэн VAISALA маркийн AWS 310B цаг уурын автомат станцыг Баян-Уул, Бигэр сумд угсарч суурилууллаа.<br>Аймгийн хэмжээнд AWS310R, AWS330, AWS310 маркийн цаг уурын нийт 11 автомат станц ажиллаж байна. | 100 |
| **ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ** | | | | | | | | | |
| **Зорилго 7. Батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | | | |
| **Батлан хамгаалах** | | | | | | | | | |
| **Зорилт 7.1. Батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэн иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | | | |
| 118 | 7.1.1 | Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн, иргэд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад шалган туслах ажлыг зохион байгуулж иргэний цэргийн үүргийн биелэлтийг хангуулна. | - | Дайчилгааны төлөвлөгөө шинэчилсэн сум | 2005 | 18 | 18 | Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний хээрийн дадлага сургалтыг орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж, болон удирдах бүрэлдэхүүний сургалтыг жил бүр зохион байгууллаа.<br>Завхан аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн сумдын ЗДТГ-ын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтад 18 сумын ЗДТГ-ын дарга нар хамрагдаж, тус сургалтаар сумдын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах арга, аргачлалыг зааж, сумын дайчилгааны төлөвлөгөөг боловсруулан батлуулахад бэлэн болсон. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 119 | 7.1.2 | Хүүхэд, залуучуудад, эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, оюутан цэргийн тоог нэмэгдүүлнэ. | - | Зохион байгуулсан арга хэмжээ | 2019 | 2 | 10 | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Эх орон” сэдэвт хэлэлцүүлэг, “Энхийн үйлсэд-Монгол цэрэг” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, “Эх оронч үзэл, үндэсний бахархал”, “Улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо” сэдвээр яриа таниулга хийж, 18 нас хүрсэн иргэдэд цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулж талархал хадгалуулах ажлыг жил бүр зохион байгуулж байна.<br>Олон улсын энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан тус аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас энхийг сахиулах ажиллагаанд оролцсон офицер, ахлагч нар ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад үүрэг гүйцэтгэсэн газар орон болон ёс заншил, энхийг сахиулах ажиллагаа, батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний чиг хандлагын талаар яриа танилцуулга хийх ажлыг жил бүр зохион явууллаа.<br>Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2022”, “Дөл-2023”, “Дөл-2024”, “Дөл-2025” цогцолбор тэмцээнүүдийг 2 үе шаттай зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнд аймгийн баг тамирчид 2022, 2025 онд амжилттай оролцсон. | 90 |
| | | | | Оюутан цэрэг | 2019 | 10 | 70 | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журмын дагуу 2021-2025 онд орон нутгаас нийт 46 оюутан тус хөтөлбөрт хамрагдсан байна. | |
| 120 | 7.1.3 | Барилга-инженерийн цэргийн анги байгуулах асуудлыг шийдвэрлэнэ. | - | Барилга инженерийн цэргийн анги | 2020 | 0 | 1 | Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн 18 га газрыг хашаажуулах ажил бүрэн хийгдэж, 1 болон 2 дугаар шалганы байрыг барьж, гүний худаг гарган, 630 кВт-ын дэд станц барьж, гадна цахилгааны хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, ангийн хугацаат цэргийн алба хаагчийн байрын барилгыг ашиглалтад оруулла.<br>Ажилчдын 50 айлын орон сууц барилгыг 2026 оны 1 дүгээр улиралд ашиглалтад оруулна. | 100 |
| **Хүн, нийгмийн амар тайван байдал** | | | | | | | | | |
| **Зорилт 7.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, нийгмийн дэг журмыг сахиулан, иргэдийн аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | | | |
| 121 | | Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх урьдчилан | - | Өмчлөх эрхийн эсрэг гэмт | 2019 | 20.2 | 15 | 2021-2025 онд нэгдсэн болон хэсэгчилсэн, тусгай 154 арга хэмжээг зохион байгуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 7.2.1 | сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлж, мал хулгайлах, архидан согтуурах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийн гаралтыг бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ. | | хэрэгт мал хулгайлах гэмт хэргийн эзлэх жин | | | | сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 1280 байгууллага, аж ахуйн нэгжийн 121560 хүнд сургалт, мэдээлэл хийж, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж, гарын авлага 525000 гаруй ширхгийг хэвлэн тараан ажилласан.<br>Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7112 мэдээ, мэдээлэл, видео, рийл, постерыг цахим орчинд байршуулан, иргэд олон нийтэд хүргэлээ.<br>Аймгийн хэмжээнд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2021 онд 104, 2022 онд 120, 2023 онд 149, 2024 онд 207, 2025 оны эхний 10 сарын байдлаар 120, мал хулгайлах гэмт хэрэг 2021 онд 8, 2022 онд 27, 2023 онд 20, 2024 онд 11, 2025 оны эхний 10 сарын байдлаар 5 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Нийт дүнгээр өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт мал хулгайлах гэмт хэргийн эзлэх жин 10,1 хувьтай байна. | |
| | | | - | Нийт гэмт хэрэгт согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх жин | 2019 | 23 | 18 | 2021 онд 55, 2022 онд 60, 2023 онд 57, 2024 онд 143, 2025 оны эхний 10 сарын байдлаар 161, нийт 476 гэмт хэрэг согтуугаар үйлдэгдсэн байна. 2021-2025 онд нийт 1483 гэмт хэрэг бүртгэгдэж, нийт гэмт хэрэгт согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх жин 32,1 хувьтай байна. | |
| | | | | Жил бүрийн гэмт хэргийн илрүүлэлт | 2019 | 61.8 | 66 | Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 2021 онд 62.6, 2022 онд 63.2, 2023 онд 61.6, 2024 онд 60.2, 2025 оны эхний 10 сарын байдлаар 63.3 хувьтай байна. | |
| 122 | 7.2.2 | Аймаг, сумдын төвийн гэр хорооллын хяналтын камертай гудамжны тоог нэмэгдүүлнэ. | | Хяналтын камертай гудамж | 2020 | 12 | 62 | Аймгийн хэмжээнд нийт 254 цэгт 379 камер суурилуулснаас хөдөлгөөнт 41, чиглэлийн 266 камер байна. Эдгээрээс 81 камерыг гэр хорооллын гудамжид суурилуулсан байна. | 100 |
| **Гамшгаас хамгаалах** | | | | | | | | | |
| **Зорилт 7.3 Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 123 | 7.3.1 | Гамшгийн бэлэн байдлын бодлого төлөвлөлтийг шинэчилж, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдлийг бууруулах, хор | ОНТ 290.0 | - | - | - | - | Гамшгаас хамгаалах “Иж бүрэн” сургуулийг 12 сумд, гамшгаас хамгаалах “Команд штаб”-ын дадлага, сургуулийг 13 сумд, Засаг даргын нэрэмжит “Бэлэн байдлын үзлэг”-ийг давхардсан тоогоор 45 сумд тус тус зохион байгуулсан. Гамшгаас хамгаалах “Иж бүрэн”, “Команд штаб”-ын дадлага, сургуулийг 6 үе шаттайгаар зохион байгуулж, 70 удаагийн 350 цагийн сургалтад 4255 томилгоот бие бүрэлдэхүүн хамрагдсан. Тус | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уршгийг богино хугацаанд арилгах менежментийг хэрэгжүүлнэ. | | | | | | дадлага, сургуулиудад Засаг даргын нөөц хөрөнгөөс 290.0 сая төгрөгийг зарцуулсан. | |
| 124 | 7.3.2 | Есөнбулаг сумд эрэн хайх, аврах салбар, Цогт сумд эрэн хайх аврах бүлгийг байгуулна. | УТ-138.0 ОНТ-40.0 | Шинээр нэмэгдсэн эрэн хайх, аврах салбар, бүлэг | 2020 | - | 2 | Есөнбулаг сум дахь Эрэн хайх, аврах салбар, Цогт сум дахь Эрэн хайх аврах бүлгийн үйл ажиллагааг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлсэн. Эрэн хайх аврах бүлгийн засварын ажилд Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар 90,0 сая төгрөг, гамшгийн сангаас 10,0 сая төгрөг зарцуулсан. Цогт сум дахь Эрэн хайх, аврах бүлэгт 8, Есөнбулаг сумын Эрэн хайх, аврах салбарт 15 алба хаагчийг ажлын байраар хангалаа. Онцгой байдлын ерөнхий газраас 48,2 сая, орон нутгийн төсвийн 30,0 сая төгрөгөөр Таймшир сумд уулын болон усны дадлага сургалтын төвийг байгуулж, онцгой байдлын газрын албан хаагчдыг чадавхжуулах, бэлтгэл сургуулилт хийх нөхцөл боломжоор хангалаа. | 100 |
| 125 | 7.3.3 | Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлж, техник хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлнэ. | ОНТ-77,0 | - | - | - | - | Онцгой байдлын ерөнхий газраас гамшгаас хамгаалах “команд штаб”ын сургуулийг 1 удаа, “бэлэн байдлын үзлэг”-ийг 1 удаа тус тус зохион байгуулсан. Есөнбулаг сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн 90 албан хаагч 20 сая төгрөгөөр жагсаалын болон мэргэжлийн ангийн жигдрэлтийн хувцас, аранзтай болсон. Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/20 дугаар тушаалаар тоёота ланд круйзер 78 маркийн аврах ажиллагааны автомашин хуваарилсныг хүлээн авч, үндсэн хөрөнгөд бүртгэн данс бүртгэлд тусгаж бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлсэн. | 100 |
| **Мэргэжлийн хяналт** | | | | | | | | | |
| **Зорилт 7.4. Эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийнэ.** | | | | | | | | | |
| 126 | 7.4.1. | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж, иргэдийн эрүүл мэнд нийгмийн болон орчны аюулгүй байдлыг хангана. | - | Барилга угсралтын ажлын чанар, аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ | 2019 | 60 | 40 | Барилгын хяналтаар “Шилэн хяналтын системд 194 объектын эрсдэлийн үнэлгээг хийж нэгдсэн цахим санг бүрдүүлэн, 4 объектыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулснаас 2 дунд, 2 бага эрсдэлтэй үнэлэгдэж, 16 заалт бүхий улсын байцаагчийн 4 албан шаардлага өгч, ажиллалаа. Хуулийн хэрэгжилт 62%, эрсдэл үүсэх магадлал 35%-тай байна. 2025 онд нийт Барилга, хот байгуулалтын яамны 2025 оны 02-00/05 тоот урьдчилан сэргийлэх шалгалт хийх удирдамжийн хүрээнд 8 аж ахуйн нэгж, байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 25 зөрчил дутагдал илрүүлэн, газар дээр нь 14 зөрчил, дутагдал | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>арилгуулж, 14 заалт бүхий 4 албан шаардлага хүргүүлэн ажиллаж, нэг иргэнд шийтгэврийн буюу 1.0 сая төгрөгийн арга хэмжээ авч ажиллаад байна.</td><td></td></tr>
<tr><td colspan="10">НАЙМ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ</td></tr>
<tr><td colspan="10">Зорилго 8. Алтай хот болон сум, суурин газрын дэд бүтэц, хот байгуулалтын асуудлыг шийдвэрлэж,”Сумдын шинэчлэл-хөдөөгийн хөгжил” төслийг хэрэгжүүлнэ.</td></tr>
<tr><td colspan="10">ДЭД БҮТЭЦ: Эрчим хүч</td></tr>
<tr><td colspan="10">Зорилт 8.1. Аймгийн төв болон сумдын цахилгаан, дулааны эрчим хүчний хангамж, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ:</td></tr>
<tr><td rowspan="2">127</td><td rowspan="2">8.1.1</td><td rowspan="2">Алтай хотод баригдах дулааны станцыг ашиглалтад оруулж, 2-р хэлхээний шугам сүлжээг шинэчилж хэрэглээний халуун устай болгоно.</td><td>ОНХС 80,0</td><td>2-р хэлхээний шинэчилсэн шугам сүлжээний тоо</td><td>2020</td><td>23</td><td>20</td><td>Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээ, дэд бүтцийн ажлыг улсын төсвийн 23.9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Одкон холдинг” ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажил эхэлсэн. Гэрээний дагуу 6.1 тэрбум төгрөгөөр 2.4 км шугам сүлжээний угсралтын ажил хийгдсэн. Батсуурийн гудамжны авто замтай огтлолцох хэсгүүдийн дулааны сувгийн ажлыг гүйцэтгэсэн. Хөгжил хорооллын шугамын ажил хийгдэж байна.</td><td rowspan="2">70</td></tr>
<tr><td></td><td>Хэрэглээний халуун ус ашиглаж буй өрхийн тоо</td><td>2020</td><td>120</td><td>1500</td><td>Хэрэглээний халуун ус ашиглаж буй 507 өрх байна. 2026 оны 2 дугаар улиралд ашиглалтад орохоор хүлээгдэж байгаа 700 айлын барилга угсралтын ажил хийгдэж байна</td></tr>
<tr><td>128</td><td>8.1.2</td><td>Сумдын төвийг төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системтэй болгоно.</td><td>УТ 10,336.0</td><td>Төвлөрсөн халаалтын системд холбогдох сум</td><td>2020</td><td>6</td><td>8</td><td>Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хувийн хөрөнгө оруулалтаар сумдыг халаалтын зуух, төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсанаар Баян-Уул, Тонхил сумыг “Аураг даян” ХХК, Цогт, Чандмань сумыг “Хүрд хүч чадал” ХХК-аар тус тус гүйцэтгүүлэн ашиглалтад оруулж, сумдын төр хувийн хэвшлийн байгууллагыг ус, дулаан хангамжид холбож, тохируулгын ажил хийгдээд байна. Хөхморьт сумын ажлыг “Буман хаус” ХХК, Бугат сумын ажлыг “Гүн урлал” ХХК гүйцэтгэн ашиглалтад орууллаа.<br>Улсын төсвийн 2,493.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бигэр сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Сити агро эх” ХХК, улсын төсвийн 10,192.7 сая төгрөгийн хөрөнгөөр Алтай сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамжийн</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төсөл /Говь-Алтай аймаг, Алтай сум/-ийн ажлыг "Тунгалаг говь транс" ХХК, "Билгүүн од констракшн" ХХК гүйцэтгэж, ашиглалтад өгсөн. Нийт 17 сум нэгдсэн халаалтын системд холбогдлоо | |
| 129 | 8.1.3 | Тайшир-Есөнбулаг чиглэлийн 35 кВт-ын ЦДАШ-ыг 110 кВт болгон өргөтгөж аймгийн төв болон сумдын цахилгаан эрчим хүчний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | УТ-7749.0 | Тайшир-Есөнбулаг сумын ЦДАШ-ын хүчин чадал кВт | 2020 | 35 | 110 | Улсын төсвийн 7,7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв хүртэлх 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 110 кВ болгон өргөтгөх ажил хийгдэж байнгын ашиглалтад орууллаа. | 100 |
| 130 | 8.1.4 | Төвлөрсөн суурин газар болон зарим сумдын багийн төвийг байнгын эрчим хүчний эх үүсвэрт холбоно. | - | Байнгын эх үүсвэрт холбогдох багийн төвийн тоо | 2020 | 3 | 5 | Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хувийн хөрөнгө оруулалтаар Баян-Уул, Тонхил сумдыг халаалтын зуух, төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг ”Aураг даян” ХХК, Цогт, Чандмань сумдыг “Хүрд хүч чадал” ХХК- Хөхморьт сумын ажлыг “Буман хаус” ХХК, Бугат сумын ажлыг “Гүн урлал” ХХК-аар тус тус гүйцэтгүүлэн ашиглалтад оруулж, ус, дулаан хангамжид холбон, тохируулгын ажил хийгдлээ. | 100 |
| 131 | 8.1.5 | Алтай хотын гэр хороололд олон тарифт цахилгаан тоолуур суурилуулж, хэрэглэгчдэд ээлтэй уян хатан систем нэвтрүүлнэ | ОНХС-111.0 сая | Тоолуур суурилуулсан өрхийн тоо | 2020 | 3900 | 5000 | Цахилгаан эрчим хүчний хэрэглээг найдвартай, үнэн зөв хянах, хэрэглээг оновчтой тооцоолох зорилгоор сумдын хэрэглэгчдэд 2 тарифт электрон тоолуурын суурилуулалтын ажил үе шаттайгаар хийгдэж байна.<br>Есөнбулаг сумын гэр хорооллын 2010 хэрэглэгчийг ухаалаг тоолуурт шилжүүлэх ажил хийгдлээ. Мөн сумдад 2 тарифт тоолуур суурилуулах ажил хийгдэж байна.<br>Одоогоор Баян-Уул сумын хэрэглэгчдийн тоолуурыг 2 тарифт электрон тоолуураар шинэчлэх ажил амжилттай хэрэгжиж байна. Цаашид бусад 8 сумдад уг шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 132 | 8.1.6 | Алтай хотод 10 мВт-ын нарны цахилгаан станц барьж ашиглалтад оруулна. | АХБ 30.0 тэрбум | Алтай хотод шинээр баригдах цахилгаан эрчим хүчний хүчин чадал /мВт/ | 2020 | - | 10 | Азийн Хөгжлийн банкны 30,0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Төвийн эрчим хүчний системээс алслагдсан аймгуудад Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох зорилгоор хэрэгжиж байгаа төслийн хүрээнд Есөнбулаг сумын 10 МВт нарны цахилгаан станцын барилгын ажлын гүйцэтгэгчээр “М-Си-Эс Интернэйшнл” ХХК шалгаран, станцын барилгын ажил 2022 оны 7 дугаар сараас эхлэн суурь цутгалтын ажил хийгдэж 12 сарын хугацаанд гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж 2023 оны 09 дүгээр сард байнгын ашиглалтад орууллаа. | 100 |
| 133 | 8.1.7 | Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | ТХ 1,078,936 $ | Алтай сумын нарны цахилгаан станцын өргөтгөл кВт | 2020 | - | 300 | Азийн хөгжлийн банкны “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд Алтай сумын нарны цахилгаан станцыг 300 кВт-аар өргөтгөж, цэнэг хуримтлуур болон удирдлагын төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэх” барилга угсралтын ажлыг БНХАУ-ын “Шуангдэнг групп”, Монгол Улсын “ЭСПМ интернэйшнл” ХХК, “Жи Пауэр” ХХК-ууд гүйцэтгүүлэн 2022 оны 06 дугаар сард ашиглалтад хүлээн авлаа. | 100 |
| 134 | 8.1.8 | Алтай сумыг эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болгоно. | - | ЦДАШ-ын өргөтгөл | 2020 | - | 35кВ | Алтай сумын 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, сумын төвд 35/10кВ, 1000кВА-ын дэд станц, 10/0,4кВ-ын 4 ширхэг дэд станц, 0.4 кВ-ын ЦДАШ-ын шинэчлэл шинээр баригдаж БНХАУ-ын импортын эрчим хүчний системд 2025 оны 12 дугаар сард бүрэн холбогдоно. | 100 |
| 135 | 8.1.9 | Аймаг, сумын төвийн 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл шинэчлэл хийж, гэр хорооллын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийг сайжруулна. | Дэлхийн банк | ЦДАШ-ын өргөтгөл шинэчлэлт хийгдсэн сум | 2020 | 5 | 18 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 1,300.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баянхайрхан, Баяншанд, Индэрт багуудын шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг “Жи Би Юу И си” ХХК шалгаран гүйцэтгэж байна.<br>2023-2024 онд Дэлхийн банкны санхүүжилтээр “Эрчим хүчний төсөл-2”-ийн хүрээнд Шарга, Хөхморьт сумдад цахилгаан түгээх сүлжээний шинэчлэлийн ажил бүрэн хэрэгжиж хүлээлгэн өгсөн.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бигэр сумын АТП-01, 02, 03 дэд станцаас гарч байгаа 0.4 кВ-ын агаарын шугамын АС утастай хэсгийг бүрээстэй дамжуулагч бүхий агаарын шугамаар шинэчлэх ажил- 658.8 сая,<br>Эрдэнэ сум шинэ суурьшлын бүсийн айл өрхийн гадна цахилгаан хангамж болон АТП-1 дэд станцыг өргөтгөх ажил-588.9 сая,<br>Бугат сумын АТП-1.2 дэд станцын төмөр хийцийг шинэчлэх, одоо байгаа 0.4 кВ-ын агаарын шугамын АС утастай хэсгийг бүрээстэй агаарын шугамаар солих угсралтын ажил-751.9 сая, | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Тонхил сумын АТП-01, 02 дэд станцын төмөр хийцийг шинэчлэх, одоо байгаа 0.4кВ-ын агаарын шугамын АС утастай хэсгийг бүрээстэй агаарын шугамаар солих угсралтын ажил-1,066.4 сая,<br>Дарив сум шинэ суурьшлын бүсийн гэрэл цахилгаангүй айл өрхүүдийн гадна цахилгаан хангамж 250/10 кВа дэд өртөөний ажил-179.0<br>Дарив сум 100 кВа чадалтай дэд станцын 0.4 кВ-ын ЦДАШ хэсэгчлэн шинэчлэх ажил-133.2 сая,<br>Дарив сум 630 кВа чадалтай дэд станцын 0.4 кВ-ын ЦДАШ хэсэгчлэн шинэчлэх ажил-148.3сая<br>Дэлгэр сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг ЦЭХ-ээр хангах ажил-80.1 сая төгрөгөөр тус тус хийгдэхээр хүлээгдэж байна. | |
| **Зам, тээвэр:** | | | | | | | | | |
| **Зорилт 8.2.Улсын болон орон нутгийн чанартай авто зам, гүүрний засвар, арчлалт, ашиглалт болон тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлнэ:** | | | | | | | | | |
| 136 | 8.2.1 | Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулна. | УТ | Алтай хотын хатуу хучилттай авто замын урт | 2020 | 25 | 35 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй Аймгийн төвийн 10 км хатуу хучилттай авто замын ажлыг 9,964.3 сая төгрөгөөр “Түм дэлгэрэх” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд тайлант үеийн байдлаар 4.3 км замын хучилт хийгдсэн.<br>2023-2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн 4,474.0 сая төгрөгөөр аймгийн төв талбайг тохижуулж, түүний дагуух Жанчивын гудамжийг 3 болон 4 эгнээ 2 км хатуу хучилттай автозам болгон өргөтгөж, явган зам, ногоон байгууламж, ус зайлуулах далд байгууламжийг цогцоор нь хийхээр зураг төслийг “Нью товер” ХХК, “Кадсүрвэй” ХХК-аар тус тус гүйцэтгүүлэн бүтээн байгуулалтын ажлыг Зэвсэгт хүчний 341 дүгээр цэргийн ангитай гэрээ байгуулж ашиглалтад оруууллаа.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх зам, Хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг, Хөгжил хорооллын доод талаас 3, 4 дүгээр гудамжны хатуу хучилттай авто зам тавих ажлыг “Сакот импорт” ХХК гүйцэтгэж 600м, аймгийн төвийн 15,6 км хатуу хучилттай авто замын ажлыг “Бумбат даваа” ХХК гүйцэтгэж 10 км замын далангийн ажил, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Батсуурийн гудамжны тохижилт шинэчлэлтийн ажлын хүрээнд "Гранд мөнх буурал" ХХК 575м авто замын хучилтыг гэрээнд заасны дагуу тайлант онд хийж гүйцэтгэлээ. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 137 | 8.2.2 | “Дугуйн болон явган хүний зам” төслийг хэрэгжүүлнэ. | ОНТ-753.9 АОНЗС-300.0 | Алтай хотын дугуйн замын урт | 2020 | 8.9 | 10 | “Хөгжлийн гудамж” төслийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн 68.9 сая төгрөгийн санхүүжилтээр Алтай хотын төв Хасагт хайрхан 4,75 км, Жанчив 1.33 км, Батсуурь 0.67 км, Хантайшир 1.3 км, Ардчиллын 1.33 км, Барилгачдын 0.77 км, Лодойдамбын 0.56 км, Хөгжлийн гудамж 1.03 км нийт 8 гудамжны явган зам, төв болон нийтийн эзэмшлийн талбай, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, услалтын систем, цас болон борооны ус зайлуулах суваг, инженерийн шугам сүлжээг шинэчлэх ажлын зураг төслийг “Нью товер” ХХК-аар гүйцэтгүүллээ.<br>Тус төслийн хүрээнд 2023-2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн 4,474.0 сая төгрөгөөр аймгийн төв талбайг тохижуулж, түүний дагуух Жанчивын гудамжийг 3 болон 4 эгнээ 2 км хатуу хучилттай автозам болгон өргөтгөж, явган зам, ногоон байгууламж, ус зайлуулах далд байгууламжийг цогцоор нь хийхээр зураг төслийг “Нью товер” ХХК, “Кадсүрвэй” ХХК-аар тус тус гүйцэтгүүлэн бүтээн байгуулалтын ажлыг Зэвсэгт хүчний 341 дүгээр цэргийн ангитай гэрээ байгуулж ашиглалтад оруууллаа.<br>Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Батсуурийн гудамжны тохижилтын ажлын гүйцэтгэгчээр “Гранд мөнх буурал” ХХК шалгаран суурийн ажил болон хашлага, явган замын хийгдэж байна.<br>Лодойдамбын гудамжны тохижилтын ажлын гүйцэтгэгчээр “Гуулин зам” ХХК, Ардчилалын гудамжны тохижилтын ажлын гүйцэтгэгчээр “Сакод импорт” ХХК тус тус шалгаран гэрээ байгуулан явган зам, авто замын бродюр тавих ажил хийгдэж байна. | 100 |
| 138 | 8.2.3 | Алтай хот-Бургастайн боомт чиглэлийн 320 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг эхлүүлнэ. | УТ-2,150.5 | хатуу хучилттай авто замын урт | 2020 | - | 320 | Алтай хот-Бургастайн боомт чиглэлийн 253 км хатуу хучилттай автозамын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг “Эс ар фи инженеринг” ХХК гүйцэтгэлээ. | 30 |
| 139 | 8.2.4 | Алтай-Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг барьж, ашиглалтад оруулна. | УТ | хатуу хучилттай авто замын урт | 2020 | - | 194 | АХБ-ны зээлийн хөрөнгөөр “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын 3 -р үе шатны төсөл”-ийн хүрээнд хэрэгжих “Улиастай - Алтай чиглэлийн 178 км авто замын эхний хэсэг болох Улиастай – Цагаанхайрхан чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам барих ажлын гүйцэтгэгчээр “China Jiangsu International Economic and Technical Cooperation Group, LTD”-тай гэрээ байгууллаа. Алтай-Тайшир чиглэлийн 70 км хатуу | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хучилттай авто замын ажлын зураг төслийг “ХЗТ авто зам” ХХК гүйцэтгэн магадлалаар хянагдаж байна. | |
| 140 | 8.2.5 | Алтай хотод “Автовокзал”-ын барилгыг шинээр ашиглалтад оруулж тээврийн үйлчилгээг сайжруулна. | - | “Автовокзал”-ын барилга | 2020 | - | 1 | Зорчигч тээврийн авто үйлчилгээний төвийн барилгын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зарласан бөгөөд гүйцэтгэгчээр 3244.7 сая төгрөгөөр “Мөрөн-Алтай” ХХК шалгарч барилга угсралтын ажил 50 хувьтай хийгдэж байна. | 50 |
| 141 | 8.2.6 | Алтай хотын төвийн хатуу хучилттай автозамын үерийн ус зайлуулах байгууламжийг шинээр бий болгоно. | - | Авто замын үерийн ус зайлуулах байгууламж км | 2020 | - | 10 | Алтай хотын 10,3 км үерийн хамгаалалтын барилга байгууламжийн зураг төслийг “Эм Ти Эс гидро инженеринг” ХХК боловсруулж, 2024.09.25-ны өдрийн 1778/2024 дугаар магадлалын дүгнэлтээр баталгаажсан. Тус ажлын 30,923.6 сая төгрөгийн төсөвт өртгөөс 2026 оны улсын төсөвт 5,0 тэрбум төгрөг тусгагдлаа. 2023-2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн 4,474.0 сая төгрөгөөр аймгийн төв талбайг тохижуулж, түүний дагуух Жанчивын гудамжийг 3 болон 4 эгнээ 2 км хатуу хучилттай автозам болгон өргөтгөж, ус зайлуулах далд байгууламжийг байгуулах ажлыг Зэвсэгт хүчний 341 дүгээр цэргийн ангитай гэрээ байгуулж, гүйцэтгүүллээ. | 50 |
| 142 | 8.2.7 | Орон нутгийн чанартай авто зам, гүүрийн байгууламжийн засвар арчлалтыг үе шаттайгаар гүйцэтгэнэ. | УТ-8,928.0 сая | Гүүр | 2020 | - | 1 | Шарга сумын нутаг Ээвийн голын 66,24 у/м төмөр бетон гүүрийн барилгыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Тоёо” ХХК гүйцэтгэн 2022 онд ашиглалтад оруулсан.<br>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Шарга сумын Баянголын гүүрийг засварлах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зарласан. Улсын төсвийн 8,928.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Жаргалан сумын Бүрэн багийн гүүрийг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчээр “Эвт уул” ХХК шалгаран гүүрийн далан, суурийн ажил хийгдсэн. | 100 |
| **Мэдээлэл, харилцаа холбоо** | | | | | | | | | |
| **Зорилт 8.3.Мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлнэ:** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 143 | 8.3.1 | Алтай сум, Баянтоорой тосгоныг өндөр хурдны интернетийн шилэн кабелийн сүлжээнд холбож, интернетийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэнэ. | - | Шилэн кабельд холбогдсон сум, тосгоны тоо | 2020 | 18 | 20 | Өндөр хурдны интернетийн сүлжээ ашиглалтад орсноор Алтай сум, бургастай боомтод байрлан үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон ААН байгууллага ард иргэд мэдээ мэдээллийг цаг алдалгүй авч, өгдөг болсон.<br>Сумын ЗДТгазар, Улсын бүртгэлийн газар, Хилийн цэргийн анги, сургууль, цэцэрлэг гэх мэт алба хэлтсүүд, Бургастай боомт дээр үйл ажиллагаа явуулж байгаа гаалийн хэлтэс, Хил хамгаалах ерөнхий газар, “Алтай Ложистик” ХХК, үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгч Мобиком, Юнитель зэрэг байгууллагууд шилэн кабелийн урсгал авч Сум, боомт, багуудад суурилагдаж байгаа сайтууд нь 3G, 4G сүлжээгээ оруулан үйл ажиллагаагаа хэвийн найдвартай явуулж байна | 50 |
| 144 | 8.3.2 | Өндөр хурдны телевизийн сигнал дамжуулах “IPTV” технологи сумдад нэвтрүүлнэ. | - | “IPTV” технологи нэвтэрсэн сум, тосгон | 2020 | 1 | 3 | Есөнбулаг сумын Индэрт, Баяншанд, Баянхайрхан, Харзат, Жаргалант, Түмэн багуудын Булаг, Засагт хан, Найрамдал, Сутай, Толгойт, Ундарга, Хайрхан, Шанд, Шүтээн хорооллын 3200 гаруй айл өрхүүдэд Юнивишний үйлчилгээг нэвтрүүллээ. | 30 |
| 145 | 8.3.3 | Сум суурин болон алслагдсан багуудад үүрэн холбооны 3G, 4G сүлжээнд холбоно. | - | 3G, 4G технологи нэвтэрсэн сум, тосгон | 2020 | 17 | 20 | Мобиком болон Юнител групп 5G сүлжээ нэвтрүүллээ.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төгрөг сумын Хүрэн гол, Халиун сумын Чацран, Тонхил сумын Алтансоёмбо, Баян-Уул сумын Баянговь, Эрдэнэ сумын Цэцэг нуур, Хутаг уул, Есөнбулаг сумын Рашаант, Цогт сумын Баян-Өндөр багуудад үүрэн холбооны сүлжээ нэвтрүүлэх ажил хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Шарга сумын Хамтын хүч багт үүрэн холбооны сүлжээ нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа зарлагдсан. Шарга сумын Сондуулт, Улаантуг багт мобикомын сүлжээ орсон. | 90 |
| **Барилга, хот байгуулалт** | | | | | | | | | |
| **Зорилт 8.4. Аймаг, сумдын төвийн хот төлөвлөлтийг боловсронгүй болгож, хөгжүүлнэ** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 146 | 8.4.1 | Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шинэ суурьшлын бүсүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хот төлөвлөлтийг сайжруулна. | УТ-150,0 ОНХС-115.0 | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тоо | 2020 | 1 | 2 | Улсын төсвийн 150.0 сая төгрөгөөр Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлыг “Нью Урбанизм” ХХК-аар гүйцэтгүүлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 16 дугаар тогтоолоор Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг батлууллаа. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 115.0 сая төгрөгийн хөрөнгөөр Солонго хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг “Циркулл проект” ХХК гүйцэтгэж байна. | 90 |
| 147 | 8.4.2 | Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар боловсруулж, сумын төвийн хөгжил, газар зохион байгуулалтын ажлыг нэгдсэн төлөвлөлтөд оруулна. | ОНХС-65.6 сая | Хөгжлийн ерөнхий төлөв-лөгөөтэй сум, тоо | 2020 | 10 | 18 | Жаргалан сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 35.0 сая төгрөгөөр “Ланд овнер” ХХК гүйцэтгэж байна.<br>Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Есөнбулаг, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Шарга сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 576,9 сая төгрөгөөр “Вектор меп” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.<br>Чандмань сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 198.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр худалдан авах ажиллагааг зарласан. | 70 |
| 148 | 8.4.3 | Алтай хотын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах "Тайшир-Алтай" төслийн барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулна. | ТХ-14.0 сая $ | “Тайшир-Алтай” төслийн шугам сүлжээний урт, км | 2020 | 54.3 | 54.3 | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд “Тайшир-Алтай” усан хангамжийн төслийн ажлыг 14.0 сая долларын санхүүжилтээр Тайширын усан цахилгаан станцын Гэгээн нуураас Алтай хот хүртэл 54.8 км ган ширмэн хоолойгоор цэвэр усны шугам, хоёр өргөх насос станц, 2000 м3 усан сан, хоногт 172м3 ус цэвэршүүлэх хүчин чадал бүхий байгууламжийг ерөнхий гүйцэтгэгч “TRM” ХХК, туслан гүйцэтгэгчээр “Сайрам булган” ХХК 2019-2021 онуудад хэрэгжүүлэн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр байнгын ашиглалтад оруулж, Алтай хотын иргэд ундны цэвэр усаар хангагдлаа. | 100 |
| 149 | 8.4.4 | Алтай хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, төв магистраль шугамыг шинэчлэх, сумдын | УТ 17,732.4 | цэвэрлэх байгууламж-жийн хүчин чадал | 2020 | 2800 | 5000 | Алтай хотын 3000 м3 цэвэрлэх байгууламжийн ажлыг улсын төсвийн 17,732.385.644 төгрөгийн хөрөнгөөр “Сайн констракшн” ХХК, “Сан” ХХК-ийн түншлэл гүйцэтгэхээр гэрээ байгуулж, барилга угсралтын ажил эхлэсэн. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төвийг усан хангамж, ариутгах татуургын нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэж, бага оврын цэвэрлэх байгууламжтай болгоно. | УТ, ОНХС, ТХ 9,246.0 | Ариутгах татуургын шинэчилсэн шугамын урт | 20200 | 0.5 | 4 | Улс, орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөрийн нийт 8,600.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Алтай, Бигэр сумд 1.35км, Тонхил сумд 1.2км, Халиун сумд 1.7 км, Цогт 0.4км, Шарга сумд 1.1 км, Дэлгэр сумд 0.8км, Есөнбулаг сумын Харзат багт 1,79км, Индэрт багт 0.597 км, аймгийн төвд 0.58 ариутгах татуургын төв шугам сүлжээний ажлыг хийлгэж, ашиглалтад оруулсан.<br>Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2,150.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн төвийн 1.7 км ариутгах татуургын төв шугамыг шинэчлэх ажлыг “Техвейр” ХХК гүйцэтгэж, 459.6 сая төгрөгийн хөрөнгөөр Жаргалан сумын ариутгах татуургын шугамын ажлыг “Дулаан проект” ХХК тус тус гүйцэтгэж байна. | |
| | | | УТ,ОНХС-5,394.1 | Цэвэрлэх байгууламж-тай сум | 2020 | 1 | 17 | “Сумдын шинэчлэл-хөдөөгийн хөгжил” төсөл, арга хэмжээний хүрээнд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн 5,394.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 11 сумд цэвэрлэх байгууламжийн барилгыг барьж, ашиглалтад оруулсан. | |
| | | | УТ 2,130.1 | Ус хангамжийн шинэчилсэн шугамын урт | 2020 | 0 | 1.5 | Улсын төсвийн 2,130.1 сая төгрөгийн хөрөнгөөр Аймгийн төвийн 1,5 км цэвэр усны төв магистраль шугам сүлжээг шинэчлэн солих ажлыг “Өгөөмөр баян булаг” ХХК гүйцэтгүүлж, ашиглалтад орууллаа. | |
| 150 | 8.4.5 | Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжуудыг буулгаж, дахин төлөвлөлтөд оруулна. | УТ | Дахин төлөвлөлт оруулсан обьект | 2020 | 0 | 3 | Оргил багийн иргэний 6 айлын 2 блок орон сууцыг буулгаж үйлчилгээтэй 21 айлын орон сууцыг хувийн хөрөнгө оруулалтаар барилаа. Цэцэрлэг 5, сургууль 1, дотуур байрны 1, соёлын төв 3, спорт заал 2 нийт 12 обьектыг буулгаж шинээр барих дүгнэлтийг гаргаж, ажлын зураг төслийг боловсрууллаа. Улсын төсвийн хөрөнгөөр Дарив сумын спорт заалыг 1,711.1 сая төгрөгөөр "Бэст вүүдэн хаус" ХХК, Тонхил сумд спорт заалыг 359.9 сая төгрөгийг "Хүрийн овоо" ХХК, Халиун сумд шинээр соёлын төвийг 2,853.0 сая төгрөгөөр “Хонгор буурал” ХХК, Зооноз өвчин судлалын төвийн барилгыг буулгаж, барих ажлыг 4,378.2 сая төгрөгөөр “Сод энх констракшн” ХХК, хуучин Халдвартын эмнэлгийн барилгыг буулгаж, Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг шинээр барих ажлыг 4,580.0 сая төгрөгөөр “Зорь бүтээ” ХХК, Баян-Уул сумын 160 ортой, дотуур байрны барилгыг 3,409.5.0 сая төгрөгөөр “Эв-эе” ХХК, Есөнбулаг сумын | 100 |
| | | | | Дахин төлөвлөлт оруулсан орон сууцны тоо | 2020 | 0 | 8 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 6 дугаар цэцэрлэгийг буулгаж, барих ажлыг 4,319.3 сая төгрөгөөр “Жи Ти Кэй Эс” ХХК-ууд гүйцэтгэлээ.<br>Халиун сумын буудлын барилгыг буулгаж шинээр хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн барилга, Баян-Уул, Тайшир сумын ЗДТГ-ын барилгыг буулгаж Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийг ашиглалтад орууллаа. | |
| 151 | 8.4.6 | Гэр хорооллыг хэсэгчилэн дахин төлөвлөлтөд оруулж, инженерийн шугам сүлжээнд холбоно. | УТ-7,286.60 | Дахин төлөвлөлт оруулсан гэр хорооллын өрх, тоо | 2020 | 0 | 200 | Есөнбулаг сумын Харзат, Индэрт, Баянхайрхан багийн Гэр хорооллыг хэсэгчилэн дахин төлөвлөлтөд оруулж, инженерийн шугам сүлжээнд холбох зураг төслийг улсын төсвийн 110.0 сая төгрөгийн хөрөнгөөр “ДНТ” ХХК, Жаргалант багийн зураг төслийг орон нутгийн төсвийн 24.9 сая төгрөгийн санхүүжилтээр “Бюлдинг миррор” ХХК тус тус боловсруулж хүлээлгэн өглөө. Улсын төсвийн 4,255.0 сая төгрөгийн хөрөнгөөр Харзат багийн шугам сүлжээний ажлыг “Энержи плас инженеринг” ХХК гүйцэтгэж, ашиглалтад оруулаа.<br>Индэрт багийн шугам сүлжээний ажлыг улсын төсвийн 3031.6 сая төгрөгийн хөрөнгөөр "Вентана констракшн" ХХК гүйцэтгэж, дулаан хангамжийн шугамын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>Дээрх ажлын хүрээнд Харзат багийн 65 өрх, Индэртийн 42 өрх, нийт 107 өрх дахин төлөвлөлтөд хамрагдсан. | 50 |
| 152 | 8.4.7 | Сумын төвийн хүн амын ундны усны эх үүсвэрийг эрүүл ахуйн стандарт шаардлагад нийцүүлнэ. | ТХ 40.9 сая төгрөг | Стандарты н шаардлага хангасан ундны усны худгийн тоо | 2020 | 23 | 35 | НҮБ-ын Хүүхдийн сангийн Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийн 67.2 сая төгрөгийн санхүүжилтээр Цээл сумын шинэ суурьшлын бүс, Тонхил сумын төв худгийн автомат төхөөрөмж, иж бүрэн тохижилтыг хийж гүйцэтгэлээ. "Сэкер ресорсус Монголиа" ХХК-ийн санхүүжилтээр Чандмань сумын 10 уст цэгт ундны усны чанар хүртээмжийн судалгаа хийсэн. "Марко поло" ХХК, "Номин Эрдэнийн Өргөө" ХХК-ууд нийгмийн хариуцлагын хүрээнд Есөнбулаг, Бигэр сумдад унд ахуйн зориулалттай 4 худаг гаргаж малчдын ундны усны чанар хүртээмжийг сайжруулсан. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Харзат, Жаргалант багуудын 3 ундны усны худгийн нөөцийн савыг сольж, Түмэн, Баянхайрхан, Индэрт, Харзат багуудын 5 ундны усны худгийн гадна засвар үйлчилгээг хийж гүйцэтгэлээ. Баянхайрхан, Баяншанд, Харзат багт сумын орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн шугам сүлжээнээс алслагдсан суурьшлын бүсүүдэд стандартын шаардлага хангасан "Ус түгээх байр"-ны тоог нэмэгдүүллээ. Төгрөг сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажлыг “Таширын хүрээ” ХХК-аар | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гэрээ байгуулан гүйцэтгүүллээ. Тус ажлын хүрээнд 90-120 м гүнтэй газрын доорх усны хяналт шинжилгээний 4, ашиглалтын 2, нийт 6 цооног өрөмдөж нийлбэр дундаж 3 л/сек ундрагатай усны нөөц тогтоогдсон байна. | |
| | | | ТХ 14.0 сая доллар | Эрүүл ахуйн стандарты н шаардлага д нийцсэн цэвэр усны байгуулам -жийн тоо | 2020 | 1 | 1 | “Тайшир-Алтай” усан хангамжийн төслийн ажлыг 14.0 сая долларын санхүүжилтээр Тайширын усан цахилгаан станцын Гэгээн нуураас Алтай хот хүртэл 54.8 км ган ширмэн хоолойгоор цэвэр усны шугам, хоёр өргөх насос станц, 2000 м3 усан сан, хоногт 172м3 ус цэвэршүүлэх хүчин чадал бүхий байгууламжийг ерөнхий гүйцэтгэгч “TRM” ХХК, туслан гүйцэтгэгчээр “Сайрам булган” ХХК 2019-2021 онуудад хэрэгжүүлэн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр байнгын ашиглалтад оруулж, эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн цэвэр усны байгууламжтай боллоо. Алтай хотын төвийн 1.5 км цэвэр усны шугам сүлжээний шинэчлэлтийн ажлыг улсын төсвийн 2,130.0 сая төгрөгөөр “Өгөөмөр баян булаг” ХХК, Халиун сумын ундны усан хангамжийн дэд бүтцийн ажлыг улсын төсвийн 2463.0 сая төгрөгөөр “Жаргалант дулаан” ХХК-иуд тус тус гүйцэтгэж, байнгын ашиглалтад оруууллаа. | |
| 153 | 8.4.8 | Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх орчны нөлөөллийг бууруулах зорилгоор эмнэлэг, сургууль, цэцэрлэг, дотуур байр, /нүхэн жорлонтой/-ыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж-тай болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | ТХ-65.3 сая | Эмнэлгийн ариун цэврийн байгуулам-жийн тоо | 2020 | 8 | 19 | 2021-2022 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн Ус, орчны эрүүл ахуйн хөтөлбөрийн 289.7 сая төгрөгийн санхүүжилтээр Алтай сумын хилийн цэргийн 0214-р ангийн дэргэдэх цэцэрлэг, Бугат, Хөхморьт, Есөнбулаг сумын 1-р цэцэрлэгийн жишиг ариун цэврийн өрөө байгуулах ажил болон Хантайшир-Өргөө цэцэрлэг, 2-р сургуулийн ариун цэврийн байгууламжийн засварын ажил хийгдсэн. 2022 оноос эхлэн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 5,518.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл” 4 ээлжээр хэрэгжин сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ажил хийгдэж, Дарив, Дэлгэр, Халиун, Эрдэнэ сум, Гуулин тосгоны сургууль, дотуур байрны ариун цэврийн байгууламж, МСҮТ-ийн дотуур байр болон Есөнбулаг 8-р цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг бүрэн ашиглалтад оруулсан. Төсөл хөтөлбөрийн 29.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлгийн гэмтлийн тасгийн ариун цэврийн байгууламжийн засвар ажил хиигдсэн бөгөөд улсын төсвийн 12,864.5 сая төгрөгийн хөрөнгөөр Есөнбулаг, Алтай, Төгрөг сум, Баянтоорой тосгонд эмнэлгийн шинэ барилга баригдаж ашиглалтад орж, эрүүл ахуйн стандартын | 90 |
| | | | ТХ-1,352.3 | Цэцэрлэгий н ариун цэврийн байгуулам жийн тоо | 2020 | 8 | 19 | | |
| | | | ТХ-1,163.0 сая | Сургуулийн ариун цэврийн байгууламж ийн тоо | | 10 | 19 | | |
| | | | ТХ-1,029.8 сая | Дотуур байрны ариун цэврийн | 2020 | 13 | 19 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууламжийн тоо | | | | шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай эмнэлгийн тоо 5-аар нэмэгдсэн. Тайлант хугацаанд 9 сургууль, 13 цэцэрлэг, 7 дотуур байр, 5 эмнэлэг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болсон байна. | |

__o0o__